



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-84
<hr/>	
<i>1.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	11-12
<i>2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 8 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	12-17
<i>3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	17-40 55
<i>4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	40-56
<i>5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	56-78
<i>6.Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 30 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	78-84

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 54.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 13 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, С.Бямбацогт, С.Ганбаатар, Н.Ганибал, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Ц.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Д.Батлут, Э.Батиугар, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд;

Тасалсан: Х.Ганхуяг;

Хоцорсон: Б.Баярсайхан-1 цаг 24 минут, Г.Ганболд-18 минут, Г.Мөнхцэцэг-04 минут, Н.Учрал-1 цаг 14 минут, Л.Энх-Амгалан-09 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяшаа, Д.Ганбат нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяшаа, Д.Ганбат нар үг хэлэв.

Нэг.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 13

Бүгд: 42

69.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаан 10 цаг 30 минутад түр завсарлаж, 12 цаг 00 минутад эхлэв.

Хоёр.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 8 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Х.Болорчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ц.Цэрэнпунцаг нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	19
Бүгд:	42

54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, С.Одонтуяа, Ц.Туваан, Б.Жаргалмаа, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, 13 цаг 03 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ш.Адьяаа, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-г заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /14:48/

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ц.Туваан, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Б.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлын санал хураалтыг явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлын санал хураалтыг явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн зөвлөх С.Доржханд нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын

байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Ж.Сүхбаатар, Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Ганбат, Ш.Адьяа, Ж.Сүхбаатар, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /17:12/

Уг асуудлыг 17 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 30 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Хуралдаан даргалагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /17:33/

Уг асуудлыг 17 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 52 минут үргэлжилж, 72 гишүүнээс 46 гишүүн хүрэлцэн ирж, 63.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 11-ний
өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 13 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтгая. Ирц 54 хувьтай бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Гуравдугаарт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Дөрөвдүгээрт, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Юуны өмнө хоёрдугаарт санал хураалт үлдсэн хууль байгаа.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын

өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хэлэлцэх асуудлыг танилцуулсан. Ингээд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамгийн эхэнд хэлэлцэнэ. Энэ дээр 5 дахь өдөр хэлэлцээд зөвхөн санал хураалт үлдсэн байгаа. Асуулт, хариулт дууссан.

Үнэнбат даргаа энэ Дэг дээр яагаад үүнийг оруулаагүй байгаад байна? Хариуцлагагүй байна шүү дээ.

Нэгдүгээрт нь улс төрийн Одонтуяа гишүүний санаачилсан тэр хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэх тухай хуулийн төслийн эцсийн зөвхөн санал хураалт үлдсэн байгаа тэр асуудлыг эхэлж хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбандийн Адъяаа, Дашидондогийн Ганбат нараас албан бичиг ирүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг бол энэ ард иргэдийн үгийг төрд хүргэх үүрэгтэй. Энэ хүрээндээ манай баруун тойргийн 4 аймаг, 78 сум, 2 тосгонтой. Энэ бүх сум, тосгоноор явж ажиллаад, дуусгаад ирлээ. Ганцхан Өндөрхангай сум дээр зар нь тараагдаагүй, хүн цуглараагүй учраас

уулзалт хийгээгүй. Дараа нь уулзалт хийнэ.

Увс аймгийн Ховд сумын иргэн Ц.Пони гуай Монголын хөгжлийг доош нь татдаг хүмүүс бол хулгайч шүү. Тийм учраас сонсгол хийгээд орхичих вий энэ дээрээ дахиж хариуцлага тооцох ажлыг сайн хийгээрэй гэж байна.

Хоёрдугаарх нь Увс аймгийн Түргэн сумын багш Баярмаа тойргийн хүүхдийн тоогоор, өөрөөр хэлбэл сумын хүүхдийн тоогоор боловсролын санхүүжилтийг хийж өгөөч. Тэгэхгүй бол ойрхон сумын хүүхдүүд аймгийн төв рүү явж сураад байна гэж хэлж байна.

Увс аймгийн Малчин сумын Батсуурийн Цэнджаргал эрүүл мэндийн санхүүжилт 12 сарын 11-нээс хойш гүйцэтгэлийн санхүүжилт ерөөсөө орж ирээгүй. Сум аймагт өртэй, аймаг нь хотод өртэй ингээд бөөн сүлжээ өртөө болчихоод байна. Эрүүл мэндийн сайд анхаараарай гэж.

Увс аймгийн Наранбулаг сум Хужирт багийн Дагвын Лхамаа Зөрчлийн хууль харгис байна, машиндаа эхнэр 3 хүүхэд, ээжтэйгээ явахад нь торгодог. Хэнийг нь хасах юм гээд асуух дээр хариуцдаггүй ийм зүйл байгаад байна гэж.

Увс аймгийн Өлгий сумын Хөдөлмөр багийн Дагвын Басан малчдын хүүхдийг 3 сарын 1-нээс 4 сарын 1-ний хооронд амруулмаар байна. Ахлах ангийн хүүхдийг нийгмийн тустай хөдөлмөр эрхлүүлэх талаар бас анхаарч ажиллаач гэдэг ийм хүсэлтийг тавьж байна.

Ховд аймгийн Алтай сумын ахмад настан Баярхүү гуай Малчид их хөнгөлөлт авдаггүй. Тэрний нийгмийн даатгалын 50 хувийг хөнгөлөхөд хотынхон маш их янз янзаар ярьсан. Хотынхон өөрсдөө болохлоор 2 жилийн турш цахилгаанаа хөнгөлүүлсэн, хогийн мөнгөө хөнгөлүүлсэн, усны мөнгөө хөнгөлүүлсэн, автобусны мөнгө байнга

хөнгөлдөг, хотынхон өөрсдөө хамаг хөнгөлөлтийг бүгдийг нь хамдаг мөртөө хөдөөгийнхнийг ингэдэг тэгдэг гэж ярьдгаа боль. Ер нь тэр малчдын зээлийг тэглэх талаар тэр Их Хурлын гишүүддээ хэлж шийдүүлж өгөөрэй гэж хүсэж байна.

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баянхонгор багийн Т.Чулуунбат гуай Тэнгэрийн зуд арилдаг, төрийн зудаа арилгаж өгөөч. Энэ Монгол ардын намынхан арай хэтэрч байна гэдэг ийм зүйлийг ярьж байна.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Содномжамц гуай чоно улаан номд оруулсан юм уу хаашаа юм. Чоно ихэдсэн, алахаа больсон. Алахаар торгодог. 1 сая төгрөгөөр тэр байгаль орчны үнэлгээний дагуу торгодог ийм зүйл гараад байна. Чоно мал идээд байх юм. Зудад хэцүү байна. Дээрээс нь мал тэр туйлдсан малыг сэглээд сэглээд явчихна. Энд чоныгоо ялангуяа тэр талын болон говийн чоноо хамгаалж болно. Хурдан буутай, хурдан машинтай хүмүүс алаад байдаг байх энэ уулын чоно чинь хэрээс хэтэрлээ. Үүнийгээ шийдвэрлэж өгөөч гэдэг ийм хүсэлтийг тавьж байна.

Хөдөөгүүр явж байхад олон иргэд янз янзын хулгай гарч байна, энэ хулгайныхаа асуудал дээр хариуцлага тооцоод тэр 2024 оны сонгуульдаа илүү шударга янз янзын асуудалгүй тэр хүмүүсийг дэвшүүлэх талаар бүх нам анхаарахгүй бол энэ тал дээр маш том хариуцлага хүлээлгэх болно шүү гэдгийг бас анхааруулж хэлж байна гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

Ш.Адьшаа: Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурал, Монголын төр өнөөдөр ард иргэдийнхээ хүнсний хангамж, ард иргэдийнхээ хямд төсөр хүнсээр хангах

асуудал бол төрийн үүрэг байх ёстой. Энэ үүргээ бид биелүүлэх ёстой.

23 оны 12 сараас эхэлж энэ гурил, тэжээлийн импортын гаалийн татварыг тэглэх тухай асуудлыг Засгийн газрын түвшинд, Улсын Их Хурлын түвшинд ярьсаар байгаад өнөөдөр 4 сар, 5 сар боллоо. Энэ ямар зорилго энэ цаана нь явагдаад байна? Энэ гурилын импортын гаалийн татварыг тэглэж, ард иргэдээ хямд гурилаар хангах, малчдаа хямд тэжээлээр хангах гэхээр энд том бүлэглэлийн эрх ашиг энэ Улсын Их Хурал дээр, энэ Засгийн газрын түвшинд орж ирж, энэ монголчуудынхаа эрх ашгийн эсрэг ийм бүлэглэл өнөөдөр энэ Монголын төрийг эзэлсэн энэ асуудлаа хэзээ бид дүгнэлт хийх юм бэ? Хэзээ дүгнэлт хийх юм? Монголын банк, санхүүгийн байгууллага гээд өнөөдөр монголынхоо ард иргэдийг банкны хүүгээр сорон мөлждөг, гаднын банк, санхүүгийн байгууллагыг оруулж ирэх гэхээр үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэг ийм хориг, тээг ярьж өнөөдөр монголчуудаа сөхрүүлдэг ийм системийг бид өнөөдөр ярьсаар байгаад дийлэхгүй монголын төр үүний өмнө сөхөрч байгаа.

Гэтэл өнөөдөр хямд үнэтэй гурил оруулж ирье гэхээр үндэсний аюулгүй байдлын асуудал, дотоодын үйлдвэрлэгчдийг сөхрүүлэх гэж байна гэдэг ийм худал хуурмаг зүйл тарааж нам дамжсан ийм бүлэглэлүүдийн эрх ашгийг хангаж байна. Өнөөдөр гадаадын зах зээлээс хямд үнэтэй гурил, гурилан бүтээгдэхүүн, өвс тэжээл оруулж ирэхээр Оросын аюул гэдэг ийм юм ярьж байна. Энэ юу гэсэн үг юм бэ? Өнөөдөр Монгол Улсын ард иргэд хямд үнэтэй гурил, хүнсний зүйл хангах асуудал хамгийн тэргүүнд байх ёстой. Энд монголын төр шийдвэр гаргах ёстой. Ингээд өнөөдөр энэ асуудлыг ярихаар улс төржиж байгаа ч юм шиг, бүлэглэлийнхээ эрх ашгийг хамгаалж байгаа ч юм шиг энэ байдлаар гацаасаар байгаад энэ Улсын Их Хурал, энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусах нь.

Энэ асуудлаа өнөөдөр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хэмжээнд авч ирж, хямд үнэтэй гурил тэжээлээр хангах энэ асуудлаа бодлогоо, шийдлээ гаргаач ээ эрх баригчид аа. Ингэж муур, хулгана болж тоглохоо больё. Өнөөдөр Монгол Улсын иргэн.../минут дуусав./

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар олон чухал асуудал хэлэлцэх гэж байна. Гэхдээ сүүлийн үед энэ асуудлууд маш их бөөгнөрч байна. Ярьж, хэлэлцэх асуудлууд олон байна. Чухал чухал асуудлууд. Байнгын хороодын ирц чинь ч хүрэхгүй байх шиг байна. Ер нь сонгогдохын төлөө л их яараад байх юм. Хүний тойргоор ч гэсэн өлөн зэлмэн царайлаад л явах юм зарим нь. Үгүй нээрээ зарим нь босоо хөх..., хэвтээ цэврүүд гээд л баахан юм дагуулаад л. Яах вэ Архангай, Өвөрхангай, Өвөрхангай, манай аавын нутаг л даа. Сайхан зун болох байх. Сааль сүү, сав тараадаг Ганбат гишүүн ирээсэй л гэж байгаа байх. Тийм олон мянган оюутанд тараадаг. Тэртээ тэргүй сонголт хийчихдэг юм. Энэ дээр хоёр чухал л асуудал байна. Нэн тэргүүнд ярилцах ёстой.

Нэгдүгээр асуудал бол нийгмийг маш их талцуулж байгаа энэ манай ардчиллын бэлгэ тэмдэг болсон удирдагч манай Зоригийн асуудал байна. Сонгууль болгоны өмнө гарч ирдэг.

Хоёрдугаарт, би энэ хүүхдийн хүчирхийллийн асуудлыг ярих гэж байна. Эхний асуудал манай 26 жил өнгөрчээ талийгаач болоод. Гэтэл алга дарам хөшөөний газар ч өгөхгүй гэж байх шиг байна шүү дээ. Энэ Зоригийн хэргийг тэр ар гэр нь ч хүсдэг юм байна лээ. Тэр нууцаас гаргах нь зөв байх. Тэгээд болохгүй бол олон улсын гаднын мөрдөн

байцаагч нарыг дуудаж авчирч ажиллуулахгүй л бол энэ хэргийг нэг цагдаагийн дарга гарч ирээд л, Монгол ардын нам ялаад, би ялбал энэ хэрэг илэрнэ гэсэн байхгүй. Хэчнээн ч ялдаг юм нам нь.

Дараа нь би төр нийгмийн нэрт зүтгэлтэн Батхүү агсныг хэлэх гээд байна. Энэ парламентын дэд дарга байсан хүн. Энэ ордонд учир битүүлэг байдлаар амь үрэгдсэн. Хэн тэр хүнийг тангаргийн буга гэдэг байлаа, хэн тийм нэвтрүүлэг явуулдаг байлаа? Энэ асуудлыг бас гадна, дотнын мөрдөн байцаагч нарыг урьж авчраад ажиллуулах цаг болсон. Тэгэхгүй бол дараа дараагийн гэмт хэргүүд ямар ч байдлаар үйлдэгдэх ийм магадлал бас маш их өндөр байна.

Тийм учраас энэ парламент гэж байдаг юм бол, парламентын засаглалтай юм байна, ер нь хамгийн том хулгайч нарыг энэ Монгол ардын нам, Монгол ардын намын удирдлага ивээлдээ авдаг. Тэгээд хамгийн том хулгайчтай, хамгийн том гэмт хэрэгтэй, авлигатай тэмцэхгүй байгаа улсууд тэр дотроо байгаа өөрсдийнх нь жижиг, дунд авлигын би тэр хэмжээгээр нь ярьж байна. Тэд нартай тэмцэхээр нөгөөдүүл нь хэлж байна шүү дээ. Ийм байдалтай байгаа юм. Хэдэн арав, арван таваараа авлигад орооцолдсон. Тэгээд одоо байж байдаг. 40 саяар л торгуулиа гаргадаг. Шүүх, хууль хяналтын байгууллагууд нь бүгд дохио зангаагаар ажилладаг болчихсон ийм байдалтай байгаа юм.

Нөгөө талаар би энэ хүүхдэд ээлгүй засаг төр байна. Ямар ч хатуу, харанхуй засаг юм бэ дээ. 2017 онд бага насны хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэхийг нь бараг өгшүүлсэн хууль баталсан. Хуучин 16 настай байдаг, 18 настай байдаг байсан ийм гэмт хэргийн нөхцөл байдлыг 14 нас болгосон. Гэтэл яаж байна? Энэ 12 настай, 13 настай хүүхдүүдийг хүчирхийлдэг, амь насыг нь бүрэлгэдэг ийм зүйлүүд удаа дараа

гарсан. Саяхан бүүр өөрийгөө хамгаалах чадваргүй тэрийг нь хамгаалж өгөх ёстой энэ засаг төрийн төлөөлөл болсон цагдаагийн 4 албан хаагч хүчирхийлэл үйлдлээ. Бүтэн жил хүчирхийлэл үйлдсэн гэж хэвлэл мэдээллээр ярьж байна. Үгүй энэ чинь та нарын үр хүүхдүүдийг ингэвэл яах юм? Та нар яасан хөндий, хүйтэн, муухай сэтгэлтэй улсууд вэ? Ийм хөндий, муухай Их Хурлын гишүүд, ийм парламентын засаглал, ийм засаг төр байж болохгүй.

Өчигдөр л гэхэд Засгийн газрын хурал хийлээ. Энэ хурлаасаа ямар нэгэн шийдвэр гаргах юм болов уу? Бүрэн бүрэлдэхүүнээр огцрох ийм шийдвэр гаргавал энэ гэмт хэргүүд дахиад гарахгүй. Энэ ард иргэдийн эсрэг.../минут дуусав./

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллын өөрчлөх, асуудал нэмэхтэй холбоотойгоор ийм санал алга байна. Энэ ажлын хэсгүүд ажлаа шуурхайлах хэрэгтэй. Байнгын хороо шуурхай ажиллах хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хариуцлагатай ажиллах хэрэгтэй байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд суугаарай, тэр гадаа байгаа гишүүд ороорой. Санал хураалт.

Санал хураалт 69 хувийн саналаар хэлэлцэх эсэхийг дэмжлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

10.30 цаг

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороо хуралдана. Төрийн ордны хурлын танхимуудад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан багш нарын Их Хурал болж байгаа учраас Их Хурлын салбар хуралдаанууд болж байгаа учраас чуулганы танхимын боломж хязгаарлагдмал нэгхэн танхимд хуралдаж байгаа. Ийм учраас бас хоёр Байнгын хороо хуралдах ийм шаардлагатай бас.

Ингээд гишүүдийн хоёр Байнгын хорооны хурлыг яаравчилъя. Ингээд хоёр Байнгын хороо хуралдах хугацаанд 1 цагийн хугацаатай чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулж байна.

10.30 цаг

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлж хуралдуулна.

12.00 цаг

Сая Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хуралдаж дууссан. Төрийн байгуулалтын байнгын хороо дөнгөж сая хуралдаж дууссан. Гурав, дөрвөн асуудал хэлэлцэнэ. Тэгээд хууль санаачлагч нь байхгүй байгаа учраас бас энэ Төрийн

байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтээ боловсруулах хугацаатай учраас тавд байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг шууд хэлэлцэж болж байна.

Төсвийн байнгын хороо хуралдаагүй байна. Гишүүд чуулганы танхимд хуралдъя. Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад болчихсон. Санал, дүгнэлт болчихсон юм уу? Энэ чинь хамтдаа явна л даа. Эднийх чинь нэг эхлэхээрээ дөрөв, таван асуудал. Хууль санаачлагч байх учраас. Тийм учраас хууль санаачлагчид байхгүй байна. Тийм учраас дараагийн асуудалд орёе.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Энэ хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан. Горимын санал дэмжигдсэн. Гишүүд чуулганы танхимд цуглая. Хууль санаачлагчийн илтгэлийг буюу Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн. Байж байгаарай. Одоохон Эдийн засгийн байнгын хороо их шуурхай байна. Өглөө саатсан болохоор.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын гишүүдээс 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг нарын гишүүдээс 2024 оны 4 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг бол дэмжиж байгаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хамгийн гол суусан зүйл бол газрыг 100 жил эзэмшүүлэх асуудлыг өөрчлөх ийм гол заалт гэж ойлгож байгаа. Үүнтэй холбоотойгоор бас Хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, мөн хяналт шалгалтын ажлыг явуулах тухай ийм бас Улсын Их Хурлын тогтоол өргөн баригдсан. Ийм учраас Хөрөнгө оруулалт оруулалтын хуулийн энэ төсөл өмнө Засгийн газраас өргөн баригдсан төслөөс юугаараа ялгаатай юм? Энэ талаар тайлбар өгөөч.

Г.Занданшатар: Эдийн засгийн байнгын хороо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, ажлын хэсэг хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Засгийн газраас өргөн барьсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд газартай холбоотой бас нэг заалт байсан. Энэ заалт гадаадын иргэнд газрыг 60 жилээр ашиглуулах, тэгээд үүнийгээ бол цаашаагаа 40 жилээр сунгана гэсэн ийм заалт байсан шүү дээ. Энэ заалт маань, мэдээж бид нар өөрсдийнхөө хүрээнд бол жишээ нь дотооддоо аж ахуйн нэгжүүдээ бол 15 жилээр дээд тал нь бол бас 40, 50 жилээр эд нар сунгаад явж байгаа. Тэгэхээр энэ заалт бол нэлээд энэ чинь бүхэл бүтэн гадаадын иргэнд бол бүх нэг насаар нь шахуу, 100 жилээр олгохоор ийм заалт болчхоод байгаа шүү дээ. Энэ бол ард иргэдийн нэлээн эгдүүцлийг их хүргэсэн ийм заалт болчхоод байгаа. Тийм болохоор Цэрэнпунцаг гишүүн болон бусад гишүүд санаачлаад энэ заалтыг ерөнхийд нь хасаж байгаа юм.

Тэгээд жишээ нь, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн газрын тухай гэснийг хассугай гэж байгаа юм.

2 дугаар зүйл бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай гэсэн ийм заалт оруулж ирж байгаа юм.

Г.Занданшатар: Болорчулуун гишүүн нэрээ өгчихсөн юм байна тээ? Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлтээр бас оруулж ирж байна. Энэ дээр газрын асуудлыг нь тэр газрын хугацааг богиносгож, 15-30 жилээр олгох энэ тэр асуудал тийм байдлаар оруулж ирж байх шиг байна. 1 удаа сунгахаар. Тэр хөрөнгө оруулалтын босгон дээр ямар санал бодолтой энэ хууль дээр чинь тусгагдсан юм бэ? Ер нь хамгийн гол нь улс орнууд босгыг тавьж өгдөг шүү дээ. Хэрэв босго тавихгүй бол хөрөнгө оруулалт биш байхгүй юу. Хүн оруулах, цагаачлал оруулах л хууль болчихно шүү дээ. Энэ хуучин өргөн барьсан хууль дээр чинь бол босохгүй болоод байнга оршин суух эрх эдэлж байгаагаараа аюултай байхгүй юу. Ийм л учраас гишүүд, мөн ард иргэд эсэргүүцээд байгаа юм. Энэ тал дээр бас тодруулж хэлж өгөөч.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн Эдийн засгийн байнгын хороо хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Болорчулуун гишүүний асууж байгаа асуулт бол үндсэн Хөрөнгө оруулалтын хуультай холбоотой асуудлууд асууж байх шиг байна. Тэгэхээр өнөөдрийн орж ирж байгаа хууль маань бол Цэрэнпунцаг гишүүний өргөн барьсан, санаачилсан. Энэ хууль бол Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл юм байгаа юм. Өргөн барьсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах.

Тэгэхээр энэ өөрчлөлтөд нөгөө заалтуудаа бид нар хасаж байгаа байхгүй юу. Газартай холбоотой заалтууд, өөрөөр хэлбэл, нөгөө 100 жилээр олгоно гэж байгаа энэ заалтаа л бид нар хасаад байгаа шүү дээ. Олон гишүүд бол 100 жилтэй санал нэгдэхгүй байгаа шүү дээ. Миний түрүүний хэлсэнчлэн дотоодын аж ахуйн нэгжүүддээ бид нар жишээ нь, газар тариалантай холбоотой аж ахуйн нэгжүүд байж байна. Миний мэдэхээр манай нутагт 15 жилээр л сунгаад байгаа шүү дээ. Сунгаад байгаа орон нутагт нь.

Тэгэхээр энэ 100 жилтэй холбоотой заалтыг л ерөөсөө л болиулж байгаа байхгүй юу даа. Сая тэгээд би хэллээ энэ чинь 2 заалттай ийм хууль орж ирж байгаа. 1 дүгээр заалт бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн газрын тухай гэснийг бол хасаж байгаа юм. Тэгээд 2 дугаар заалт нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай гэж байгаа юм.

Засгийн газраас барьсан Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр байгаа тэр босготой холбоотой асуудлуудыг бас үзэж харах ёстой л асуудал байгаад байгаа юм. Урьд өмнө бол 100 мянган доллар гэж байсан байх аа? Тийм, тэгэхээр одоо бол ерөнхийдөө хөрөнгө оруулагчдыг бас жоохон нээлттэй байлгах гэдэг утгаараа угаасаа тэр 100 мянган доллар гэдэг чинь угаасаа л бас л хөрөнгө оруулагчдын хувьд бол, тэр тусмаа стратегийн том салбарууд руу орж байгаа хөрөнгө оруулалтын хувьд бол 100 мянга гэдэг чинь бол асар бага мөнгө шүү дээ. 100 мянган доллар гэдэг. Тэгэхээр Засгийн газраас орж ирж байгаа санаанууд бол нэлээн өргөн байдлаар хаалгаа бас нэлээн нээе. Мэдээж хөрөнгө оруулалт бол Монгол Улсын эдийн засагт бол ач холбогдол бол өгнө. Тэр утгаараа бол бас босгыг нь авсан юм байна лээ. Энэ хэрэгжүүлэх

явцад ажлын хэсэг дээр яриад явчих бололцоотой л гэж хараад байгаа юм. Тэгэхээр хэлэлцүүлэх явцад энэ асуудлаа бол яриад явах нь ийм боломжтой гэж үзэж байгаа юм. Таны асуусан асуулт бол энэ Үндсэн хөрөнгө оруулалтын хуультай холбоотой асуудал байна.

Г.Занданишатар: Цэрэнпунцаг гишүүн нэмж хариулах уу? Гишүүд чуулганы танхимд цуглаарай санал хураалт явуулах гэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Болорчулуун гишүүний асуултад нэмээд хариулчихъя. Энэ Засгийн газраас өргөн барьсан төсөл, энэ миний оруулж байгаа шинэчилсэн, өөрчлөлт оруулж байгаа хоёр бол Засгийн газраас өргөн барьсан төсөл бол бүүр үндсэндээ шинэчилсэн ийм найруулга хийгдсэн ийм төсөл байгаа юм.

Энэ өөрчлөлт орох гэж байгаа хууль бол 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр байгаа газрын зүйл, заалттай холбоотой нэг зүйл, заалтыг л хасаж байгаа ийм төсөл. Гол ялгаа тэндээ байгаа юм шүү. Ер нь гол энэ хуулийг санаачлах болсон гол шалтгаан бол энэ Хөрөнгө оруулалтын хуулийг Үндсэн хууль болон Газрын тухай хуультай нийцүүлж байгаа. Хууль хоорондын зөрчлийг арилгаж байгаа л хамгийн гол ач холбогдолтой юм байгаа юм.

Г.Занданишатар: Энэ Болорчулуун гишүүн ээ таны асуусан тэр 100 мянган доллар бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөрөнгө оруулалтын хуульд хэвээрээ байж байгаа. Тэрийг авах гэсэн Хөрөнгө оруулалтын хуулийн төсөл бол хэлэлцэгдээгүй, хэлэлцэхээргүй ишидвэрлэгдэн хойшлогдсон.

Тэгэхээр бол одоо байгаа хүчин төгөлдөр хуулийнхаа хүрээнд л ярилцана. Айн? Харин одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд буюу 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай

хуульд байгаа хөрөнгө оруулалтын бус дэмжлэг гэсэн хэсэгт газрыг хөрөнгө оруулагчдад 100 жил хүртэл ашиглуулна гэсэн энэ хэрэгждээгүй заалтыг хасах, хүчингүй болгох тухай хуулийн төслийг хэлэлцээд анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг Байнгын хороо гаргасан. Энэ санал чинь юутай бас зарим гишүүд асууж байсан. Энэ хөрөнгө оруулалтын бус дэмжлэг, хөрөнгө оруулалтын санхүүгийн бус дэмжлэг гэсэн энэ хэсгийг 2013 онд ажлын хэсгээс нэмж оруулахдаа бөөнд нь санал хураагаад, зохицуулалтгүй Газрын тухай хуультайгаа зөрчилтэй санал хураагдчихсан юм байна лээ. Газрын тухай хуульд бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуулийн 44.2-т байх аа ер нь газрыг гадаадын иргэн, хуулийн этгээдүүд тодорхой болзол, нөхцөл, журамтайгаар ашиглуулна, түүний журмыг Засгийн газар батална, хугацааг Засгийн газар тогтооно гээд зохицуулагдчихсан харилцаатай. Тийм учраас үүгээр харилцаа зохицуулагдахгүй, алга болохгүй.

Хоёрдугаарт нь энэ заалтад чинь Засгийн газрын бүрэн эрхийг Газрын тухай хуулиар зохицуулж байгаа. Засгийн газраас өгсөн саналаар бол ерөөсөө Газрын тухай хуулиараа л зохицуулагдах болохоос биш энэ салбар хуулиудаар Газрын тухай хуулийг ингэж сэглэж зэрмэглэхээ больё, Газрын тухай хуулиараа хэлэлцье гэсэн ийм саналыг өгсөн. Тэгээд энэ хуулийн төсөл өргөн баригдсан байна.

Санал хураалтад бэлдье. Гишүүд 4, 7, 8. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Улсын Их Хурлын гишүүдийн бүртгэлийг явуулна. Амгалангийн Адьяасүрэн гишүүн алга байна, тас. Ширнэнбаньдын Адьяаа гишүүн өглөө байсан. Одоо алга байна. Чуулганы танхимд ирнэ үү. Норовын Алтанхуяг гишүүн өглөө байсан. 9.59 дээр

бүртгүүлсэн байна. Тэгэхдээ одоо алга байна. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн сайд? Алга байна, тас. Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн байна, чуулганы танхимд байна. Цогт-Очирын Анандбазар гишүүн? Тас. Пүрэв-Очирын Анужин гишүүн 9.48-д бүртгүүлсэн. Одоо алга байна. Чуулган танхимд цуглая. Тилеуханы Аубакир гишүүн 10 цаг 05 минутад ирсэн чуулганы танхимд алга байна. Ирье. Хавдисламын Баделхан гишүүн 10 цагт өглөө бүртгүүлсэн. Одоо чуулганы танхимд байна. Сайн байна. Энхтайваны Бат-Амгалан 10 цаг 5 минутад бүртгүүлсэн. Одоо алга байна. Чуулганы танхимд ирье. Сүхбаатарын Батболд? Тас. Жигжидийн Батжаргал 9.58-д ирсэн, өглөө бүртгүүлсэн. Одоо алга байна. Чуулганы танхимд ирье. Дамбын Батлут? Тас. Энэ нөхөр хаагуур яваад байна? Жамбын Батсуурь? Тас. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ 9.40-д бүртгүүлсэн байна. Одоо алга байна. Жадамбын Бат-Эрдэнэ танхимд байна. Балжиннямын Баярсайхан? Тас. Буланы Бейсен гишүүн 10 цаг 9 минутад бүртгүүлсэн. Одоо алга байна. Чуулганы танхимд ирье. Болорчулуун гишүүн байна. Хүрэлбаатарын Булгантуяа? Жамбалын Ганбаатар сайд өглөө 10 цагт бүртгүүлсэн. Одоо танхимд алга байна. Ирье. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн? Тас. Дашдондогийн Ганбат гишүүн 10 цаг 02 минутад бүртгүүлсэн. Одоо алга байна. Чуулганы танхимд ирье. Гочоогийн Ганболд гишүүн? Наянтайн Ганибал гишүүн? Тас. Хассуурийн Ганхуяг гишүүн? Тас. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн чөлөөтэй, Гонгорын Дамдинням гишүүн орон нутагт томилоттой, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн? Тас. Болдын Жавхлан? Тас. Бадарчийн Жаргалмаа байна. Сайн байна. Цагаанхүүгийн Идэрбат? Таны нэр болоогүй байна. Дээрээс явж байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн өглөө ирсэн байна. Алга байна, дуудъя. Лхагвын Мөнхбаатар? Гомтилдоогийн Мөнхцэцэг өглөө 10 цагт бүртгүүлсэн. Одоо алга байна. Танхимд ирье. Цэрэнжамцын Мөнхцэцэг? Тас. Тас

гэж энэ дотор чөлөөтэй, алга байна. Нанзадын Наранбаатар? Байна. Салдангийн Одонтуяа байна. Мөнхөөгийн Оюунчимэг 11.40-д бүртгүүлсэн. Одоо алга байна. Дуудъя. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн байна. Өглөө 10 цагт бүртгүүлсэн. Одоо байна. Сайн байна. Өнөрболор? Тас. Пүрэвдорж 9.52-т бүртгүүлсэн байна. Одоо байна. Сайн байна. Сандаг-Очир 9.55-д бүртгүүлсэн. Одоо байна. Сайн байна. Батсүхийн Саранчимэг гишүүн өглөө 10 цаг 7 минутад бүртгүүлсэн. Алга байна. Чуулганы танхимд. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн 9.58-д бүртгүүлсэн. Одоо байна. Сайн байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүн 9.59-д бүртгүүлсэн. Түүрүүн байсан хаачсан? Сэргэлэн гишүүнийг дуудъя. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн 9.58-д бүртгүүлсэн, ирсэн байна. Сайн байна. Цэвэгдоржийн, 8.55-аар бүртгэгдэжээ. Цэвэгдоржийн Туваан 9.54-д ирсэн. Одоо байна. Сайн байна. Ганзоригийн Тэмүүлэн 10 цагт ирсэн байна. Сайн байна. Чинбатын Ундрам 9 цаг 09-д бүртгүүлсэн. Одоо алга байна. Ундрам гишүүн. Учрал гишүүн 11.21-д бүртгүүлсэн алга байна. Тогтохсүрэн дарга 8.55-д ирсэн. Сайн байна. Чимэдийн Хүрэлбаатар? Тас. Одонгийн Цогтгэрэл? Тас. Цэрэнпунцаг 9.44-д ирсэн. Одоо байна. Сайн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн? Чинбүрэн гишүүн алга байна. Өглөө 10.14-д ирсэн, бүртгүүлсэн. Одоо алга байна. Содномын Чинзориг 9.57-д бүртгүүлсэн. Одоо алга байна. Чуулган танхимд ирье. Б.Чойжилсүрэн, Баттогтохын Чойжилсүрэн 10.06-д бүртгүүлсэн. Одоо алга байна. Дуудъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан 9.28-д ирсэн байна. Сайн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан 10.22, сайн байна. Нямаагийн Энхболд 9.04-д ирсэн. Одоо байна. Сайн байна. Төмөртөгоогийн Энхтүвшин 9.51-д ирсэн. Сая байсан байна. Жаргалтулгын Эрдэнэбат 9.59-д бүртгүүлсэн. Одоо алга байна. Орж ирье.

Санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа сууцгаая. Пүрэвдорж гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Эсрэг санал өгсөн хүмүүсийг ард түмэн газар шорооны эсрэг гэж зарла гэсэн юм. Тэр нь аяндаа л гараад л ирнэ л дээ. Тэр чинь нээлттэй юм чинь. Гишүүд суудалдаа сууцгаая. Бүртгэлийн санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалт. Энхтүвшин гишүүн байсан яачхав? Энхтүвшин, Чинбүрэн гишүүн хоёрыг дуудаач. Адьшаа гишүүн байсан. Яачхав? Бейсен, Ж.Ганбаатар?

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Адьшаа Анужин, Алтанхуяг, Бат-Амгалан, Аубакир, Бейсен, Булгантуяа, Ж.Ганбаатар, Оюунчимэг, Саранчимэг, Цэдэвийн Сэргэлэн, Ч.Ундрэм, Чинбүрэн, Учрал, Чинзориг, Чойжилсүрэн, Нямаагийн Энхболд, Энхтүвшин, Эрдэнэбат нар сөрөг өгч байна шүү. Санал хураалт явуулъя.

Байнгын хороо Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Сая 22 гишүүн дэмжиж, 51.2 хувийн саналаар санал дэмжигдсэн.

54.8 хувиар санал дэмжигдсэн.

Энэ хуучин санал гараад байна шүү дээ. Яагаад шинэ санал нь гарч ирэхгүй байна? 54.8 санал гаргасан. Ингээд Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ. Эдийн засгийн байнгын хороо эцэслэн батлуулна. Дараагийн асуултад орно. Бэлэн болсон байх гэж бодож байна.

12.25 цаг

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Сая зарлачихсан. Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн.

Н.Энхболд: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нараас 2024 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Уг хуулийн төслийг шинэчилсэн найруулах болсон үндэслэл болон хуулийн төсөлд тусгагдсан онцлог зохицуулалтаас та бүхэнд товч танилцуулъя.

Улсын Их Хурлаас 2023 оны 5 сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж өөрчлөн найруулсан.

Улсын Их Хурлын 23 оны 44 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд

оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 6-д Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд дээрх өөрчлөлттэй нийцүүлэхээр заасан байгаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зохицуулалтыг тодорхой болгох, нарийвчлах, нэр томъёог, Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэх, жигдлэх практик хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн болно.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдал, түүний баталгаа, Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон харилцаануудыг тусгасан.

Хуулийн төсөл 8 бүлэг, 53 зүйлтэй. Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг шинээр буюу шинэчлэн боловсруулж тусгалаа.

1. Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох хүрээнд Байнгын болон бусад хороодын талаар

Улсын Их Хурлын үндсэн бүтцийг тодорхойлохдоо бүрэн эрхээ шинээр эхлүүлж байгаа Улсын Их Хурал бодлогоо тодорхойлж байх чиг хандлагыг харгалзан Улсын Их Хуралд зайлшгүй байх бүтцийг оновчтой, давхардалгүй байх зарчимд нийцүүлэн санал болгож тодорхойлсон.

Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байхаар төсөлд тусгалаа. Үүнд:

Үйлдвэржилтийн бодлогын, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 11 Байнгын хороотой байхаар.

Байнгын хорооны бүрэлдэхүүний тухайд нэг байнгын хороонд 25 хүртэл гишүүнтэй байхаар тооцож, ингэхдээ нэг гишүүн 2-оос илүүгүй Байнгын хороонд харьяалагдахаар тусгалаа.

Байнгын хорооны гишүүнчлэлд тодорхой хязгаарлалтыг тогтоохоор хуулийн төсөлд оруулж тухайлбал, Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн зөвхөн 1 Байнгын хороонд харьяалагдахаар, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүний хувьд эрхлэх асуудал нь хамаарах салбарын Байнгын хороонд харьяалагдахгүй байхаар төсөлд тусгалаа. Мөн нэг Байнгын хороонд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн 2-оос илүүгүй байхаар, Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Байнгын, Дэд, Хянан шалгах түр хорооны даргаар ажиллахгүй байх зохицуулалтуудыг тусгасан болно.

Байнгын хорооны харьяанд түүний эрх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий Дэд хороо байгуулж болох бөгөөд Дэд хорооны гол үүрэг нь хяналт шалгалтын ажил байхаар төсөлд тусгав. Тусгай хяналтын, Төсвийн зарлагын хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Хүний эрхийн, Тогтвортой

хөгжлийн дэд хороог хуулиар байгуулахаар, бусад Дэд хороог Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, байгуулж байхаар төсөлд тусгалаа.

Хянан шалгах түр хорооны зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд түр хороог байгуулах хугацаа, байгуулж болохгүй нөхцөл, хорооны төсөв зэрэг харилцааг хуулийн төслөөр шинээр зохицуулсан. Жишээ нь, Хянан шалгах түр хороог дараах тохиолдолд байгуулахгүй байх нь зүйтэй гэж үзэж төсөлд тусгасан. Үүнд:

Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусахад 6 сараас бага хугацаа үлдсэн болон тухайн асуудлаар Хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар, татан буугдсанд тооцоноос хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй бол тухайн сэдвээр.

Улсын Их Хурал дахь нам эвслийн бүлгийн талаар.

Нам, эвслийн бүлэг байгуулж болох гишүүдийн тоо 8 байгааг Улсын Их Хурлын бүрэлдэхүүний тоо нэмэгдсэнтэй холбогдуулан 12 ба түүнээс дээш болгож шинэчиллээ.

Нам, эвслийн бүлэг байгуулах, тарах, гишүүн өөр бүлэгт нэгдэх, гарах, Засгийн газар байгуулах бүлэгт байгуулах зэрэг харилцааг нарийвчлан зохицуулснаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага тогтвортой, бүтээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн сахилга батыг сайжруулах, хууль тогтоох ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор нам, эвслийн бүлэг хууль тогтоомжийн төсөлд санал, дүгнэлт заавал гаргаж байх. Нэгдсэн хуралдаанд нам, эвслийн бүлгийн байр

суурийг тодорхой тооны гишүүд төлөөлөн илэрхийлж байх. Нам, эвслийн бүлгийн саналаар хууль тогтоомжийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулж байх зэрэг шинэ зохицуулалтыг төсөлд тусгасан.

Мөн бүлгийн ажлын алба, түүний гүйцэтгэх ажлыг тусгайлан зохицуулж, бүлгийн гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, гишүүний гаргах зарчмын зөрүүтэй саналыг томъёолох, судалгаа, лавлагаа, мэдээллээр хангах үүрэг гүйцэтгэхээр төсөлд тусгасан болно.

Хоёрт, Улсын Их Хурлын бие даасан байдлын баталгааг дээшлүүлэх хүрээнд хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас бусад хуулиар зохицуулахыг хориглосон зохицуулалт шинээр тусгав.

Ингэснээр Улсын Их Хурлын бие даасан байдлын хууль зүйн баталгаа дээшлэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Гуравд, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхийн баталгаатай холбоотой зохицуулалтын хүрээнд

Улсын Их Хурлын биеэ даасан байдал, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх зорилгоор Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх, үндэслэл журмыг энэ хуулийн төслөөр нарийвчлан зохицуулахаар тооцлоо.

2023 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн үзэл баримтлалын дагуу

Улсын Их Хурлын нэг гишүүнд ноогдох зардлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримтлан гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч, туслахын орон тоо, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад зардал хангамжийг тогтоох хууль зүйн үндсийг энэ хуулиудын төсөлд тусгалаа.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд

Их Хурлын үйл ажиллагааны талаарх нээлттэй мэдээллийг хийх албан тушаалтнуудыг хуулийн төсөлд тодорхойлсон. Тухайлбал, Улсын Их Хурлын дарга, гишүүн, нам, эвслийн бүлгийг төлөөлөн дарга, дэд дарга, Байнгын, Дэд, Хянан шалгах түр хорооны дарга, Тамгын газрын холбогдох ажилтан, албан тушаалтан мэдээлэл хийж байхаар.

Мөн Их Хурал, чуулганы хуралдааныг шууд нэвтрүүлэх үйл ажиллагаа, батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах телевиз, радиогийн тусгай сувагтай байж болохоор энэ төсөлд тусгасан.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох хүрээнд олон улсын нийтлэг жишигийн дагуу хуулийн төсөл хэлэлцэхэд мэтгэлцээн явах зохицуулалтыг боловсронгуй болгохоор шинээр тусгасан. Тухайлбал, нам, эвслийн бүлгээс төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах шаардлагатай гэж санал, дүгнэлт гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх эсэх үе шатад мэтгэлцээн явуулахаар энэ төсөлд тусгасан.

6. Улсын Их Хурлын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах хүрээнд Их Хурлын Тамгын газар Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч,

туслах, Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны чиг үүрэг, эрхлэх ажил, ажилтны эрх зүйн байдлыг хуулийн төсөлд нарийвчилж тусгасан. Мөн Их Хурлын гишүүний зөвлөх, туслах нь гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн, техник, зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэх зохицуулалтыг нэмж тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж та бүхэнд тараасан төслийг хэлэлцэн, хэлэлцэх эсэх явдлыг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нараас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

23 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд уг өөрчлөлтөд бусад хууль тогтоомжийг нийцүүлэхээр, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 44 дүгээр тогтоолыг баталж, Улсын Их

Хурлын тухай хуулийг шинэчлэн найруулахаар тогтсон болно.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хэрэгжүүлэх явцад зарим зохицуулалтыг тодорхой болгох, нарийвчлах нэр томъёог Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэх, Улсын Их Хурлын зохион байгуулалт, Байнгын хороо болон бусад хороод, нам, эвслийн бүлэг, тэдгээрийн ажлын алба Улсын Их Хурлын ил тодод нээлттэй хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж, хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг *d.parliament.mn* хаягт байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, нам, эвслийн бүлэг байгуулах, тарах, гишүүн өөр бүлэгт нэгдэх, гарах, Засгийн газар байгуулах, бүлэг байгуулах зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдал, түүний баталгаа, Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон зохицуулалтуудыг тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа хуулийн төслийг дэмжиж байгаа болон Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд нэгдсэн хуралдаанд болон өөрийн харьяалагддаг Байнгын, Дэд, Хянан шалгах түр хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох зохицуулалт болон Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганболд Түр хороо байгуулах хүрээ хязгаар болон хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо холбогдох Байнгын хороонд ажлын 2-оос доошгүй

өдрийн өмнө хүргүүлэхээр тусгасан нь цаг хугацааны хувьд оновчтой эсэх, мөн Улсын Их Хурлын гишүүнд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг дэлгэрэнгүй, тодорхой болгох талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг Байнгын хороодын бүрэлдэхүүн болон нийгэмд тулгамдаж байгаа асуудал болон иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхийн тулд Байнгын хороодыг байгуулдаг олон улсын жишигийг харгалзан үзэх талаар саналаа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 70 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тус бүр 2, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. Идэрбат гишүүнээр тасаллаа. 13 цагаас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдана. Төсвийн байнгын хороо одоо хуралдана. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Түрүүн Төрийн байгуулалтын хороон дээр ч бас байр сууриа илэрхийлж байсан. Энэ Улсын Их Хурал бол ард түмний төлөөллийн байгууллага. Бид ард түмэн бид нарыг төлөөллөө болгож Улсын Их Хуралд ирүүлдэг. Тийм учраас Улсын Их Хурлын энэ Байнгын хороод, чуулганы хуралдаан түүгээр хэлэлцэж байгаа асуудал өөрөө маш чухал. Өмнө Улсын Их Хурлын дарга хэлж байсан.

Бид нар Герман улсын жишигийг дагаад Өргөдлийн байнгын хороо гээд Байнгын хороотой байсан. Энэ Байнгын хороод иргэд тухайн асуудлаар нийгмийн, олон нийтийн эрх ашигт хөндөгдсөн чухал асуудлуудаар гарын үсэгтэй 500, 600 мянган хүнтэй гарын үсэгтэйгээр асуудлаа оруулж ирээд, тэрийг нь Байнгын хороо хэлэлцээд, жишигээр, Туул голыг бохирдуулаад байна, ой сав энэ олон хууль зөрчөөд, энд хашаа хайс босгоод байна гэж хэлэнгүүт Өргөдлийн байнгын хороо жишигээр Туул голын тэр хууль бус үйлдлийг зогсоож, бид 40 гаруй лицензийг хүртэл цуцлуулж байсан. Тэгтэл сая 20 онд бас ийм бүтцийн өөрчлөлт хийх үед Өргөдлийн байнгын

хороо байхгүй болсон. Одоо тэгээд энэ нь тухайн иргэдээс ирж байгаа, тухайн байгууллагуудаас ирж байгаа өргөдлийг бас харьяалах Байнгын хороод нь хариуцна гээд явсан.

Гэтэл одоо иргэдээс тухайн Байнгын хороонд хандаад, өргөдлүүдээ ирүүлдэг, бас гарын үсэг зураад явуулдаг. Ямар ч хариу байхгүй. Тухайн Байнгын хороо нь тэр олон иргэдийн асуудлаарх өргөдлийг хэлэлцэхдээ биш, нөгөө салбарынхаа асуудалд л түлхүү анхаараад цаг зав нь ч олдохгүй ингээд явчхаад байсан л даа. Дараа нь Өргөдлийн байнгын хорооны даргаар би ажиллаж байсан болохоор над руу нөгөө бичиг нь энд хариу ирэхгүй байна гээд ярьдаг.

Тэгэхээр бид нар энэ Байнгын хороодын тоо 8 байсныг бас намын бүлгүүд хэлэлцээд 11 болгоод орж ирж байна. Инновацын байнгын хороо хэвээрээ. Үйлдвэржилтийн байнгын хороо гээд 11 болж байна л даа. Бид нар энэ дээр тухайн, бусад улс орныг харахад ялангуяа парламентын засаглалтай өндөр хөгжсөн улс орныг харахад тухайн улсад ямар асуудал илүү тулгарсан байна, ард иргэд нь юу илүү хүсэж байна гэдгээр тэр нь өөрөө яг Байнгын хорооны асуудал болоод явчихдаг.

Жишээ нь, Солонгос улсыг аваад үзэхэд гэхэд эрүүл мэнд, хүнсний асуудал чухал бол хүнс, эмийн асуудал хариуцсан тусгай агентлаг, Байнгын хороо ч гэдэг юм уу. Жишээ нь, өөр улсад өнөөдөр эрүүл мэндийн асуудал юм уу, эсвэл агаарын бохирдлын асуудал, жендерийн асуудал чухал бол түүгээрээ Байнгын хороо энэ тэр байгуулчихдаг. Би бас ийм санал гаргаж байсан л даа. Одоо Байгаль орчин, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо гээд маш том Байнгын хороо байгаа. Энэ Байнгын хорооны үйл ажиллагааг хараад байхад голчлон хөдөө аж ахуйн асуудал нь түлхүү явчихдаг. Хааяа нэг Байгаль орчны сайд орж тухайн төсөв хэлэлцэх

үед тайлбараа хийдэг. Аялал жуулчлал нь ч бараг орхигдчихдог. Тэр нь соёлынх ч юм шиг, юун ч юм шиг. Ялангуяа агаар, хөрсний бохирдлын асуудал, байгаль орчны асуудал чинь энэ Байнгын хорооны асуудал юм уу, эсвэл нийгмийн бодлогын асуудал юм уу гэхээр Нийгмийн бодлогын байнгын хороо сүүлийн үед Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тодорхой асуудлыг л хэлэлцдэг. Өөр тэр Дэд хороонд нь Агаарын бохирдлын дэд хороо байгаа гэсэн хэр нь энэ Байнгын хороо нь, Дэд хороо нь бараг ажлаа хийдэггүй. Өнөөдөр Монгол Улсад юу чухал байна гэхээр энэ агаар, хөрсний бохирдол 98, бараг 100 хувийн бохирдолтой хөрсний бохирдол. Жишээ нь, 1.3 сая хүн амтай нийслэл Улаанбаатар хотод хөрсний бохирдол өөрөө өнөөдөр гамшигийн түвшинд хүрчихсэн байгаад байгаа. Тэгээд дараагийн удаад энэтэй холбоотой асуудал хэлэлцье гэхээр Дэд, Байнгын хороон дээр яах вэ, эсвэл Нийгмийн бодлогын байнгын хороо гэхээр хэлэлцэх асуудал энэ нь бараг орохгүй явчхаад байдаг ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа.

Уг нь тэр хуучин Өргөдлийн байнгын хороо их чухал Байнгын хороо байсан гээд Занданшатар дарга ч өөрөө бас энэ Байнгын хороо уг нь байх ёстой Байнгын хороо гээд. Бид нар бас энэ асуудлыг хөндөж байсан л даа. Тэгээд одоо нэгэнт бүтцийн өөрчлөлтөөр байхгүй болсон. Иргэд ди парламент дээр саналаа өгч байгаа.

Гэхдээ энэ ихэвчлэн тухайн хуулийн төсөлд саналаа өгөх, эсвэл ийм төрлийн хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна гэдэг асуудал нь ч чухал болохоос яг нөгөө нийтийн эрх ашгийг зөрчигдөөд байгаа томоохон асуудлуудаар иргэд нийлээд саналаа өгдөг тэр асуудлыг өнөөдөр бас жоохон орхичхоод байна. Бүх Байнгын хороон дээр.

Тэгэхээр энийг бид яаж тусгах вэ? Эсвэл тэр Байнгын хороонд нь үүрэгжүүлж өгөх вэ гэдэг асуудал байгаа юм. Энд хариулт авахыг хүсэж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хороон дарга, хууль санаачлагч хариулна.

Н.Энхболд: Хариулъя Оюунчимэг гишүүний асуултад. Юуны өмнө олон асуулт гарах байх. Бас гишүүд байр сууриа илэрхийлэх байх. Нэг зүйлийг тодруулаад хэлчихье. Шинээр сонгуулийн дараа бүрдсэн Улсын Их Хурал дэгээ өөрөө хэлэлцээд шинэчлэх үү, өөрчлөх үү, тодотгох уу гэдгээ хэлэлцээд батлаад явах ийм хуулийн зохицуулалт байгаа. Үүнийг бас бүх хүн мэдэж байх хэрэгтэй. Тэгээд мэдээж янз бүрийн мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн байр суурьтай олон нам, эвсэл, бие даагч нараас бүрдсэн ийм хурал бүрдэнэ. Хэн ямар зорилт дэвшүүлж гарч ирсэн түүндээ нийцсэн Их Хурлын бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэх эрх нь байж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид нар энэ Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад хууль, төрийн бодлогын төлөвлөлт, хэрэгжүүлэлт тогтвортой байна гээд заасан. Энэ хүрээнд мэдээж тэр шинэ Улсын Их Хурал тэрийг харгалзаж үзээд дэгээ ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй байх вэ гэдгээ шийдэх эрхтэй гэдгийг нэгдүгээрт хэлчихье.

Анх хуулийн төсөл боловсруулахад 8 Байнгын хороотойгоор байхаар бодож оруулж ирсэн. Бүлгүүд дээр ярьж байгаад гишүүдээс гарсан саналыг харгалзаж үзээд одоогийн байгаа 11 Байнгын хорооныхоо бүрэлдэхүүнтэйгээр байхаар санал оруулж байгаа. Энэ дотор өөрчлөгдсөн зүйл бол Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороог Ёс зүй, дэгийн гэж болгоод дэгтэй холбоотой бүх асуудлыг тэнд ёс зүйтэйгээ уялдуулаад хэлэлцээд явж байх нь зүйтэй гэсэн ийм саналаар оруулсан байгаа юм.

Гишүүд санал гаргаад өөрчлөх, цөөлөх, хасах ийм боломж байгаа.

Яг Өргөдлийн байнгын хороотой холбоотой асуудлын хувьд түрүүн би Байнгын хороон дээр ч бас хэлж байсан. Энэ өнөөдрийн Улсын Их Хурлын бий болгоод ажиллаж байгаа 11 Байнгын хороог энэ Их Хурал өөрөө шийдээд, энэ 4 жилийн хугацаанд ийм байгаа. Ийм 11 Байнгын хороотой байхад болох юм гэж үзээд явж байгаа ийм. Өөрөөр хэлбэл, Өргөдлийн байнгын хороо байхгүй байхад тэрүүгээр шийдэгдэж байсан асуудлыг бусад Байнгын хороогоор дамжуулаад шийдэж болно гэж үзээд энэ Их Хурал өөрөө гаргасан шийдвэр.

Энэ хооронд бас зүйлүүд өөрчлөгдөж байгаа. Энэ Их Хурлын хамгийн хийсэн амжилттай хэрэгжүүлж байгаа ажил бол Их Хурлаа энэ *d.parliament* болгох ажлыг үнэхээр сайн зохион байгуулж байгаа. Энийг хүмүүс хэрэглэж мэддэг болж.

Энэ шинэ хуульд, Дэгийн хууль эд нар дотор энэ цахимаар санал аваад, түүнийгээ хэлэлцэх эсэхийг нь Улсын Их Хурал шийдээд, шаардлагатай гэж үзвэл шийдвэр гаргаад явах энэ боломжийг нээсэн байгаа. Тэгэхээр Байнгын хороо дээрээ дамжаад ч иргэдээс ирсэн асуудлыг шийдэх ийм боломжууд байна, энэ шинээр Их Хурлын даргын санаачилж, хэрэгжүүлж эхэлсэн энэ шинээр цахимаар .../минут дуусав./

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Яг энэ шийдвэр гаргах түвшинд тухайн салбарыг хариуцсан сайд, тухайн салбар дахь асуудал хариуцдаг Байнгын хороон дарга энэ тэрийн шалгуур ч гэсэн өөрөө бас өндөр байх хэрэгтэй байна л даа. Дөнгөж нэг, хоёрхон хэдхэн хоногийн өмнө Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын ажилтан алба үүргээ гүйцэтгэж яваад харамсалтайгаар амиа алдлаа. Гүнээ

харамсаж байна. Ер нь энэ он гараад харахад бараг 4, 5 Онцгойгийн ажилтнууд жишээлбэл, үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдаж байна л даа. Уг нь яг ийм болж байгаа үед тухайн салбарын Байнгын хороо нь хуралдаад, тэр салбарын сайдад нь арга хэмжээ авч чаддаг, хариуцлага тооцож чаддаг, учир шалтгаан нь олж чаддаг, тулгамдаж байгаа асуудлыг нь шийдэж чадуулдаг байх ёстой л доо. Энэ шалгуурыг тавьж өгмөөр байна.

Жишээ нь, зарим Байнгын хорооны ч гэсэн бараг унтаж байна шүү дээ. Асуудлыг хөндөөд ямар идэвхтэй үйл ажиллагаа зарим нь явуулж байна, зарим нь тэгээд л таг болчихдог ч юм уу. Энэ тэрийг бид нар бас чагтыг нь суулгаж өгөөд, тогтоож өгвөл дараагийн удаад Байнгын хорооны даргын шалгуур өндөр юм байна, сайдын шал .../минут дуусав./

Г.Занданшатар: Санал юм байна энэ чинь. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр 7 дугаар бүлэгт гишүүний эрх, үүргийн талаар бичсэн байна. Юу хийж болох вэ, хориглох заалт гээд. Тэгэхээр би бол ард түмний төлөөлөл, улс төрчид. Манай урд хөршийн удирдагч сая номдоо бичсэн байна лээ. Ард түмнээ сайхан амьдруулахаас илүү том улс төр байхгүй гэж. Тэгэхээр бидний үүрэг бол ерөөсөө л ард түмнээ сайхан амьдруулах. Энд нэг зүйлт, заалт дээр бүүр онцгойлон хэлмээр байна. Улсын Их Хурлын гишүүн нь бүрэн эрхийн хугацаандаа иргэд, сонгогчдод эд зүйлс тараах, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлдэл хийхгүй байх гэдгийг оруулах ёстой. Энэ бол Сонгуулийн хуульд юу гэж орсон бэ гэхээр зөвхөн сонгуулийн жил гэгчихсэн байгаа.

Тэгэхээр гишүүд чинь яадаг вэ гэхээр 4 жилийн бүрэн эрхийнхээ 3 жилд нь тойргоороо санал цуглуулах зорилгоор маш их юм тараадаг. Цагаан сараар ул

боов тараадаг, чихэр, жимс, тэгээд л янз янзын л юм тараадаг. Тэгэхээр энийгээ одоо болимоор байна. Би энэ сонгуулийн хуулийн ажлын хэсэгт ороод энийг бас оруулъя, зөвхөн Сонгуулийн хууль, жил гэхгүйгээр ер нь өмнөх жилүүд гэсэн чинь л чухамхүү болохгүй гэсээр та энэ хуульд л оруул гэсэн. Одоо энэ хуульд энийг заавал оруулах ёстой.

Өөрөөр хэлбэл, тайлангаасаа, ажлын тайлангаасаа өөр ямар нэг эд зүйлс тараахгүй л байх хэрэгтэй. Энийг яагаад онцгойлж хэлж байгаа юм бэ гэхээр одоо Монгол Улс авлигын индексээрээ ерөөсөө нуужсиндаж байна шүү. Тэгэхээр энэ сонгогчдод эд зүйлс тараадаг зүйл чинь авлигалыг дандаа хөөрөгддөг. Би тооцоо хийгээд л үзлээ л дээ. Жишээлэхэд 30 мянган төгрөгийн ул боовыг тараалаа гэж бодъё. 30 мянган төгрөгийн эд зүйлсийг. Зарим нь 30-аас бүүр 100 мянга хүртэл тараадаг.

Тэгэхээр энийг тараахад л сонгогчдынхоо талд нь тараахад л 75-100 тэрбум шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөөр хэлбэл, гишүүний цалингийн хэмжээнээс хамаагүй давчихсан орлого байхгүй юу. Тэгэхээр энэ чинь авлигалыг хөгжүүлж байгаа л, нэмэгдүүлж байгаа эх үүсвэр гэсэн үг.

Тийм учраас энийг ерөөсөө оруулж өгмөөр байна. Одоо ард иргэдтэй очоод уулзахаар сонгогчдын боловсрол өндөр болсон байна. Юу гэж хэлж байна вэ гэхээр Их Хурлын гишүүд ээ та нар, бид нар та нараас тэр янз янзын бэлэг горьдохгүй, янз бүрийн баярын арга хэмжээнд та нар хийх гээд хэрэггүй. Гол нь бид нарыг сайхан амьдруулаад өг, тэтгэврийн шинэчлэлээ хий, үнийн хөөрөгдлөө зогсоо. Дүүргийн жижиг сажиг ажилд ч гэсэн та нарыг бид нар ингээд зовоохгүй. Та нар үндсэн энэ улс эх орноо хөгжүүлээч гээд. Одоо бүүр сонгогчдынх нь боловсрол нь тэр гишүүдээсээ хамаагүй мундаг өндөр болж эхэлж байна.

Тийм учраас энийг зогсоохгүй бол энэ өөрөө маш олон юу дагуулж байна шүү. Бидний чинь гол үүрэг бол хууль батлах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөв батлах.

Гэтэл зарим гишүүд ерөөсөө чуулгандаа суудаггүй, нэг ч хууль санаачилдаггүй, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, Засгийн газраа шахаж ажиллуулдаггүй. Тэгээд л төсөв батлах дээр гүйж орж ирээд л хэдэн байшин барилга ингээд батлуулсан болчихоод л. Ингээд л ерөөсөө юм тараадаг шүү дээ. Одоо томсгосон тойрог гээд бид нар бас баярлаад багасгасан юм болов уу гэтэл дахиад л мөнгөтэй олигархууд тараана л гэж байна. Нэг аймагт 10 тэрбум юу ч биш. 4 аймаг 40-ийг бол тараачихна л гэсэн иймэрхүү л гишүүд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол өөрөө авлигалыг хөөрөгдөж байгаа.

Тийм учраас Энхболд даргаа энэ заалтыг заавал оруулах ёстой шүү. Та энэ дээр бас байр сууриа илэрхийлээч гэж хүсэж байна. Агаарын бохирдлын түр хороог яагаад.../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн, хууль санаачлагч.

Н.Энхболд: Нэгдүгээр саналын хувьд гишүүд зөвхөн сонгуулийн сурталчилгааны үед, бусад үед ч гэсэн хуульд заасан үндсэн үүргээ биелүүлэхээс бусад ямар нэгэн байдлаар тэр юм тараадаг барьдаг энэ зүйлийг болиулах тийм хуулийн заалт томъёолоод ороод ирвэл хууль санаачлагчдын хувьд тэрийг ерөөсөө эсэргүүцэх юм байхгүй. Та нарт, гишүүдэд маань бүрэн эрх нь байгаа. Үүний дараа ажлын хэсэг гарна. Жишээ нь, би 2, 3 хууль санаачлаад, төлөөлөөд би зоригтой хэлж болж байна. Тийм санал ороод ирээд энэ дотор тусгачихвал бидний зүгээс манай үзэл баримтлалд харшилна гэж үзэх юм огт байхгүй гэж л хэлэх байна.

Хоёр дахь нь бараг санал шахуу юм даа. Бүх л Улсын Их Хурлын тухай,

Дэгийн тухай хуульд гишүүн хуралд тусалж болохгүй, ер нь идэвхтэй байх ёстой, ерөөсөө үндсэн үүрэг нь хууль санаачлах, оролцох шүү гэж ингэж заасан л байгаа. Одоогийн хуульд ч тийм юмнууд байж байгаа. Ерөөсөө ч би сонгогч иргэд аливаа гишүүнийг сонгохдоо энэ хүнийг сонгогчлоод би энэ хүнээс тийм юм авна даа гэж бодож биш, энэ хүн миний төлөө ажиллаж, хууль тогтоомж дээрээ ажиллах, тэр гаргасан хууль тогтоомжийнхоо хойноос нь явж, шалгаж, хянаж, Засгийн газарт хяналт тавиад, бидний төлөө ажиллах ёстой гэж бодож л саналаа өгч гэж боддог. Аливаа хууль юмыг заавал эрүүл саруул ухаанаас нь бодож л боловсруулдаг шүү дээ. Тэгэхээр тантай бол бас тэр шүүмжлэлтэй хандаж байгаа зүйлтэй чинь санал нэг байна.

Агаарын бохирдлын тухай одоо манайд байхгүй. Энэ хууль дээр жишээ нь, 11 гээд Байнгын хороо байж байгаа. Би түрүүн хэлсэн. Байнгын хороо хэд байхыг Их Хурал, дараагийн Их хурал өөрөө шийдэж болно. Нээлттэй байгаа.

Хоёрт, Байнгын хороон дээр ярьж байгаад шаардлагатай гэж үзвэл түрүүн миний нэр дурдсан хууль санаачлагчийн илтгэлд тавьсан Дэд хорооноос бусад Дэд хороодыг гишүүдийнхээ олонхын саналаар байгуулах боломж энэ хуульд нээлттэй бас байгаа.

Яг энэ хууль дээр нь, асуудал болгоныг Дэд хороо гэж заавал бас ямар юу ямар байх юм бол доо? Онцгүй л гэж бодож байна. Байнгын хороод нь тухай тухайн үедээ яриад за Агаарын бохирдлын дэд хороо байгуулна гэвэл энэ хуулийн заалтад нээлттэй байж байгаа шүү. Тэр нь боломжтой байгаа л гэж хэлье.

Г.Занданшатар: Одонтуяа гишүүн тодруулъя.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд

тайлангаас бусад ямар нэгэн эд зүйлс тараахгүй, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэхийг хориглох ийм заалт, саналын томъёолол би оруулъя. Байнгын хороон дээр. Энэ дээр харин дэмжээд нэгдэх гишүүд байвал дэмжиж оролцоорой. Энэ саналыг албан ёсоор би саналын томъёололд орж хураалгана. Ер нь Улсын Их Хурлын гишүүн бол үндсэн ажлаа л хийдэг байх ёстой. Улсын Их Хурлын гишүүн бол үндсэн үүргээ биелүүлдэг байх ёстой. Та дэмжихгүй байж болно Тогтохсүрэн даргаа. Би дэмжих гишүүд байвал хамтарч оролцоорой.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах гээд энэ багцаараа явж байна л даа. Дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хууль гээд. Энэ дээр энэ Улсын Их Хурлын гишүүд чинь өөрсдөө ард түмнээ төлөөлнө гээд энэ Их Хуралд сонгогддог. Тэдний саналыг аваад, тэр гишүүнээр дамжуулж бүрэн эрхээ хэрэгжүүлдэг ийм хүмүүс. Тэгэхээр энэ дээр энэ хуулийн зүйл, заалтууд дотор энэ Их Хурлын гишүүдийг 76 ч байна уу, 126 ч байна уу үг хэлэх асуудлыг нь хязгаарлах ийм заалт орж ирж байна. Тухайн гишүүний сонгогдсон тойргийн асуудлыг бүлэг дээр нь мэдэхгүй байх асуудал зөндөө байгаа. Тэр үедээ хэлэх үгээ гишүүд чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлж шийдвэрлүүлэх асуудлыг яаж харж байгаа вэ? Зарим хүн нь үг хэлээд, зарим нь үг хэлэхгүй байдлаар орж ирж байгаа юм шиг байна шүү дээ.

Ер нь энэ сүүлийн үед энэ цөөнх рүү, сөрөг хүчин рүүгээ хүндэтгэлгүй хандах, тэдний хэлж байгаа, өргөн барьж байгаа хууль журмын дагуу явж байгаа юмыг хааж боогдуулах асуудал бол хэрээс хэтэрч байна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд, 7 гишүүн гарын үсэг зураад энэ Улсын Их

Хурлын тухай, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Их Хурлын тогтоолын төсөл санаачлаад өгсөн. 2 сар хэртэй өргөн барих товыг нь гаргаж өгдөггүй ингээд байлгачхаж болдог юм уу?

Тойрогт, энэ жил Монгол Улсад ганц тойрог ч гэлтгүй Монгол Улс даяар Засгийн газар тогтоочихсон гамшигийн нөхцөл байдал үүссэн. Ийм нөхцөл байдалд чинь энэ тангараг өргөчихсөн гээд байгаа Их Хурлын гишүүд чинь цаг алдалгүй яаралтай ажиллах ёсгүй юм уу? Бид бүхэн чуулганы завсарлагаагаар асуудал өргөн барихаар бүүр хэлэлцэх дараалалд битгий хэл өргөн барих товыг нь хүртэл тогтоож өгөхгүй ингээд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ Их Хурлын тухай хууль дээр энэ сөрөг хүчний цөөнх байгаа хүмүүсийн үг хэлэх энэ асуудлуудыг нь бас оруулж өгмөөр байна. Тэр хуулийн, би сая Байнгын хороон дээр бас ороод асуулаа л даа. Энэ хуулийн энэ тов тогтоох энэ асуудал энэ тэр гээд. Энэ асуудал хэрвээ зохицуулалт байхгүй юм бол энийг энэ хуулийн шинэчилсэн найруулга хийж байгаа тохиолдолд энийг оруулж сайжруулаад явмаар байна. Тодорхой цаг хугацаатай болгож өгмөөр байна.

Тэгэхгүй бол ийм субъектив, хувийн үзэмжээр, эрх баригч сөрөг хүчний үзэмжээр асуудалд хандаад байвал энэ Их Хурлын гишүүд чинь тэр тойргийн сонгогчдын, ард түмний хэлж байгаа үгийг яаж шийдвэр болгож гаргах юм? Би энэ дээр тодорхой хариулт авмаар байна. Энэ зудын нөхцөл байдал чинь ганцхан сөрөг хүчний ажил юм уу? Ард түмний асуудал биш юм уу? Засгийн газар нь гамшигийн зэрэг тогтоочихсон энэ асуудал чинь жижиг асуудал юм уу? Тэгээд бусад асуудлууд, ялангуяа эрх баригчдын зүгээс орж ирж байгаа асуудал болохоор 1 цагийн дараа Байнгын хороогоор орж ирж байдаг. Ямар ч судалгаа, янз бүрийн юм нь байхгүй байна л гээд байдаг мөртөө чуулганы хуралдаан дээр ерөөсөө өргөн бариад л тэр дороо

ороод ирж байдаг иймэрхүү юмнууд байна.

Тэгэхээр энэ дээр бас Их Хурлын тухай хууль, энэ Дэгийн тухай хууль энэ тэр дээрээ бас оруулаад явмаар байна. Цөөнх рүүгээ хүндэтгэлгүй ханддаг. Адилхан л гишүүн шүү дээ. Их Хурлын дарга ч гишүүн, Байнгын хорооны дарга ч гишүүн, сул гишүүн байсан ч ард түмний л төлөөлөл хэрэгжүүлж байгаа. Төсөв дээр санал тавиад орно Байнгын хорооны дарга нар нь яамтайгаа нийлээд булаад авчихна. Ямар ч тийм, сүүлийн үед ийм сөрөг хүчин рүүгээ яаж байгаа байдал бол .../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

Н.Энхболд: Тийм. Туваан гишүүнээ нэг их улс төржөөд, эс үгүй бол цөөнхийг хязгаарлах үүднээс энэ үг хэлэх дэгээ арай өөр болголоо гэж үзэж болохгүй. Бид нар бас олон талаас нь харж, үзэж ярьсан. Та бол үг хэлэхийг нь бүрэн хязгаарлачхаж байгаа юм шиг юм хэлээд байна.

Тэгэхээр энэ дээр, заалт дээр юу байгаа байгаа вэ гэхээр өөр үзэл баримтлалаар санал ороод ирвэл нээлттэй шүү дээ. Энийг би хэлчихсэн. Энэ хууль дээр юу гэж орсон байгаа вэ гэхээр ерөнхийдөө аливаа хуулийг юм уу, шийдвэрийн төслийг хэлэлцэх ерөнхий цагаа тогтооё гэж байгаа юм. Тэр цаг дотроо багтаагаад олонх, цөөнх, бусад хүмүүс хэдэн суудал Их Хуралд авсан байна тэрүүгээр нь пропорцлоод хуваая гэж байгаа юм. Бүгдээрэнд нь тодорхой хэмжээгээр. Олон суудалтай бол арай олон цаг авна. Тэр нэг их шударга ёсноос гажсан зүйл биш гэж бодож байна. Арай цөөхөн суудалтай бол арай бага цаг авна гээд л хуваарилаад явчихъя.

Бүлгүүд дотроо асуудлаа яриад, ер нь бид нарын энэ Үндсэн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд төрөө бэхжүүлэх, Их Хурлаа бэхжүүлэх,

парламентын ардчиллыг бэхжүүлэх, сонгодог парламент бий болгох энэ гол цаад агуулга нь юу вэ гэхээр цөөнхөө хүндэтгээд олонхын шийдвэр гаргаж байх. Аль болохоор цөөнхөө оролцуулж байх ийм бололцоог нээх л үүднээс энэ бүх зүйлүүдийг хийсэн шүү дээ.

Тэгэхээр энэ огт үгийг нь хязгаарлачхаад байгаа юм биш. Үгүй яах вэ одоо ингээд гишүүд санал гаргаад, энэний дараа ажлын хэсэг байгуулна. Би Улсын Их Хурлын дарга ажлын хэсэг байгуулж өгөх болов уу гэж бодож байна. Тэн дээр саналуудаа хүн болгон дуртай үедээ, дуртай цагтаа үгээ хэлж байя. Хязгааргүй гэж санал оруулаад дэмжигдвэл тэгээд явахаас өөр аргагүй. Дараагийн Их Хурал тэрийг нь яаж үзэх юм байгаа юм? Тэр бас тэд нарын асуудал байж таарна. Тэгэхээр энэ бол их тийм цөөнхийг хязгаарлахын үүднээс дараагийн хийгээд байгаа ажил биш шүү.

Дараагийн хуралд хэн цөөнх боллоо, хэн олонх боллоо хэн ч мэдэхгүй л байгаа. Үг хэлэхийг нь хязгаарлах байтугай бүлэг байгуулахыг нь хязгаарлаж байсан үе байсан юм. Тэгэхээр энэ удаагийн Их Хурал бол харин ч бас их тийм асуудалд либерал хандаж, томоор нь шийдэж, үндэс суурийг нь их сайжруулж ирсэн гэж үзэж. Би бол тэгж үздэг. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс эхлээд энэ бүх юмнууд бол зөвхөн тэрэнд ч л жишээ нь чиглэсэн байгаа.

Тэр тов тогтоох энэ тэртэй холбоотой асуудлыг би бас түрүүн Байнгын хороон дээр саналаа оруулсан төслийнхөө талаар тайлбарласан. Ямар ч байсан эхний ээлжид энэ дарааллаа, өргөн мэдүүлсэн дарааллаар нь хэлэлцдэг болъё. Тэр л дараалалд орчихсон бол зайлиггүй дараа нь хэлэлцдэг, ээлж нь ирдэг тийм байя. Хэлэлцэх, хэлэлцэхгүйг нь бас Даргын зөвлөл, Улсын Их Хурлын дарга өөрөө бас хурал удирдах .../минут дуусав./

Г.Занданшатар: 13 цаг болсон байна. Чуулган завсарлана.

Ер нь Дэгийн хуулиа сайн унших хэрэгтэй. Туваан гишүүнд Дэгийн хуульдаа сайн суралцах хэрэгтэй. Ер нь Улсын Их Хурлын тухай хуулиар юу санаачлах вэ, юу санаачлахгүй вэ, юуг хамтарч санаачилдаггүй, цөөнх, олонхоороо санаачилдаггүй. Тэрийг бас ойлгох хэрэгтэй.

Ер нь бас энэ Улсын Их Хурлын ажил чинь цээжний бангаар явдаг ажил биш, олон жил уламжилсан. Сая Нямаагийн Энхболд гишүүн хэллээ. Харин ч ёстой цөөнхийг бүүр бүлгийг нь ч байгуулахгүй, цөөнхөө дарамталдаг, үг хэлүүлдэггүй байсан бол харин ч цөөнхөд маш хүндэтгэлтэй хандаж байгаа. Тэгэхдээ цөөнх байна гэдэг нь өөрөө хууль зөрчинө гэсэн үг биш. Дураараа авирлана гэсэн үг биш. Энийгээ хаа хаанаа санаж, бас Дэгдээ ч гэсэн энийг хаа хаанаа анхаарч энэ хуульдаа боловсруулах хэрэгтэй.

13 цаг болсон учраас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан завсарлалаа. 14 цагаас үргэлжилнэ.

14 цагаас Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

13.03 цаг

Пүрэв гараг, 11 Дөрөвдүгээр сар 2024
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим

14 цаг 01 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаан үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна. Нямаагийн Энхболд гишүүн асуултад хариулъя. Хууль санаачлагч Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд асуултад хариулна.

Бадарчийн Жаргалмаа гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболдыг дуудъя. Хатантуул Байнгын хорооны даргаа олж ирив, явъя.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Түрүүн би бас Байнгын хороон дээр асууж байсан энэ гишүүдийн хариуцлагын асуудлыг бид нар ер нь яаж энэ хуулиараа бас тодорхой хэмжээнд тусгаж өгөх ёстой юм бэ гэдэг зүйлийг тодруулсан юм. Тэр асуултаа би дахиад тавих гээд байна.

Яагаад гэвэл энэ хуралдаанд санал өгөхөөс гадна түрүүн Их Хурлын дарга бас Улсын Их Хурлын гишүүдийн ирцийн асуудлыг бас олон нийтэд мэдээллээ. Ер нь гишүүдийн үндсэн үүрэг бол Улсын Их Хурлын хуралдаанд сууж хууль батлах, санаачлах, боловсруулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ийм үүрэгтэй. Сонгуулийн жилийн онцлогоос шалтгаалан гишүүд маань тойрогт ажиллаж байна гэдэг ийм шалтгаан нар Байнгын хорооны хуралдаан хуралдахгүй байх ийм нөхцөл байдал үүсээд байна.

Зөвхөн өчигдөр, уржигдар гэхэд Байнгын хороод хуралдаж чадаагүй ийм байсан. Би яагаад энэ гишүүдээс хариуцлага нэхэх гээд байна вэ гэвэл Монгол Улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй. Сонгосон төлөөллөө энэ жижиг парламентад энэ жижиг нөхцөл байдалд гэдэг юм уу энэ танхимд хэлэлцэх тэр явцдаа сонгогч иргэн маань миний үгийг, миний саналыг ер нь энэ Их Хурал дээр миний сонгосон гишүүн хэрхэн яаж хамгаалж байна вэ, хэрхэн яаж хууль

болгож чадаж байна вэ гэдгийг сонгогчид маань хараад сууж байдаг. Тэр ч үүднээсээ сонгогчид маань харьцангуй боловсрол өндөр болсон энэ цаг мөчид бид нар хариуцлагыг нэхэх энэ шаардлага улам бүүр өндөр болж байгаа.

Тэгэхлээр яг энэ дээр бид нар энэ хуульдаа гишүүний хүлээсэн үүргийг хэрхэн яаж чангатгах вэ, зүйл, заалтаар нь чангатгах ёстой юм уу, үгүй юү гэдэг зүйлийг тодруулж байгаа юм. Их Хурлын даргын түрүүн зарласан нөхцөл байдал бол энэ бол анхааруулга байсан. Зүгээр 1 удаа анхааруулаад үзэх үү? Тодорхой хэмжээнд хуульдаа бид чуулганы хуралдаанд тэгж тэгж хурлын ирцийн талаарх мэдээллийг олон нийтэд өгч, сонгогчдод дүгнэлт хийх тэр боломжийг нь олгоно гэдэг юм уу. Хариуцлага гэдэг зөвхөн парламентыг дахин сонгох, сонгох тухай асуудал биш. Энэ бүрэн эрхийн хугацаандаа үүргээ хэр сайн биелүүлж байгаа вэ гэдэг дээр бас дүгнэлт хийх тэр боломжийг нь бид нар олгож өгөх ёстой байх гэж бодож байгаа юм.

Би бас Сонгуулийн тухай хуулийг хэлэлцэж байхад сонгогчдын боловсрол дээр бид нар ер нь хэр анхаарах ёстой юм бэ, бид нар яаж мэдээлэл өгч байна гэдэг зүйлийг бас тодруулж байсан. Энэ бол миний итгэл хүлээлгэсэн гишүүн, миний төлөөлөл болж энэ парламент үгээ хэлж чадаж байна уу, үгүй юү гэдгийг харах, хариуцлагатай байна уу, үгүй юү гэдгийг харах, хуулийн хугацаанд, чуулганы хуралдаандаа сууж батлагдсан хууль, тогтоолын төсөлд хяналт тавьж чадаж байна уу, үгүй юү гэдэг дээр иргэд хяналт тавих тэр боломжийг нь бид нар бас Их Хурлын тухай хуулиар бас олгох ёстой болов уу гэж бодож байна.

Энэ дээр ер нь ямар зүйл, заалт нарийн байгаа юм бэ? Бид бүрэн эрх гэдэг зүйлийг ярьдаг. Бидэнд бүрэн эрх байгаа. Гэхдээ бид бас хариуцлага хүлээх энэ тогтолцоог энэ хуульд нарийн

тусгаж өгөх ёстой болов уу гэж бодож байгаа юм. Асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Хууль санаачлагч, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд хариулна.

Н.Энхболд: Энэ өөрөө их том асуудал. Үнэхээр Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг бол төрийн эрх барих дээд байгууллагыг бүрдүүлж байгаа хүний хувьд төрөөс гарч байгаа бүх л шийдвэр хууль тогтоомж юманд, амархнаар хэлбэл хуульд заавал бичсэн, бичээгүй маш хариуцлагатай хандаж, хүмүүсийн санал бодолд, өөрийнхөө ярьж байгаа юманд, гаргаж байгаа шийдвэр, тэрнийхээ үндэслэлд туйлын хариуцлагатай хандаж байх ёстой.

Яг Их Хурлын гишүүн мэдээж дээр нь ёс зүйн асуудал юмнууд байгаа. Яг ингээж ингээж ийм байхыг Их Хурлын гишүүн хариуцлагатай байна гэж заалт, зүйл болгож Улсын Их Хурлын юм уу, бусад хуульд оруулахад бас төвөгтэй л дөө. Ерөнхийдөө ямар үүрэгтэй вэ гээд л тэр үүргийг л хариуцлагатайгаар биелүүлэх ёстой гэдэг ийм дахиад аливаа хууль чинь энэ аливаа зүйлийг эрүүл саруул ухаанаар бодож хийдэг учраас яг энэ том суурин дээр л хийгдэх ёстой.

Хуралдаа суухгүй байгаа, хууль санаачлахгүй байгаа, ажлын хэсэгт ажиллахгүй байгаа, ирцээ бүрдүүлэхгүй байгаа энэ бүхэнд бол мэдээж Дэгийн хуулиар бусад хуулиар зарим зохицуулалтууд бий. Улсын Их Хурлын даргын зүгээс анхааруулах, үг хэлэх эрхийг нь хасах, хуралдаанаас гаргах гэх мэтчилэн. Мэдээж гэмт хэрэг хийсэн бол тэр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлагаа хүлээгээд явна. Тэгэхээр тэр болгоныг бүгдийг нь яг л ийм л байвал энийг хариуцлагатай гишүүн гээд бид тоочилж бичсэн ер нь аль ч улсын хуульд байдаггүй. Тангарагтай. Тэр тангаргийнхаа хүрээнд л нөгөө ёс зүйгээ баримтлаад л аливаа гаргаж байгаа

шийдвэрүүд нь улс орны эрх ашигт, сонгогч иргэдийн эрх ашигт нийцсэн байх үүднээс л үйл ажиллагаагаа явуулж байх ёстой л гэж хэлдэг юм уу даа.

Хориглох зүйлүүд гэж жишээ нь, гишүүдэд тэгж болохгүй, ингээж болохгүй гээд заачихсан байж байгаа. Тэр бүх зүйлүүдийг 43 дугаар зүйл, 44 дүгээр зүйлд заасан юу хийж болох вэ, ямар ажлыг давхар хийж болох вэ, юуг үйл ажиллагаанд нь хориглох вэ гэсэн энэ бүх зүйлүүдийг бас тодорхой хэмжээгээр тусгачихсан байгаа. Энийгээ л зөрчөөд байвал тэр гишүүн үүргээ биелүүлэхгүй байна л гэж үзэхээс өөр арга байхгүй. Эцсийн дүн тавьдаг газар нь л сонгогч шүү дээ. Их Хурлын дарга бол би түрүүн бас үгэн дундаа хэлсэн. Энэ төрийн эрх барих байгууллагыг удирдаж байгаа Их Хурлын дарга бол бусад орнуудад янз бүрийн л байдаг. Их Хурлын дарга жишээ нь, намаасаа түдгэлзсэн байдаг. Нетриал-ны байдлаар Их Хурлаа хуралдуулж явна гээд .../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн гүйцээж хариулъя.

Н.Энхболд: Өөрөө улс орны өмнө төрийн удирдах дээд байгууллагыг үйл ажиллагааг нь зөв хуулийн хэмжээнд явуулахыг толгойгоороо хариуцаж байгаа хүн бас тодорхой хэмжээгээр тийм шийдвэр гаргаж байх орон зайтай байх хэрэгтэй гэж би боддог. Түүнээс энэ болно, тэр болохгүй гээд бүх юмыг нь заачихвал түрүүн яриад байсан шиг дэгийг нь, товыг нь заавал ингэнэ, тэрийг нь заавал ингэнэ гээд байвал энэ хүн зүгээр л алах тогшоод л сууж байдаг болох тийм л юм болчих юм байгаа юм. Бусад бүх Их Хурлуудад ч тийм юм байдаг. Тодорхой эрхтэй, орон зайтай.

Энэ дэгийг сахиулаад л хурлыг үр дүнтэй явуулах нь энэ даргын эрх байгаа, үүрэг юм байгаа юм. Тэрэндээ ч хариуцлага хүлээдэг. Энэ удирдлага, зохион байгуулалтын дотор хориглосон

зүйлүүдийг зөрчихгүйгээр явж байгаа. Зөрчөөд байвал авах арга хэмжээ нь бас Их Хурлын даргад хуулиар олгогдсон ч эрхүүд байгаа. Түүрүүн би хэлсэн үг, үгийг нь хасах барихаас эхлээд. Энэ бүх юм цогцоороо нийлж байж л Их Хурлын гишүүний үүрэг, хариуцлага, түүнд хүлээлгэх хариуцлагын зүйлүүдийг ярина. Эцсийн дүндээ дүн тавьдаг газар нь бол сонгогчид, иргэд хамгийн сүүлд дүн тавьдаг. Наана нь бол өөрөө нэгэнт эрх авчихсан хүн бас тодорхой хэмжээгээр бүх юмыг нь зааж яагаад байхгүй хэмжээнд бэлтгэгдсэн хүмүүс л Улсын Их Хуралд гишүүнээр сонгогдоно гэж бодож аливаа хуулиудыг хийж, иргэд сонгогч ч гэсэн сонгуулиа хийхдээ тэгж хандаж байх ёстой л гэж боддог юм.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Би яагаад гишүүний хүлээх үүрэг, хариуцлагын тухай тодруулаад байгаа юм бэ гэвэл Үндсэн хуулиараа бид нар ирэх энэ сонгуульд парламент маань 126 гишүүнтэй болно. Олон үзэл баримтлал, ургалч үзэл гэдэг юм уу бид нар Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг парламент олон намын төлөөллийг бий болгохын тулд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр аль ч намын гишүүн хэчнээн ч хүн сонгогдсон бие даагч болоод, бусад намын төлөөлөл хэдэн ч хүн орж ирж болзошгүй.

Тэгэхлээр хурлын ирц бүрдэх үү, үгүй юү гэдэг дээр л би бас тодорхой хэмжээний хариуцлага зааж өгөх ёстой юм болов уу гэдэг зүйлээр тодруулж байгаа юм. 20-24 оны парламент бол цахим парламент. Бид иргэдийнхээ саналыг цахимаараа авдаг болчихсон. *d.parliament*-аар иргэд маань өргөн барьсан хуульд саналаа өгдөг. Одоо энэ хуулийн 39.4.1 дээр хуулийн төсөл санаачлах саналыг 100 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол гэдэг ийм зүйл, заалт орж ирж байгаа. Түүний 39.5 дээр нийтийн өргөдлийг дэмжсэн

иргэдийн санал цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан тоон гарын үсгээр.../минут дуусав./

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй л гэж үзнэ л дээ. Эхлээд хариултаа авчих, гүйцээчих. Нямаагийн Энхболд гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хороон дарга.

Н.Энхболд: 39.4, 5-тай холбоотой асуултад хариулъя. Энэ манай Их Хурал энэ удаагийн Их Хурал бол Монгол Улсын Их Хурлыг маш олон талаар иргэдтэй харьцах сувгуудыг нээсэн. Тэрний дотор энэ жишээ нь *d.parliament* гээд цахим парламентын асуудлыг үнэхээр цоо шинээр эхлүүлээд боломжийн шинэ шатад аваад ирсэн үйл ажиллагааны ажиллагаанд ер нь орчин үеийн техник технологи, мэдээлэл харилцааны хэрэгслийг ашиглаад яаж ажлаа сайжруулж болох вэ гэдэг дээр эхлэлийг нь тавиад хувьсгал гаргасан гэж хэлж болохоор ийм хурал байгаа юм.

Одоо бол журмаар зохицуулагдаж яваа юмаа бид нар хуульчилж байгаа юм. Нийтийн өргөдлийг цахим системд, тодорхой хугацаанд байршуулаад, насанд хүрсэн иргэд 100 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол хуулийн төсөл санаачилгыг Байнгын хорооны эрх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулахыг 70 мянга, түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол тодорхой ажил хэсгийн асуудлаар ажлын хэсэг байгуулагдсанаас яг 30 хэдэн хүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол үүнийг нь баталгаатай цахим гарын үсгээр баталгаажсан ийм саналуудыг нөгөө тролл элдэв янзын юм оруулахгүйгээр Их Хурал авч хэлэлцэж байхаар цоо шинээр хуульчилж ингэж оруулж байгаа юм. Энэ их том алхам болно.

Түүрүүн тэр Өргөдлийн байнгын хороотой холбогдсон асуудал дээр би бас хэлж байсан. Аль болохоор хууль хэлэлцэх үйл ажиллагаанд, санаачлах үйл

ажиллагаанд иргэдийн оролцоог миний хувьдаа ойлгож байгаагаар буруу ойлгогдвол уучилна биз. Өргөдлийн байнгын хороо байснаас илүү том үүд хаалгыг нээсэн ийм алхам болсон хуулийн заалт энэ төсөл дотор бас орсон байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулъя, 1 минут.

Б.Жаргалмаа: Би шууд л юу асуучихъя даа дарга. Энэ цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-д заасан тоон гарын үсгээр баталгаажсан гэгчихсэн байгаа шүү дээ. Ер нь Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт хэчнээн иргэн тоон гарын үсгээ баталгаажуулсан байдаг юм бэ? Тэн дээр мэдээлэл өгөх боломж байна уу?

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Яг тодорхой тоо надаа алга, уучлаарай. Тэгэхдээ ер нь нэлээд хэсэг нь тоон гарын үсгээ авчихсан байгаа юм билээ. Би дараа хэлэлцүүлэг явцад энэ тоог авч байгаад хэлье. Энийг таширамд хэлэхэд энэ цаашдаа бол ер нь дэлхий даяар тийм болж байгаа. Бүх юм цахимаар явдаг болж байна. Үүний гол баталгаа нь бол өнөөдөр бид нар иргэний үнэмлэхийн дугаар, регистр гэдэг шиг, гарын үсэг гэдэг шиг тэд нарыг орлоод яваад энэ хүн бол энэ хүн мөн байна. Энэ хаяг дээрээ ингэж байдаг, батлах хамгийн том баталгаа бол энэ хэн ч давтаж өөрчилж болохгүй цахим гарын үсэг байгаа юм. Хуультай. Хуулийнх нь дагуу хийгээд явах. Тоог бол би гаргаж байгаад дараа хэлэлцүүлгийн явцадаа дахиад хэлье. Тийм, тэр тоог гаргаарай.

Г.Занданшатар: Сая нэг зуун мянган иргэн тоон гарын үсэгт шилжсэн гэсэн. 3.5 сая нийт иргэнээс. Энэ бол Үндсэн хуулийн 3.1-д ингэж байгаа юм “төрийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна” гэж байгаа юм.

Ардчилсан бүх Үндсэн хуультай улсууд төрийн эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байна, мэдэлд байна сэн ийм агуулгатай. Ардчилсан үндсэн хуулийн зарчим. Энэхүү эрх мэдлээ ард иргэд өөрсдөө төрийн хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагадаа уламжилж, мөн тэднээрээ дамжуулан, төлөөлөгчдөөрөө дамжуулан энэ төрийн хэрэгт оролцож асуудлаа шийдвэрлэнэ гэсэн энэ Үндсэн хуулийн энэ заалтыг л хэрэгжүүлж байгаа юм.

Үндсэн хуулийн 16.12-т иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүрэгтэй гээд заачихсан юм. Үндсэн хуулийн ийм хоёр заалт үүгээр амьдралд хэрэгжиж, өнөөдөр бас яг тэр 100 мянган иргэний санал авсан хуулийн төсөл батлагдлаа шүү дээ.

Тэгэхээр энэ бол жагсаж цуглаад байхгүй, гудамж талбайд жагсаж үзэл бодлоо илэрхийлдгээс илүү ард иргэд зөвлөлдөөд, хэлэлцээд бодитой саналаа тэрнээс эерэг, сөргөөрөө дуудаж байгаад саналаа ирүүлээд тэрийг нь тэгэхдээ хууль тогтоох байгууллага эцсийн шийдвэр өөрсдөө гаргана. Энэний мэтгэлцээний зарчмаар шийдэх нөхцөлийг ард иргэдийн санал бодолд нийцсэн шийдвэр гаргах бололцоо ингэж хангагдсан.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Энэ 2020-24 онд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал, Засгийн газар онцгой чухал шинэчлэлийн ийм ажлууд хийсэн. Та бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Энд ялангуяа энэ улс орон урагшаа дээшээ ахиж, дэвшихгүй байгаа ард түмний аж амьдрал байдал энэ хэмжээнд доошлоод байгаа, өнөөгийн нийгэмд бий болсон олон үйл явдлын энэ хорттой үр

дагавруудын үндсийн үндэс бол ерөөсөө авлигал, ашиг сонирхол байна гэж ингэж үзэж, авлигатай тэмцэх чиглэлээр томоохон ажил эхлүүлсэн. Олон хууль, эрх зүйн зохицуулалт, шинэчлэл, өөрчлөлтийн ийм шийдвэрүүдийг гаргасан.

Энэ дотор бол ерөөсөө энэ хамгийн дээд талд эрх барьж байгаа шийдвэр гаргах түвшний хүмүүсийн ёс зүй, сахилга хариуцлагаас бүх юм шаардана. Шатны гишгүүр дээрээсээ шүүрдэнэ. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүний дүрмийг энэ хуулийг шинэчилсэн найруулгын төслөөр баталж авсан. Эхэлж Их Хурлын гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг маш тодорхой хуульчилж өгөөд, үүнтэйгээ уялдуулаад Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчдаасаа ёс зүй, сахилга хариуцлага шаардахын зэрэгцээгээр тэднийхээ ажиллах амьдрах орчин, нийгмийн хамгаалал, баталгаа, цалин хөлсний асуудлыг нь шат дараалалтайгаар нэмэгдүүлээд ингээд явж байгаа.

Энэ хүрээнд ерөөсөө л болохгүй юмны үндэс бол энэ хамгийн дээд түвшинд ажиллаж байгаа хүмүүсийн ашиг сонирхол, авлигал, хулгай, хувийн сонирхлоос л энэ бүх юм шалтгаалж байгаа юм. Энийг үндсэндээ 20 жил шаардаж, энэ 2010 оны анхны Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлагдах тэр ажлын хэсэгт орж ингэж явж ирсэн.

Харин энэ тэмцэл, энэ шаардлагыг бодит ажил хэрэг болгосон Их Хурал бол энэ 20-24 оны Улсын Их Хурал юм. Энэ Засгийн газар юм. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулсан 2-5 жилийн ялыг 12-20 жил яс цоожинд суухаар энэ цагаан захтнуудад ингэж хатуу зааж өгсөн. Ял наймаалцах тухай асуудал байхгүй, хөөн хэлэлцэх тухай асуудал байхгүй, наана нь магадлангаар чөлөөлөгдөхгүй асуудал байхгүй. Үүний зэрэгцээгээр нэг том хууль бол энэ ашиг сонирхлын зөрчлөөс

ангид байх. Их Хурлын гишүүн юм уу, дарга сайд болох юм бол өөрийнхөө эхнэрийг, нөхрийг ёс юм шиг ажил, албан тушаалд тавьдаг. Өөрийнхөө үр хүүхдүүдийг энэ төрийн албаар тасралтгүй зайдагнуулдаг. Энд хаалт тавьж өгсөн.

Гэхдээ энэ дотор хуулийн хулгай бол явсан. Энийг энэ Их Хурал анхааралдаа авч, үүнийг засаж, залруулах ёстой гэж.

Дараагийнх нь юм бол монголчууд энэ байгалийн баялагтаа эзэн болж чадахгүй, ард иргэдийн итгэл сэтгэл бол сөхөрчихсөн ийм л байдалтай байсан шүү дээ. Тавантолгойн энэ том ордоосоо 1072 хувьцаа эзэмшиж байгаа боловч энэ ноогдол ашгаа энэ 10 жилийн хугацаанд хэзээ ч авч байгаагүй ийм л байдалтай байсан. Тэрний цаад талд юу байсан нөгөө л авлигал, хулгай, үл бүтэх юм л байж байсан. Үүнийг бол харин энэ Засгийн газар ил тод болгож, энэ далд эдийн засгийг ил болгож, өнөөдөр зөвхөн Тавантолгойгоос гэхэд 4 их наядыг төсөвт төвлөрүүлж байна шүү дээ. Энэ ажлын үр дүнд ерөөсөө хагас жилийн дотор 1.9 их наяд төгрөгийг. Өмнө нь үе үеийн парламент энэ юу хийх гэдэг чинь бид нарт хэцүү байлаа шүү дээ. Төсвийн тодотгол хийхэд. Энэ жил харин төсөв давж биелсэн учраас ийм бололцоотой байна.

Тэгээд ийм юм мэдэх хэрэгтэй байгаа юм. Энэ Их Хурлын гишүүд энэ ёс зүйнхээ дүрмийг, хуулийг унш, үүнийгээ баримтал. Би та бүхэнд энэ өргөсөн тангаргийн тухай асуудлыг би хэлж өгдөг. Тэгээд байна шүү дээ энэ халдашгүй байдалтай холбоотойгоор би нэг асуулт асуух гээд байгаа юм.

Г.Занданшатар: Асуултад Нямаагийн Энхболд. Их Хурлын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбоотой бас яаж зохицуулагдсан бэ?

Н.Энхболд: Энгийг их олон хүн асууж байгаа юм. Яривал их удаан түүх болохоор юм байгаа юм. Одоогийн хуулиар бол ер нь Их Хурлын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрх хоёрыг жоохон тусгаарлаж, ялгаж салгахгүй бол болохгүй юм байна гэдэг нь сүүлийн 30 жилийн манай парламентын түүхнээс харагдсан.

Маш товчхон хэлэхэд ер нь бүрэн эрх гэдэг бол сонгогчдоосоо авсан мандат байж байгаа эрх. Халдашгүй байдал гэдэг нь тэр гишүүнийг гаднын ямар нэгэн хууль бус дарамт шахалтаас хамгаалж байж, гишүүд сонгогчдынхоо өмнө хүлээсэн үүргээ өөрийнхөө үзэл баримтлалаар чөлөөтэй ямар нэгэн дарамтгүйгээр явуулж байх энэ баталгааг олгож байгаа л хэрэгсэл байгаа юм.

Тэгээд гишүүнээр нь дамжуулж төрийн эрх барьж байгаа Монгол Улсын хувьд Улсын Их Хурал нь үйл ажиллагаагаа бас хэнээс ч хамааралгүйгээр, гаднын, дотнын хүчин зүйлүүдээс хамааралгүйгээр биеэ дааж шийдвэр гаргах энэ боломжийг нь гишүүдийнхээ баталгаагаар дамжиж Их Хурал нь эдэлж байдаг энэ тогтолцооны тухай л яриад байгаа юм.

Одоо манай хуульд бүрэн эрх, халдашгүй байдал хоёрыг ингээд нэг багцлаад, хэрэг төвөг хийсэн гишүүдийн асуудлыг хэлэлцэхэд баримтлах арга хэрэгсэл, зарчим болоод яваад байгаа нь бас жоохон зохимжгүй харагдаад байгаа юм.

Гишүүнийг шалгаж болно, нэгжиж болно, үзлэг хийж болно. Энэ юмнуудыг нь бол илүү чөлөөтэй болгох хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй бол нөгөө бүрэн эрхтэйгээ холбогдчихоор тэр юмыг нь шалгуулах гээд бүрэн эрхийг нь түдгэлзүүлчихээр нөгөө гишүүн хуралдаа орж чадахаа байгаад, гишүүд сонгогчдынхоо өмнө хүлээсэн үүргээ

биелүүлэх ийм боломжгүй болчихоод байхгүй юу.

Тэр нь юун дээр харж байна гэхээр баривчлаад шоронд хийчихээр тэр хүн хуралдаа оролцож чадахаа байчхаж байгаа юм. Бүрэн эрх нь түдгэлзээгүй байж байдаг. Нөгөө гишүүдээс өгсөн юм нь. Ямар тохиолдолд бүрэн түдгэлзэх вэ гэхээр шүүхээр ороод, шийдвэр гараад тэрийг нь Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эргүүлэн татаад буюу тэр хүнийг бүрэн эрхийг нь байхгүй болгож байгаа ийм байдалтай байгаа.

Тэгэхээр бид энэ сүүлийн жилүүдийн туршилага, практикаасаа харж байгаад тэр нэгждэг, шалгадаг бүх бололцоог нь хууль хяналтын байгууллагуудад олгоё. Тэрийгээ үзэж, шалгаж байгаад энэ хүн үнэхээр ийм хэрэг хийчихсэн байна гэдгийг нь нотлуулах хэрэгтэй шүү дээ. Нотолчихвол дараа нь тэгвэл энэ хүн нэгэнт ийм хэрэг хийчихсэн юм чинь бүрэн эрхээ хэрэгжүүлэх тийм ёс суртахууны, бусад хуулийн нөхцөл байдал байхгүй боллоо. Ийм учраас энэ хүнийг шүүхээр оруулаад шийтгэлээ, шийтгэлийг нь Улсын Их Хурал хүлээж аваад бүрэн эрхээс нь, гишүүнээс нь эргүүлэн татаад авах юм байгаа юм. Тэгэхгүй болохоор би дахиад хэлэхэд энэ хоёр холилчихоор.../минут дуусав./

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Би яг саяын таны хэлдэг ийм үндэслэлээр ийм байр суурийг баримталдаг хүн. Энэ Халдашгүй байдлын дэд хорооны гишүүн ч байна. Би ер нь энэ Их Хуралд байсан он жилүүддээ Их Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх нь зүйтэй. Ямар нэгэн байдлаар тийм хүндрэлтэй бишээр шууд шалгадаг байх хэрэгтэй. Аливаа гэмт хэрэгт холбогдсон бол заавал үйлдэл дээр нь биш гэсэн ийм хатуу байр суурьтай байдаг нэг.

Нөгөө талынх нь юм бол ерөөсөө л энэ дээрээсээ л шалтгаална шүү. Энэ дээр байж байгаа цөөхөн хэдэн хүмүүсийн авлигал, хулгай, ашиг сонирхолтой холбоотой улсуудаас болоод л үе үеийн парламентын ард түмнээсээ эрх мандат авсан улсууд өдөр болгон нүүр рүүгээ шороо цацуулж байдаг, ус цацуулж байдаг. Ийм байж болохгүй л гэж би энэ үе үеийн парламентаас би шаарддаг юм байгаа юм.

Өнөөдөр бол Ёс зүйн байнгын хороо бие даасан Байнгын хороо байгуулагдаад Ёс зүйн дүрэм, хуулиа шинэчилсэн найруулгаар батлаад өнөөдөр жишээлбэл I цагийн хоцролттой байдаг үе үеийн парламентад байсан бол яг цагаараа парламент эхэлдэг болсон.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, хууль санаачлагч хариулъя.

Н.Энхболд: Тийм энэ өргөн мэдүүлсэн хуулийн төслийн 45 дугаар зүйлд, 45.1-д нь яг нөгөө халдашгүй байдлыг нь түдгэлзүүлээд шалгаж байх ажлыг нь зөвшөөрөх тухай, 45.2-т нь ямар тохиолдолд бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх вэ гэдгийг нь заагаад, ялгаад, зааглаад оруулчихсан байж байгаа.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн алга байна. Хаслаа.

Нэг гишүүн асуулт асууж, хариулт авсны дараа үг хэлээд санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Ардчилсан улсад тэгээд парламент сайн, муу янз янзын л нэр

хүлээгээд л явж байдаг. Улс орны эрх ашгийг хангасан олон шийдвэрүүд гаргадаг учраас таалагдах ч юм байна, таалагдахгүй ч юм байна. Ийм л замыг туулдаг юм байна.

Харин би энэ удаагийн парламент бол энэ 30 жилийн хугацаанд энэ авлигалын хуулийг үнэхээр энэ Засгийн газраас маш сайн төсөл оруулж ирж, энэ парламент харин шийдэж чадсан ийм гавьяатай парламент гэж би хэлэх гэж байгаа юм.

Нөгөө талдаа энэ төрийн ажил, бизнес хоёр зэрэгцээд явж байсан тэр ашиг сонирхлын хуулийг бас энэ 30 жилд бараг анх удаа гаргаж энэ замбараагүй явж ирсэн зам мөрийг бас тасалсан, ийм хуулийг баталсан ийм гавьяатай парламент гэж бас хэлэх гэж байгаа юм. Засгийн газраас энэ асуудлуудыг зоригтой оруулж ирсэн.

Одоо харин дараагийн 126 бүрэлдэх энэ парламентын зохицуулалтуудын хуулийг бид хэлэлцэж байна л даа. Энэ үеэр би нэг зүйлийг зайлшгүй энэ хуульд тусгамаар санагдаад байгаа юм.

Юу гэхээр улс төрчид ч тэр, улс төрийн намынхан ч тэр сонгогчдын боловсрол гэж их ярьдаг. Сонгогчдын боловсрол энэ сонгуулийн үр дүнд их нөлөөлдөг, цаашилаад улс орны хувь заяанд нөлөөлдөг ийм чухал зүйл.

Гэтэл сонгогчдын боловсролыг балруулдаг, хүчгүйдүүлдэг ийм зүйлүүд бол энэ улс төрчид эд мөнгө, эсэн бусын юм тараах энэ бол бүүр зайлшгүй зогсох ёстой ийм зүйл. Энэ танхимд сонгогдсон хүмүүс, гишүүд хөрөнгө мөнгөөрөө ялгаварлагддаг, мөнгөтэй, мөнгөгүйгээрээ ялгаварлагддаг, мөнгөтэй нь хүний тойнд багтамгүй их мөнгө гаргаж тэр бэлэг сэлт тараадаг, тэр нь сонгогчдод нөлөөлдөг ийм бусармаг юмыг бол энэ парламент бас энэ хуулиараа

бүүр хаагаад өгчхөөсэй гэж би бол бодож байгаа юм.

Одоо 126 болно. 76 байхдаа замбараагүйтэж байсан юм чинь 126 хоёр давхар болоод ирэхээрээ энэ улс орон, энэ сонгогчдын боловсролыг бүүр байхгүй болгоно.

Тийм учраас ер нь цаашидаа улс төр цэвэр явъя гэж бодож л байгаа бол энэ хөрөнгө, мөнгө эд мөнгөнөөс шалтгаалдаг ийм хүчин зүйлүүдийг энэ парламент хаагаад, парламентын гишүүн нь яг тэр хууль тогтоох, иргэд олон нийтээ төлөөлөх энэ үндсэн үүргээ биелүүлж байгаасай. Энийг чинь өөр ямар хуульд оруулах юм бэ? Тусдаа бие даасан хууль гаргалтай биш. Сонгуулийн хуульд оруулаад тэр чинь ганцхан сонгуулийн жил л үйлчлээд байна. Тэр нь үр дүнгүй гэдгийг 30 жил бид нар харлаа. Тийм учраас энэ парламент, энэ Байнгын хороонууд энэ саналыг бас би хүлээж аваасай гэж ингэж бодож байгаа юм. Санал.

Нөгөө талдаа одоо мажоритар, пропорционалиар сонгогдоно. Орон нутгаас сонгогдсон гишүүд энэ орон нутагт ажиллаад ирэх болгонд л ярьж хэлэх юмнууд маш их байдаг шүү дээ. Одоо Пүрэвдорж гишүүн бол нэр устай нь, сумтай нь зарлаад л ингэж байна гэж ярьж байна шүү дээ. Одоо энэ нь байхгүй болчих юм байна шүү дээ.

Тэгэхээр тэр орон нутгаас сонгогдсон энэ 78 сонгогдох гишүүдийн хэлж ярих эрхийг иймэрхүү байдлаар хаах хэрэг байна уу, үгүй юү? Хэрвээ үнэхээр гишүүдийн ярих, хэлэх хугацааг хязгаарлая гэж байгаа бол тэр хоёр өөр тогтолцооныхоо асуудлыг тэрэнд нь тохируулсан өөрчлөлт хийх боломж бололцоо байх уу, үгүй юү? Амьдрал баян шүү дээ. Тэгээд бүх юм гоё, хууль батлаад л гоё хэрэгжиж байгаа юм бас ховор шүү дээ. Хууль чинь амьдрал дээр хэрэгжинэ, хэрэгжихгүй, хөрсөн дээрээ бууна, буухгүй. Энэ орон нутагт

ажиллаж байхад хуулийг хэрэгжүүлэх ч хэцүү, байх ч хэцүү олон асуудлууд байдаг шүү дээ.

Хэрэгжүүлэхгүй болохоор хэрэгт орчих гээд, хэрэгжүүлэхээр шал утгагүй юм хэрэгжүүлэх болчих гээд байдаг. Тэгэхээр энэ асуудал дээр ч гэсэн энэ хоёр асуудал дээр ер нь.../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн, хууль санаачлагч. Төрийн байгуулалтын байнгын хороон дарга хариулна.

Н.Энхболд: Идэрбат гишүүний эхний санал, асуулт бол түрүүн Одонтуяа гишүүний ярьж байсантай яг адилхан санал байна. Бид нар хууль санаачлагчдын зүгээс хэрэв Улсын Их Хурлын гишүүн зөвхөн сонгуулийн сурталчилгаанд оролцох үеэрээ биш, үйл ажиллагааныхаа бүхий л хугацаанд ямар нэгэн тийм бэлэг сэлт тараадаг, элдэв янзын тойруу утгаар хэлбэл авлигал гэж үзэж болох үйлдлүүд гардаггүй байх тухай томъёоллоор саналаа гаргаад, хэлэлцүүлээд явахад бидний зүгээс бол энэ манай үзэл баримтлалд харшилсан гэж үзэхгүй. Дэмжээд явахад бэлэн. Улсын Их Хурлын гишүүд олонхоороо эцэст нь шийднэ биз. Санал гаргаж байгаа гишүүд өөрсдөө хэлэлцүүлгийн явцад зарчмын зөрүүтэй саналуудаа оруулаад, хэлэлцүүлээд явахад бид нар хүлээж аваад, ажлын хэсэг дээрээ яриад оруулж ирэхэд би лав хууль санаачлагчийн хувьд, хувь гишүүний хувьд татгалзах, болохгүй гэж үзэх зүйл байхгүй гэж хэлэх байна.

Үг хэлэх хугацааны хувьд ийм шүү дээ. Түрүүн би бас яагаад гол нь нөгөө бодлогын цөм болсон бүлгүүд дээрээ асуудлуудаа илүү их төвлөрүүлж ярьж байхгүй бол 126 гишүүн яг өнөөдрийн байдлаар бүх асуудлаар үг хэлдэг, бүх асуудлаар цаг авч асуулт асуудаг байвал Их Хурлын үйл ажиллагаа маань их тийм үр дүн багатай, цаг их алдсан болох болов уу гэдэг үүднээс ийм бүлгүүд

дээрээ төвлөрсөн, ер нь авсан суудлынх нь тоотой уялдуулаад цагийг хуваарилж байх тухай ерөнхий зарчмуудыг ярьсан. Түүнээс энэ гишүүдийн үг хэлэх эрхийг хүн болгоны эрхийг хаана гэсэн санаа бас цаана биш. Мэдээж цагийн хугацаа тогтоочихвол бүх гишүүд үг хэлэх бололцоо гарахгүй л байх даа.

Гэхдээ одоо ч гэсэн аливаа хууль хэлэлцэхэд бас 76 гишүүн 76-уулаа хэлдэггүй. Хэлье гэсэн хүмүүс сонирхсон асуудлаараа, санаа зовсон асуудлаараа л үг хэлж байгаа. Хоёр дахин ихэсчихээр энэ цаг улам их алдах болов уу гэж бодоод, Байнгын хороон дээр бас хэвээрээ байгаа шүү дээ. Чөлөөтэй, бүх гишүүд тэр орон нутагт яваад ирсэн асуудлуудаа бүгдийг нь мэргэжлийн Байнгын хороон дээрээ яриад, бүлэг дээрээ ярих энэ тэр бүгд чөлөөтэй байж байгаа. Бүлэг л тэр асуудлуудаа зангидаж чадаад, бодлого болгоод оруулаад ирээд байвал ийм зохицуулалтаар явсан нь дээр юм уу даа гэж бодож, зөв юм уу даа гэж бодож энийг оруулсан. Одоо бас хэлэлцүүлэх явцад дахиад л хэлье дээ бүүр. Гишүүдийн маань эрх нээлттэй байгаа. Ингэхгүй одоогийнхоороо л явна гээд саналаа оруулаад олонх нь дэмжигдвэл явна. Дараагийн Их Хурал тэрийгээ зөв үү, буруу юу, зохистой юу, зохисгүй гэж үзэхээ бас өөрснөө шийдчих ийм боломж нь байгаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг дээр ороод ажиллаж болно. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Бат-Эрдэнэ, Пүрэвдорж нарын гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн суудалдаа сууж бай л даа. Энэ урдуур гүйгээд. Адьшаа гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Улсын Их Хурлын тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Нэг сайшаалтай зүйл бол энэ 20 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал өмнө нь Төрийн байгуулалтын байнгын хорооны харьяанд байсан Ёс зүйн дэд хороог Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо болгож өргөтгөж байгуулсан. Би түрүүн асуулт дээрээ тодорхой хэлсэн. Ерөөсөө л авлигал, ашиг сонирхол, үүнийг дагасан монголчууд ийм баян орон мөртөө баялагтаа эзэн байж чаддаггүй. Өнөөдрийн нийгэмд гарсан бүх болохгүй, хөгжиж дэвшиж чадахгүй байгаа, амьдрал дорой байгаа бүх учир шалтгаан бол энд л байгаа юм. Үүнийг хаанаас эрэх вэ гэхээр дээд, өндөр албан тушаал хашиж байгаа улсуудаас л эхлэх ёстой.

Ялангуяа энэ Улсын Их Хурлын гишүүдээс эхлэх ёстой. Эд нар хамгийн наад захын шаардлага цагтаа, ажилдаа хариуцлагатай байхаас эхлэх ёстой. Хууль санаачилна гэж байна. Хууль санаачлах бол хоёр талтай ойлголт шүү. Энэ чинь үе үеийн парламент энэ хууль боловсруулах, тавигдах шаардлага, холбогдох хууль эрх зүйн зохицуулалтыг шат дараатай гаргасан шүү. Ингэхээс ч өөр арга байхгүй. Гадна, дотнын үндэстэн, компани, аливаа энэ байгууллагад үйлчилдэг, хувь хүнд үйлчилдэг, өөртөө үйлчилдэг, өөрийнхөө бизнест зориулсан энэ хуулийг чинь 20 жил энд сууж байна одоо бид хахираад дийлэхгүй ингээд л гардаг шүү дээ. Бүүр стратегийн том ордуудыг Их Хурлын тогтоол, шийдвэр болгоод л гардаг шүү дээ.

Тийм учраас бол энэ зөвхөн хууль санаачилж байна гэдгээр нэг үзүүлэлт тавина гэдэг бол энэ ээдрээтэй зүйл шүү. Бүүр сая ярих юм бол энэ хулгай луйверынхаа бүх юмнуудыг хамж нийлүүлээд Эдийн засгийн өршөөлийн хууль гаргаад, батлаад бүүр хав цааш нь нууцын зэрэглэлд хадгалаад авсан ийм тохиолдол байгаа шүү.

Тийм учраас би юу гэж сайшааж хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг энэ 20-24 онд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа энэ Улсын Их Хурал өргөжүүлж байгуулсан энэ Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороог үргэлжлүүлж ажиллахаар болж байгаа.

Ялангуяа энэ шатны гишгүүрийг дээрээс нь шүүрдэх энэ зарчмын хүрээнд энэ Их Хурлын гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сахиулж байх ёстой энэ Байнгын хороог ажиллуулж байгаа. Ёс зүйн дүрэм, энэ батлагдсан, шинэчилсэн найруулгаар батлагдсан хуулиа бүрэн хэрэгжилтийг нь хангах ийм Байнгын хороог нь хэвээр нь ажиллуулж байгаа нь энэ маш чухал зүйтэй ийм зүйл юм шүү.

Нөгөө талынх нь хэлэх санал бол энэ улс үндэстнээрээ цахим шилжилт хийж байгаа. *d.parliament.mn* энэ шилжилт бол маш сайн явагдаж байгаа. Үүний зэрэгцээгээр ард иргэдийн энэ мэдэх эрхийг бүрэн хэмжээнд хангаж байна шүү дээ. Өнөөдөр жишээлэх юм бол хэнийх ч гэсэн жишээлбэл Их Хурлын гишүүдийг шууд нэрээр нь цахимаар үзэхэд энэ боловсролын сангийн зээлд холбогдож уу, ЖДҮ-ээс хамаарал бүхий этгээддээ авсан байна уу, эсвэл Хөгжлийн банк, энэ нүүрсний хулгай, өшөө юу байдаг юм энэ юмнуудтай холбоотой байна уу, үгүй юү гэдгийн дараа л гараад ирдэг болсон. Энэ мэдэх эрхийг хангаж байгаа.

Энэ хүрээндээ энэ парламентын хийсэн том ажил бол Хяналт шалгалтын хууль. Өмнө нь энэ Улсын Их Хурлын гишүүн бол иргэд сонгогчдоо төлөөллөө хэрэгжүүлнэ, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцоно, дээрээс нь энэ хянан шалгах чиг үүрэг. Энэ хяналт шалгалтын ажлын үр нөлөө бол туйлын хангалтгүй явж ирсэн. Үүнийг харин засаж, залруулж өнөөдөр энэ авлигал, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэртэй тэмцэж байгаа ажлын нэг хүрээнд энэ хянан шалгах тухай хуулийн асуудал. Энэ

хүрээнд хийгдсэн олон сонсголууд байгаа. Энэ үнэхээр юмыг нь бол дэлгэж тавьж, хаана, хэн ямар хамаарал, холбоотой байна гэдгийг нь бүгдийг нь гаргаж өгч байгаа. Үүний дагуу хариуцлага тооцох энэ ажил явагдана. Үнэхээр энэ дээд талаасаа л ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг ярихгүй бол үнэхээр болохгүй байгаа юм.

Тийм учраас бол харьцангуй энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд нийгэм тэр чигээрээ энэ ёс зүйн тухай асуудал, сахилга хариуцлагын тухай асуудлыг өндөр хэмжээнд ямар ч байсан гэсэн ярьдаг болжээ. Шүүхийн сахилгын хороо байгуулсан хуулийнхаа дагуу. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороогоо аваад үлдэж байна. Сайн .

Өнөөдөр жишээлбэл хувийн хэвшил, Худалдаа аж үйлдвэрийн танхим дэргэдээ ёс зүйн төв байгуулж байна шүү дээ. Энэ чинь үнэхээр сайн жишиг шүү дээ. Ингээд явах хэрэгтэй гэдгийг хэлье. Хуулийн төслийг дэмжиж байгаа гэдгээ хэлье.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа юм байна. Өнгөрсөн хугацаанд энэ Дэгийн тухай хуульд өөрчлөлт нэлээн хэдэн удаа орсон. Орох болгондоо миний эсрэг энэ дэгийг өөрчилдөг. Өөрөөр хэлбэл аль болох л сөрөг хүчний үгийг хэлүүлэхгүй, ард түмний үгийг хэлүүлэхгүй байх ийм зорилготой байдаг.

Ер нь та бүхэн бүгдээрээ л энэ ард түмэн дээрээ очоод сонгогдохдоо яадаг вэ гэх дээр Ганболдоо, Бат-Эрдэнэ аваргаа та нар ард түмэн дээрээ очоод сонгогдох болох дээрээ та бүхний дуу хоолой болж, ард түмнийхээ дуу хоолой болж ажиллана гэж сонгогдчихоод тэгээд яг Дэгийн тухай хуулиар яг тэр ард түмний дуу хоолой болох тэр үгийг

маань хааж боодог ийм зохицуулалтыг оруулж ирж байна л даа.

Би өчигдөр орой 9 цагт Говь-Алтай аймгийн Дэлгэр сум дээр уулзалт хийгээд Чулуунбат гуай үгийг энд хэлнэ гээд л өглөө 10 цаг 5 минут таны хэлсэн үгийг төрд хүргэнэ, энэ хэлэх ёстой газар нь хүргэнэ гэдэг ийм л амлалтыг аваад л ирээд л би үг хэлж байгаа юм. Үүнийг дахиад л дуу хоолой болох тэр үгийг нь ард түмний үгийг дамжуулах тэр юмыг минь хасаж хаяж байгаа юм байна л даа. Тэгэхдээ би дахиад л арга олно л доо. Энэ чинь зөвхөн хууль батлах бол бидний бас нэг л үүрэг.

Гэтэл бид нар бас энэ төрийн бодлогыг тодорхойлох, тодорхой гүйцэтгэх засаглалд чиглэл өгөх, шүүх засаглалд чиглэл өгөх энэ асуудлуудыг бид нар бас тодорхой хэмжээгээр хийх ёстой. Энэ хүрээндээ ард иргэдийн тэр болж байгаа, болохгүй байгаа тэр бүх зүйлүүдийг бүгдийг нь дамжуулах тэр үүргээ бид нар хэрэгжүүлэх ёстой шүү дээ. Би цаашидаа дуу хоолой болох тэр боломж маань хаагдах юм байна л даа. Ерөөсөө энэ надад энэ Сүхбаатар гишүүн бас хэлээд байгаа юм. Ер нь ингээд таны энэ Их Хурал дээр үг хэлээд энэ ард иргэдийн багийн, сумын нэр, багийн нэр, овог нэрийг нь хэлээд энэ үг хэлдэг чинь бол яг тэр Их Хурлын гишүүнийхээ үүргийг биелүүлж, ард түмнийхээ дуу хоолой болох тэр үндсэн ажлаа хийж байна л гэж, хамгийн зөв зүйл юм байгаа юм л гэж зөвлөөд байгаа юм. Бас туршилагатай парламент ч. Бас Идэрбат ч гэсэн хэлж байна.

Тэгэхээр бид нар энэ боломжоо хаана гэдэг чинь бид нар хүмүүсийн үгийг дамжуулахгүй юм бол би тэнд очиж иргэдтэй уулзаад яах юм бэ. Иргэд чинь бид нарыг энэ үгийг минь хэлээд, энийг төрийн бодлогод оруулаад өгөөч л гэдэг зүйлийг хэлж байгаа шүү дээ. Энэ Их Хурал чинь төрийн бодлогыг тодорхойлдог гол газар шүү дээ. Ийм байдлаар энэ хүний үг хэлэх эрхийг хасна

гэдэг бол бас байж болохгүй зүйл гэж би хэлмээр байна. Тэгэхдээ яах вэ аргыг нь олно доо. Ямар ч байсан энэ хуулиудын ажлын хэсэгт би орж байгаа. Энэ дээрээ бас тодорхой тодорхой боломжуудыг нээнэ.

Дээрээс нь жишээ нь, тойрог томссон. Тойрог томсоод ард иргэдтэйгээ яг уулзалт хийж байгаа явцад ядаж цахимаар хуралдаа орох тэр боломжийг нээж өгөх ёстой байхгүй юу. Цахимаар сайхан Их Хурлаа тавьчихсан, наана нь Их Хурлын гишүүн нь иргэдтэйгээ уулзангаа бас үгээ хэлэх тэр боломжийг, нийт ард иргэд оролцох тэр боломжийг л бас нээж өгөх талаар бас саналуудыг оруулна. Батлуулахын төлөө зүтгэнэ. Ямар ч байсан энэ иргэдийн дуу хоолой болох тэр зүйлээ хойш нь тавиулж микрофоноо хаалгана гэж ёстой байхгүй. Харин түүнийхээ төлөө тэмцэнэ.

Г.Занданшатар: Ширнэнбаньд-ийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

Ш.Адьяа: Энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийг бид өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байна л даа. Тэгэхлээр энэ хуулийг ер нь бүхэлд нь дэмжих боломжгүй байна.

Яагаад гэхээр энэ 24 оны сонгуулиар улс төрийн төрийн тогтолцооны шинэ тогтолцоогоор бид Улсын Их Хурал үйл ажиллагаа явуулна. Өнөөдөр энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд зөвхөн нээлт, хаалттай холбоотой энэ асуудлыг л оруулах шаардлагатай байгаа юм. Тэрнээс биш энэ бүрэн эрх нь эрх нь дуусгавар болж байгаа хэт нэг нам олонх болсон энэ парламент дараагийн парламентын дэгийн үйл ажиллагааг бид өнөөдөр урьдчилан харж зохицуулах нь өнөөдөр тийм ёс зүйгүй асуудал байна.

Тийм учраас энэ хуулийн үзэл баримтлалын хувьд ч гэсэн энэ асуудлыг би хэлэлцэхийг дэмжихгүй байгаа юм. Зөвхөн өөрчлөлт оруулъя. Улсын Их

Хурлын чуулганы анхны хуралдааныг ямар журмаар явуулах юм, ямар асуудал хэлэлцэх юм гэдгийг л энэ шийдэх ёстой. Тэрнээс биш тэр дараагийн парламентын хийх асуудлыг энэ хэт олонх байгаа энэ эрх баригчид, бүрэн эрх нь дуусаж байгаа энэ Улсын Их Хурал ингэж хуульчилна гэдэг асуудал бол байж болохгүй. Энэ дээр та нар дүгнэлт хийгээрэй.

Ийм учраас энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжих боломжгүй байгаа гэдгийг илэрхийлье. Харин энэ нэгэнт Монголын төр тогтвортой байх ёстой, үйл ажиллагаа нь үргэлж явах учраас тэр Улсын Их Хурлын 26 гишүүн сонгогдсон, тэр намуудын жагсаалтаар орж ирсэн 48, ард түмний дундаас сонгогдсон 78 гишүүний бүрэн эрхийн эрхийг хэрэгжүүлэх анхны чуулганы хуралдааны дэгийг л энд авч хэлэлцэх ёстой. Тэрнээс биш бусад үйл ажиллагаагаар тэр дараагийн бүрэлдсэн парламент, дараагийн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн эрхийг өнөөдрийн энэ парламент бид хуульчлах нь боломжгүй юм гэдэг ийм байр суурьтай байгааг хэлье. Дэмжих боломжгүй байгаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Адьшаа гишүүнээ санал хураалт явуулах гэж байгаа учраас та гараад явчихна. Энэ Дэгийн тухай хуулийг бол шинэ парламент өөртөө нийцүүлж, зохицуулж шинээр батлах нь бол нээлттэй. Тэгдэг, олон улсын зарчим тэр. Одоо бол Улсын Их Хурлын тухай хууль хэлэлцэж байна. Улсын Их Хурал 126 гишүүнтэй болсонтой холбогдуулаад, 39-өөр санал хураагддаг байсан бол, 8 хүнтэй бүлэг байгуулдаг байсан бол энэ чинь 65-аар хуулиа батлахад ихэвчлэн энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор энэ дэгээ энэ Улсын Их Хурлын тухай хууль органик хуулиа

өөрчлөхгүй бол энэ чинь дараагийн Их Хурал үйл ажиллагаа явуулах боломжгүй болно шүү дээ. Энийг бас залруулж хэлэхгүй бол бас.

Санал хураалт явуулахад бэлэн үү? Энэ Их Хурлын тухай хууль 92 оноос хойш үндсэндээ өөрчлөгдөөгүй, аль ч парламент өөрчлөөгүй. Аль ч олонх байх үедээ ерөнхийд нь боловсронгуй болгоод л яваад байна.

Энэ нөгөө 126 гишүүнтэй болчихсон болохоор чинь бүх структур нь өөрчилж байгаа байхгүй юу. Энэ холбогдох асуудал хүмүүс байхгүй байгаа учраас санал хураалтыг хойшлуулаад дараагийн асуудалд орж байя. Тэр Хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга. Нэгмөсөн энэ гурав асуулт багц асуудал учраас.

14.48 цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг төслийг шинэчлэн найруулах болсон үндэслэл хуулийн төсөлд тусгагдсан зарим зохицуулалтуудын талаар та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд Их Хурал төрийн эрх барих

дээд байгууллага мөн. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэж, 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурал 2023 оны 5 сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан. Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулаад Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж заасан.

Мөн Улсын Их Хурлаас 2023 оны 5 сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 1 сарын 1-нээс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө гэж, Мөн хуулийн 3 дугаар зүйлд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн баталж мөрдөх хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө гээд тус тус заасан байдаг.

Ийм учраас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байхаар заасны дагуу чуулганы нэгдсэн, Байнгын, Дэд, Түр хорооны хуралдааныг яаж зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд тодорхой асуудлуудыг яаж хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаанд зохион байгуулалтын шинжтэй ямар өөрчлөлтүүд хийх шаардлагатай байгааг үзээд энэ зүйлүүдэд тусгасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэглэх явцад зарим зохицуулалтыг илүү оновчтой, тодорхой болгох, нарийвчлах, нэр томъёог нь улсын Үндсэн хууль, бусад хууль, монгол хэлний дүрэмд нийцүүлэх, жигдлэх, хууль зүйн техникийн шинжтэй засвар оруулах практик хэрэгцээ, шаардлага байгааг бас харгалзаж үзсэн болно.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн энэ удаагийн өөрчлөлт, шинэчлэлийг Үндсэн хуулийн хүрээнд шинээр үүссэн зохицуулалтыг харгалзан бусад орнуудын туршилагаас бас тодорхой хэмжээгээр харгалзаж шинэчлэн боловсрууллаа.

Хууль нийтдээ төсөл нь 16 бүлэг, 136 зүйлтэй. Дараах зарчмын шинжтэй зохицуулалтууд тусгагдсан.

Хуулийн шинэчилсэн найруулгаар хуралдааны дэг тогтоох нийтлэг жишигт мэтгэлцээний зарчмыг тусгаж, нам, эвслийн бүлгээс санал, дүгнэлт гаргахдаа үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Байнгын хорооны хуралдаанд хууль, тогтоолын хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгийн үе шатуудыг мэтгэлцэх зарчмаар явуулах зохицуулалтыг тусгасан байгаа. Энэ бид нарын яриад байгаа олон улсын нийтлэг жишиг гээд байгаа бол олон улсын парламентын холбооны гишүүн орнуудын хэмжээний дийлэнх олонх хэсэгт мөрдөгддөг энэ жишигүүдийг харгалзаж үзсэн гэдгийг бас тодотгох хэрэгтэй байх.

Хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үе шатын зохицуулалтыг боловсронгуй болгож, чуулганы хуралдааны тов, дарааллыг тогтоох, түүнийг гишүүд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтуудыг нарийвчилсан. Хуулийн төслийг хэлэлцэх дарааллыг тогтоохдоо өргөн мэдүүлсэн хугацааг харгалздаг

байх. Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг буцаах зохицуулалтуудыг нэмж тусгасан.

Одоо түрүүчийн Их Хурлаас дамжиж ирсэн олон хуулиуд, тогтоолын шийдвэрүүд хэлэлцэгдэхгүй ингээд дамжаад байгаад байдаг ийм зүйлүүд бий. Түүнчлэн Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох Байнгын хороо хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх, хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль, тогтоолын төсөл, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцэж байгаа эсэх, тухайн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд шаардлагатай бүх хуульд зүйл, хэсэг, заалтыг хамааруулсан эсэх асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг байх энэ зарчмыг оруулж байна. Тамгын газрын зүгээс.

Мөн Байнгын хорооны хүсэлтээр хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг байх зохицуулалтыг хийсэн. Урьд нь Байнгын хорооны хүсэлтээр хийдэг ийм зохицуулалт байгаагүй. Эдгээр арга хэмжээнүүдийг цогцоор нь хэрэгжүүлснээр Их Хурлаас хуулийн төслийг чанартай, хийдэлгүй, судалгаа тооцоо сайтай батлагдах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулаад асуулт асуух, үг хэлэх, санал хураах журам, хугацаанд холбогдох өөрчлөлтийг оруулж, хуулийн төсөл хэлэлцэх үед нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилах, асуулт асуух гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдөр хуралдаан даргалагчид

урьдчилан мэдэгдэх зохицуулалтуудыг тусгалаа.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй хуулийн төслийг тодорхой хугацааны дотор дахин өргөн мэдүүлэхгүй байх зохицуулалтыг бас нэмж тусгасан болно.

Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг тогтоолын төсөл, зарчмын зөрүүтэй санал гаргах бол саналаа Байнгын хороонд хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас тодорхой хугацааны өмнө бичгээр тооцоо, судалгаатайгаар, үндэслэлтэйгээр урьдчилсан ирүүлсэн байх.

Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль хоорондын уялдааг хангуулахаар холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болох энэ зохицуулалтыг тусгасан байгаа. Гишүүд мэдэж байгаа байх. Одоо Байнгын хороон дээр ярьж байхдаа санал болгоод л өргөн мэдүүлсэн хуулийн хүрээнд ярихаас биш, үүнтэй уялдаад бас нэмэлтээр ийм хуулийн төслүүдийг хамтад нь хэлэлцүүлэх шаардлагатай юм байна гэж санал гаргах бололцоогүй байсан нь өөрөө бас заримдаа асуудлыг явцууруулах, эс үгүй бол дутуу дулимаг шийдэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж ирсэн гэж үзэж ийм зохицуулалт оруулсан.

Мөн чуулганы хуралдааны үеэр Их Хурлын гишүүдийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, дэг сахихтай холбоотой зарим зохицуулалтуудыг шинэчилж оруулсан байгаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг нь ойлгомжтой болгоход чиглэсэн бүтэц, нэр томьёо, хууль зүйн техникийн шинжтэй зарим өөрчлөлтүүдийг тусгасан. Чуулганы

хуралдааныг зохион байгуулах нийтлэг журам, олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал зэрэг бие даасан бүлгүүдийг нэмсэн.

Эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх, Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх, Улсын Их Хурлын хяналтын сонсголын зохион байгуулалттай холбоотой урьд өмнө хяналтын сонсгол явуулж байсан туршлагаудаас анзаарагдсан зарим зүйлүүдийг зохицуулахаар тооцож бүтцийн хувьд зохих өөрчлөлтүүдийг хийсэн ийм хуулийн төслүүдийг өргөн мэдүүлж байна.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт бас холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсан төслийг та бүхэнд тараасан байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиудын төслийг хэлэлцэх эсэх ажлуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нараас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал I танхимтай, 126 гишүүнтэй байна гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд уг өөрчлөлтөд бусад хууль тогтоомжийг нийцүүлэхээр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 44 дүгээр тогтоолыг баталж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар тогтсон болно.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 126 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үр дүнтэй зохион байгуулах, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй байлгах, асуудлыг ажил хэрэгч, шударга мэтгэлцээний зарчмаар шийдвэрлэх, түүнчлэн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх, оролцоо, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэхдээ дэлхийн зарим орны парламентын үйл ажиллагаанд нутагшуулах зэрэг асуудалд анхаарч хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар гишүүдийн асуулт асуух, үг хэлэх, санал хураах журам, дэг тогтоох олон улсын жишигт нийцсэн мэтгэлцээний зарчимд тусгагдсан хууль тогтоолын төслийг хэлэлцэх үе шатын зохицуулалтыг боловсронгуй болгож, төслийг чанартай, хийдэлгүй батлагдах нөхцөл хангагдсан, чуулганы хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдийн сахилга, хариуцлага нэмэгдэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг ойлгомжтой нэг мөр хэрэглэгдэх боломж бүрдэнэ гэж үзжээ.

Дээрх хуулийн төсөл иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын *d.parliament.mn* цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Байнгын хорооны даргыг сонгох журам, Улсын Их Хурлын өмнөх бүрэн эрхийн хугацаанд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг буцаахгүй үргэлжлүүлэн хэлэлцэх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллыг хэрхэн тогтоох, хуулийн төслийг өргөн мэдүүлэх, тов тогтоох асуудлыг нарийвчлан зохицуулсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлын талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дууслаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Дэгийн тухай хуулийн 132.16-д нэр дэвшигчийн сонсголын талаар байна л даа. Энд ийм ноцтой заалт л харагдаад байх юм. Хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй явуулна. Хэрэв нэр дэвшигчээс үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн тохиолдолд сонсголыг хаалттай явуулж болно гээд энэ чинь яг юу гэсэн үг юм? Жишээлэхэд янз бүрийн ах дүүс, хамаатан садан ч юм уу, авлигын хэрэгт шийтгэгдэж байсан хүн ч юм уу орж ирээд л Байнгын хорооны гишүүдийг миний асуудлыг хаалттай хэлэлцээд өгөөч гээд л дэмжүүлчихвэл хаалттай хэлэлцэгдээд л дэмжигдчих нь байна шүү дээ.

Тэгвэл Улсын Их Хурлаар ер нь энэ нээлттэй сонсгол хийхийн ач холбогдол нь юу байгаа юм? Ямар шалтгаанаар тэр хүн нэр дэвших вэ? Энэ чинь ямар тагнуулын ажилтан биш. Улсын Их Хуралд нээлттэй сонсголоор л нэр дэвшинэ гэсэн байгаа. Үүнийг хариулж өгөөч, ямар шалтгаан байна?

Хоёр дахь асуудал энэ үг хэлэх дээр энэ хязгаарлалтууд байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцээс ер нь энэ янз бүрийн лавлагаанууд энэ хуульчдаас авсан уу? Нэг нь Үндсэн хуулийн цэцэд хандах юм биш биз дээ? Хүний үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх цаг хязгаарлалаа гээд. Одоо бол бүх гишүүд саналаараа ярьж байгаа. Гэтэл бүлэг дээр хуваагдаад манай бүлгээс чи ярихгүй юм байна, чи ярь гээд тэгэхээр нөгөө гишүүн чинь би ярих ёстой шүү дээ гээд, миний хэлэх үгийг хязгаарлалаа гэсэн ийм зүйл гарахгүй юу? Энэ дээр ямар нэгэн хүний эрхийн зөрчил гарна гэсэн, гарахгүй гэсэн

ийм лавлагаа авсан уу? Ийм хоёр асуулт асууя.

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: 132.16-г уншаад танилцуулъя. Хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй явуулна. Хэрэв нэр дэвшигчээс үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн тохиолдолд сонсголыг хаалттай явуулна гэж томъёолсон юм. Ер нь бол зарчмын хувьд бүх сонсгол нээлттэй явж болно гээд. Нэр дэвшигчээс янз бүрийн санал гарах тохиолдлууд байна бас.

Жишээ нь, хувь хүний өөрийнх нь нууцтай холбоотой асуудал байж болно. Өвчин, эмгэгтэй холбоотой асуудал байж болно. Гадаад оронд жишээ нь, элчин сайд, бусад хүмүүсийг томилох асуудалд магадгүй төрийн хар хайрцгийн бодлого гэж бид нар их юм ярьдаг шүү дээ. Тэр хүрээнд би энэ асуултад хариулж болж байна. Тэгэхдээ үүнийг бас ил тод яриад баймааргүй зүйл байна гээд нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэрийг нь хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонх нь зөвшөөрвөл.

Гуравдугаарт болно гэж байгаа юм. Зөвшөөрөхгүй ч байж болно. Нээрээ тийм байна гээд. Тэгье, үүнийг нь энэ хэсгийг нь хаалттай сонсъё гэвэл сонсож болох ийм боломжуудыг нээсэн юм. Ер нь үндсэн зарчим бол нээлттэй гэж байгаа. Онцгой тохиолдлуудад ингэе гэсэн ийм санаа байна.

Бусад газар ийм зүйл, ямар ч байсан бид нар энэ өнгөрсөн 30 жилийн хугацааны түүх, тэр хооронд Улсын Их Хурал дээр асуудлыг хэлэлцэж байхад гарч байсан зарим хүндрэл, бэрхшээл, цаг алдаж байсан үр дүнгүй яриа хэлцэл болж байсан энэ олон зүйлүүдийг харгалзаж үзээд, гишүүдийн тоо нэмэгдсэнийг бас бодолцож үзээд, дээр

нь та ч бас зарим газар явж үзсэн байх энэ олон гишүүнтэй том 300, 400 гишүүнтэй парламентуудын бас олон жилийн туршилага энэ юмнаас харахад бол ингээж бодлогын цөм болсон бүлгүүд дээрээ ерөнхийдөө асуудлуудаа тоймлоод, цэгцлээд ярих нь илүү их үр дүнтэй байдаг нь харагдсан учраас ийм санал оруулж байгаа юм.

Түүрүүн би бас хариулж байсан. Байнгын хорооны хуралдаан дээр бүгдээрээ үгээ хэлэх бололцоонд байж байгаа. Яг одоогийнх шигээ л хэдэн хүн байна бүгд үгээ хэлээд чөлөөтэй явах боломжууд нь бий. Мэргэжлийн Байнгын хороон дээрээ бүх юмаа дэлгэрэнгүй, тодорхой ярьчихсан байхад бол тэр бүхнийгээ дахиад нэгдсэн чуулган, энэ чинь нэгдсэн чуулган дээрх л зохицуулалтыг ярьж байгаа шүү дээ. Энэ бололцоотой нь байж байна гэж үзээд бид нар ийм санал оруулж байгаа юм. Тэгээд үзэл баримтлал нь буруу байна, бүх хүн бүгдээрээ үгээ хэлж байх ёстой гэж энэ Их Хурал үзвэл дэмжээд ингээж батлагдвал ингэд л явах байх.

Дараагийн Их Хурал өөрөө тэгж үзээд бид нар ямар ч хязгааргүйгээр.../минут дуусав./

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Дэгийн хууль дээр хоёр зүйл тодруулъя. Бид бүхэн энэ би дахиад л нөгөө ярьдаг юмаа л ярина. Битгий үг таслаасай гэж бодож байна. Энэ зайлшгүй нөхцөл ялангуяа энэ Засгийн газар хэлэлцээд гамигийн нөхцөл байдал тогтоогдсон үед энэ, би өмнө нь энэ Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санаачлаад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн 7 гишүүн санаачлаад явсан юм тэгээд. Уг нь энэ тов тогтоолгоод аваад явчихсан бол энэ ижил төстэй зүйл санаачлаад олонх нь ч байна уу, цөөнх нь ч байна уу санаачлаад явахад заримдаа болохоор нийлүүлээд, цуг хамтатгаад

хэлэлцээд явчхаж болж байгаа юм. Заримдаа тусад нь орхичхож байгаа.

Тэгэхээр энэ асуудал ер нь яг энэ Дэгийн тухай хуульд яаж орсон юм бол? Эс үгүй бол энэ дээр өөрчлөлтийн тухай асуудал яригдаж байна уу гэдэг ийм тодруулах зүйл байна.

Хоёрдугаарт, энэ хэлэлцэх эсэх дарааллын асуудлыг ойлгож байгаа. Тэр Даргын зөвлөлийн асуудал дээр яригдах байх. Энэ өргөн барих тов тогтоох асуудал дээр ер нь яг хуульчилсан юм байдаг юм уу? Эс үгүй бол би буруу ойлгоод, буруу, зөрүү юм яриад хүн амьтны уур хөдөлгөөд яваад байна уу? Энэ тов тогтоох дээр заалт байдаг юм уу? Байдаггүй бол үүнийг Дэгийн тухай хуульд нэгэнт ярьж байгаа юм чинь оруулж болох уу гэсэн ийм асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хороон дарга хариулъя.

Н.Энхболд: Ер нь энэ Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулиудыг боловсруулахдаа бид нар нэг үндсэн концепц болгож авсан зүйл юу вэ гэхээр аливаа зохицуулагдаагүй юм уу, эс үгүй бол маргаантай асуудлыг аль болохоор хуралдаанд оролцож байгаа гишүүдийнхээ олонхоор шийдээд явах бололцоонуудыг бүх асуудлууд дээр байгаа бүгдээрэн дээр нь байгаа шүү. Байнгын хороон дээр ч байгаа, чуулган дээр ч байгаа. Амьдрал баян болохоор бүх зүйлүүдийг яг ингээд бүрчлэн тэрийг ингэвэл ингэнэ ингэнэ гэхэд бас төвөгтэй л юм. Ер нь бүх хууль тэгж гарч чаддаггүй л байх.

Гэхдээ дахиад хэлэхэд асуудал байвал тэрийг олонхоороо шийдээд явах бололцоонууд бүх газар байж байгаа гэдгийг юуны өмнө хэлчихье.

Нэгтгээд хэлэлцээд явах боломжууд бас байгаа. Одоогийнх шигээ

ижил төстэй, үзэл баримтлалын хувьд ойрд ижил тийм зүйлүүд байвал аль болохоор нэгтгээд хэлэлцээд явах нь Их Хурлын ажил богино хугацаанд үр дүнтэй явахад ч хэрэгтэй. Нэгэнт олон талаас гарч байгаа саналыг тусгаад явах нь зохицуулалтдаа ч ашигтай гэж үзээд явах энэ боломжууд нь байгаа.

Та тов тогтоох тухай асуудлыг бол хоёр дахь удаагаа ярилаа. Байнгын хороон дээр бас барьсан. Яг өнөөдрийн байдлаар тов тогтоох асуудал Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулагдаад явж байгаа юм.

Тийм учраас бид нар яг энэ дотор оруулсангүй. Үгүй яах вэ хэдүүлээ одоо хэлэлцэх явцдаа та зарчмын зөрүүтэй санал оруулаад, үүнийг ерөөсөө тэр юунаас нь хасчихъя, хууль тогтоомжийнхоос биш. Энэ өөрөө их чухал асуудал болчихоод байна. Тийм учраас тэр хуульд биш Их Хурлын дэгийн тухай хуульдаа оруулчихъя гэсэн санал гаргаад олонх дэмжээд явбал учиргүй заавал энэ бол хэлэлцэх журамд ч юм уу, Хууль тогтоомжийн хуульд юм уу, эс үгүй бол энэ хоёрын аль нэгэнд нь энэнд нь заавал байх ёстой гэсэн тийм юм би байхгүй гэж л бодож байна.

Энэ хэд хэдэн удаа давтагдаад гарч байгаа учраас би дахиад хэлье. Их Хурлын дарга өрөө энэ хурлаа зохион байгуулалт сайтай, үр дүнтэй, их эффе́ктивный гэж ярьдаг даа. Тийм явуулах үүднээс бас ерөнхий хуулиудын концепцын хэмжээнд бас асуудлыг шийдэж байх тийм орон зайтай байх хэрэгтэй л гэж би боддог юм. Тэр ч миний энэ хууль боловсруулах үзэл баримтлалын юманд туссан байгаа.

Дээр нь түрүүчийн хэлсэн бүх асуудлыг, бүгдийг нь тохиолдол болгонд хариу өгсөн тийм зүйл, заалттай хууль гаргана гэхээр хэцүү учраас засах арга нь шинээр хууль тогтоомж гаргаад тэд нарыгаа тухай тухайд нь янзлаад явж болно. Эс үгүй бол бас тодорхой Байнгын

хороо удирдаж байгаа хүн ч гэсэн дэг тусгагдаагүй ажлыг аль болохоор олонхынхоо саналаар эвийг нь зохицуулаад явдаг ийм л практиктай ирсэн шүү дээ.

Г.Занданшатар: Туваан гишүүн бас дахин дахин асуугаад байгаа учраас. Одоо бүүр 2004 онд тов тогтоолгох гэсэн хуулийн төслүүд ч өргөн баригдаагүй байж л байдаг юмнууд. Өргөн мэдүүлснээс хойш хэлэлцээгүй өч төчнөөн хуулиуд байж л байдаг. Энэ бол ерөөсөө цэвэр Улсын Их Хурлын зохион байгуулалтын асуудлаас шалтгаалж байгаа.

Хоёрдугаарт, Хууль тогтоомжийн хуульд байсан өөрчлөлт бол Улсын Их Хурлын дарга харин иүүд буцаачихдаг байсан юм. Одоо тэрийг сэргээвэл сэргээж болно. Агуулгын зөрчилтэй байна гээд л. 3.Энхболд 12-16 оны үеийн Хууль тогтоомжийн хуулийн заалтыг. Бид нар харин Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхэд халдаад яах вэ гээд авсан юм.

Гэхдээ агуулга, бүрдүүлбэрийн хяналт хийх хэлбэрээр. Агуулгын хяналтаар энэ бол зөрчилтэй байна. Бусад хуультай, Үндсэн хуультай зөрчилтэй байна гэвэл иүүд буцаагаад хууль санаачлагч буцаачихдаг тийм Хууль тогтоомжийн тухай хуулийн заалтыг бид хүчингүй болгочихсон юм. Тэрийг харин бараг сэргээмээр юм байна лээ. Хууль тогтоомжийн хууль дээр тэрийг сэргээгээд Үндсэн хуулийн зөрчилтэй ч юм уу, Жишээлбэл 1.2 их наяд төгрөгийн асуудлыг Засгийн газраас санал авахгүйгээр, болохгүй гээд Дэгийн хууль, Төсвийн хуульд байгаа байхгүй юу. Төсөвт нөлөөлөх холбоотой хуулийн төсөл, заалтыг заавал Сангийн яамны зөвшөөрөл, Засгийн газрын саналыг авсан байна гээд Үндсэн хуульдаа заалттай. Ийм хуулийн зөрчилтэй зүйлүүд олон бий. Энийг бол нэг мөр болгох нь зүйтэй юм байх.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нэг асуулт байна. Тойрог томсож байгаа. Тийм учраас энэ тойргоор явж ажиллаж байгаа хүмүүсийн ачаалал маш их нэмэгдэх юм байна. Нэг сонгогдож авчхаад алга болчихдог хүмүүс байдаг. Тэд нар бараг тойргоороо явахгүй байх. Тойргоороо явдаг хүмүүс тэр том тойрог дээр явдаг, буцаад ирэлтээ биш, чуулгандаа суултай биш ийм зовлонтой асуудалтай. Нэг явахаар чинь нэлээн хэдэн сумдаар явж, тойрч таараад байна. Энэ тохиолдолд цахимаар оролцох ямар боломж байна? Яг тэр иргэдтэй уулзалт хийгээд явж байх үед? Жишээ нь, КОВИД-ын үед цахимаар оролцож байсан. Тэр бол хориотой байсан учраас нийтлэг хийгдэж байсан.

Ер нь 1, 2 хүн томилолттой байлаа гэх тохиолдол тэр нь тойрогт иргэдтэй уулзах тохиолдолд, аль эсвэл гадаад явж байхад биш шүү дээ. Иргэдтэй уулзаж байх тохиолдолд цахимаар оролцуулах тэр боломж ямар байдаг юм? Тэр тал дээр асуулт асууя.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн асуултад хариулъя.

Н.Энхболд: Бид нар үзэл баримтлалдаа ерөнхий санаа нь бүх гишүүд нэг дор байж байгаад танхимд байна уу, эс үгүй бол зүүмээр тойроод нэг дор байж байгаад хурлаа хийж байх тухай ийм л үзэл баримтлалаар оруулсан. Түүнээс энд тэнд тарж явж байгаа хүмүүсийг 1 юм уу, 2 хүн тэндээсээ заавал тэрэндээ оролцож байх тэр үзэл баримтлалаар хандаагүй гэж хэлье.

Ер нь ийм шүү дээ Пүүжээ гишүүнээ та бодоод үзээрэй. Жишээ нь, өнөөдөр чинь Монгол Улсын Их Хурал 76 гишүүнтэй байж байгаад 57 нь ирцдээ ирчихсэн байхад Улсын Их Хурал бүхэлдээ үйл ажиллагаа явуулах легитим байдал нь үүснэ гээд тогтчихсон байгаа шүү дээ. Нэлээн олон жил ингээд яваад

ирчихсэн. Үүний цаана ямар санаа байна гэхээр тэг гэж байгаа юм биш.

Гэхдээ бүрэлдэхүүн дутуу байсан ч гэсэн 1, 2 гишүүн байхгүй байсан ч гэсэн тэр байтугай 10 хэдэн гишүүн байхгүй байсан ч гэсэн Улсын Их Хурал үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадамжтай, гарч байгаа шийдвэр нь заавал дагаж мөрдөх эрх зүйн чадамжтай гэдэг ийм агуулга, логик орсон байгаа учраас тэр.

Жишээ нь, би 1, 2 гишүүн хөдөө яваа тэр л биз гэж хэлж байгаа юм биш шүү. Энэ том агуулгын хүрээнд заавал бүгдээрээ байцаж оролцож байх шаардлага байхгүй гэдгийг урьд нь тогтоогоод ирсэн үзэл баримтлалаараа яваад ирсэн учраас бид нар энэ удаа үзэл баримтлалтай бас ерөөсөө гишүүн болгон байгаа газраасаа заавал оролцож байх шаардлага тавихыг бодоогүй. Тийм учраас энэ яг энэ төсөл дотор тийм заалт ороогүй гэдгийг л хэлж байна.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Дэгийн тухай хууль бол Улсын Их Хурлын чуулганы тоглоомын дүрэм гэж ойлгож болно. Тийм учраас ямар тоглоомоор гэдэг юм уу, ямар дэгээр хуралдаан явах юм бэ гэдгийг маш тодорхой заасан байх ёстой гэж. Би энэ 41.5.2 дээр зарчмын зөрүүтэй саналын асуудал дээр байгаа юм Энхболд даргаа, гишүүнээ ингээд гишүүдэд хуулийн төслийг тараадаг. Одоо 126 гишүүнтэй болчихвол 1 Байнгын хороо 25 гишүүнтэй байх юм байна. Тухайн эрхлэх Байнгын хороогоор нь тухайн хуулийн төсөл орж ирдэг. 25 гишүүн тухайн Байнгын хороонд харьяалагдаад тухайн хуулийн төсөлтэй танилцаад бусад үлдсэн бараг 100 гишүүн нь тухайн харьяалагдаагүй Байнгын хорооны гишүүд нь тухайн хуулийн төсөлтэй нэг бүрчлэн танилцах бололцоо боломж их хомс байгаа байхгүй юу.

Хуулийн төсөл ороод ирдэг. Тэдийн тэдийн тэд дэх заалтыг тэгж өөрчилсүгэй гээд л ингээд л ороод ирдэг. Яг үнэнийг хэлэхэд чуулган дээр орж ирэхээр аль хуулийн аль заалтыг, юу байсныг ямар болгож байгаа гэдгийг нарийн мэдэх бололцоо ерөөсөө байхгүй. Ороод ирсэн, өргөн барьсан энэ хуулийн гишүүдэд тараагдсан төсөл дээр тэрийг уншаад хэн ч ойлгохгүй. Яах вэ тэр хуулийн ажлын хэсэгт орж ажилласан гишүүд л нөгөө шигтгэсэн хувилбараар танилцаж байж ойлгох, мэдээлэл авах бололцоо боломж байгаа. Би бол юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ зарчмын зөрүүтэй саналыг гишүүдэд тараахдаа яг энэ шигтгэсэн хэлбэрээр нь энэ заалтыг ингэж хасаж байна, ингэж өөрчилж байна, ингэж нэмж байна гэж маш тодорхой явж байхгүй бол гишүүд яг үнэнийг хэлэхэд заримдаа тэр Байнгын хороонд харьяалдаггүй гишүүд нь тухайн хуулийн заалттай холбоотойгоор яг ямар өөрчлөлт орж байгаа гэдэг талаар бас тодорхой мэдэх бололцоогүй байна. Тэрийг яаж тодорхой болгож өгөх вэ гэдгийг энэ дээр хариулт өгөөч гэж нэгд.

Хоёрт, нэгэнт ингээд 126 гишүүнтэй болчихоор хүн болгон үг хэлэх бололцоо, боломж хомс байна гэж хязгаарлаж байгаа юм байна. Тэгвэл тухайн хуулийн төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй саналтай байгаа гишүүд байвал олон байвал, тэр намуудад өгсөн 5, 10 минутад нь багтахгүй байвал бусад үг хэлмээр, зарчмын зөрүүтэй санал хэлмээр байгаа гишүүдийг тусгайлан бас өөр үг үзэл бодлоо илэрхийлэх тэр бололцоо, боломжийг гаргаж олон гишүүн бас өөр зарчмын байр суурьтай байвал тэрийг тухайлан бас авч хэлэлцдэг байх тийм хөшүүрэг юу байна вэ?

Жишээ нь, би энэ дээр 10, 20 минутад намд өгсөн санал цагт ороогүй байна шүү дээ. Би бас үгээ хэлмээр байдаг. Тэгвэл хэвлэлийн бага хурал нэгдэж нийлж тийм зарчмын зөрүүтэй

саналтай гишүүд нэгдэж байгаа тэрийг нь бас Их Хурал хүлээж авдаг байх тийм хөшүүрэг байна уу, үгүй юү? Байж болох уу, үгүй юү гэдэг ийм хоёр асуулт дээр та хариулж өгөөч.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Нэгдүгээрт, тэр би жишээ нь, хууль санаачлаад, ажлын хэсэгт ороод юм уу, эс үгүй бол Байнгын хороон дээр аливаа хууль дээр ажиллахдаа ажлын алба эд нараас яг таны хэлсэн шиг заавал тэгүүлж авдаг юм. Энэ орж ирж байгаа хуулийн энэ заалтын шинэ юм бол яагаад ийм орж ирж байгаа юм? Хуучин юм бол хуучин заалт, хуучин хуулийнх нь заалт нь аль юм? Шинэ нь энэ шалтгаан нь энэ гээд ингэж оруулж энэ зүгээр гишүүнийхээ хувьд бас. Ер нь тэрийг юу яаж болно. Энийг дотоод журмаар ямар нэгэн байдлаар энд оруулаад юу яасан ч болно. Заавал шинэ, хуучин харьцуулсан юмнуудыг шигтгэж оруулж байж байж болно. Цаас маш их орно. Тамгын газрын ажил бас нэлээд ихсэх байх, зардал жоохон бага зэрэг нэмэгдэх байх. Ер нь бол үнэн л дээ бүх орж ирж байгаа хуулиудыг жигд үзээд, бүх юуг нь яахад бас амаргүй л байдаг юм.

Ер нь гишүүн хэдэн хууль олж ирнэ болж өгвөл бүгдийг нь судлаад бүгдийг нь харьцуулж үзээд, ажиллаж чаддаг ийм л чадавхтай, нөөцтэй, цагаа зөв зарцуулж чаддаг байх нь л зөв болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхдээ тэр рүү нь чиглүүлээд хаяж байгаа юм биш. Заавал ийм харьцуулсан юм ороод ир гэвэл уг нь гишүүний өөрийнх нь л хийх ажил л даа. Тэр бол яг үнэндээ бол. Энэ чинь хуучин нь юу билээ, энэ яагаад ийм юм ороод ирэв гэдгийг нь судлахад болно. Жоохон зардал, цаг, ажил илүү юм л гарах байх нэгдүгээр асуултын хувьд бол. Тийм, Дэгийн тухай хууль. Дэгдээ биччихсэн ч болно. Эс үгүй бол Тамгын газраас журмаар зохицуулаад гишүүнд өгөхөд заавал ингэж байг гээд өгөхөд бол

би болохгүй юм байхгүй л гэж бодож байгаа юм.

Яах вэ бид нарын энэ боловсруулсан төслийн үзэл баримтлал бол ерөөсөө аль болохоор юмыг бодлого дээр төвлөрүүлж байя, тэр бодлого нь бүлгүүд дээрээ зангидагдаж байя гэдэг ийм л үзэл баримтлалаар хийсэн юм л даа. Хоёр л зам байгаа. Эс үгүй бол бүгдээрээ үг хэлдэг болно. Эс үгүй бол ямар нэгэн хязгаарлалт хэрэглэдэг болох. Бид гурав бол ийм тодорхой хязгаарлалттай байж, их бодлого дээр төвлөрч ярьдаг, хүн болгон өөрийнхөө байр суурийг ярьдаг биш. Ер нь ийм бололцоонууд байдаг. Бүлгүүд бий болчихлоо. Цаана нь гишүүд үлдлээ гэхэд албан бус ийм бас бүтцүүд бий болчихдог шүү дээ. Хэдийгээр Их Хурлын албан ёсны бүтцийн байгууллага биш ч гэсэн лобби бүлэг гээд байгуулчихдаг гэх мэтчилэн ийм зүйлүүд. Үүгээр дамжуулаад хэрэглэх аргууд байж байна.

Гэхдээ энэ дээр бол ийм сонирхлоороо, байр сууриар нэгдсэн гишүүдийн бүлгээс бусад зохион байгуулалтыг Улсын Их Хурлын албан ёсны.../минут дуусав./

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би энэ хуулийн төсөл дээр байна шүү дээ 9 дүгээр зүйл. 9.1-д нэгдсэн хуралдаанд асуулт асуух, үг хэлэх нийт хугацааг Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийн бүлэг, түүнд харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлж олгоно гээд байгаа юм. Тэгэхээр энэ ямар хугацаа гэж ойлгох юм бэ?

Гэтэл бол 11 дүгээр зүйл мэтгэлцээн явуулах ерөнхий журам гээд заачихсан байгаа. Энэний 11.7-д 2 цаг, шаардлагатай гэж үзэх юм бол 1 цагаар сунгаж болох тухай заачихсан байгаа. Ийм зүйлийг нэгдүгээрт асуух гээд байгаа юм.

Хоёрдугаарт, энэ жишээлэх юм бол 14, 15 дугаар зүйл хуралдааны дэг сахиулах, хуралдааны дэг зөрчсөн гишүүд хүлээлгэх хариуцлага гээд байгаа юм. Энэ ер нь хуралдааны Улсын Их Хурлын тухай хууль ч байна, Хуралдааны дэгийн хуульдаа энэ батлагдсан Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн тухай хуулийн нарийвчилсан заалтуудыг хэр анхаарч авч үзсэн бэ гэдэг ийм зүйлийг би хэлэх гээд байгаа юм.

Тухайлах юм бол, Улсын Их Хурлын гишүүний дүрэм байгаа, хууль. 3 дээр гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага гээд. Энэ 3.3 тодорхой заачихсан. Гишүүн өвчтэй, чөлөөтэй, албан томилолтоор ажиллахаас, бусад тохиолдолд чуулганы нэгдсэн, Байнгын, Дэд, Түр хорооны хуралдаанд товлосон цагтаа хугацаандаа ирж оролцох үүрэгтэй гээд үүрэгжүүлчихсэн байхгүй юу.

Энэ хууль чинь бол нэлээн сайн нарийвчлаад өгчихсөн шүү дээ. Энэ хууль, дүрэм энэ юмтайгаа нөхдүүд маань ер нь жаахан танилцахгүй. Тэр байтугай Их Хурлын гишүүнийхээ энэ өргөсөн тангаргийг ч мэддэггүй улс байна лээ шүү дээ энэ чинь. Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмний элчийн хувьд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт улс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэн, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлигал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлье. Хэрвээ энэ өргөсөн тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ гээд л ингээд л заачихсан юм. Тэгэхээр энэ юмаа сайн мэдэх хэрэгтэй байна. Энэ үүрэгжүүлсэн юмыг нь, одоо энэ шинэ хуулийн дээгээр үг хэлэх хугацаа ер нь үг хэлэх хүмүүсийн тоог нэлээн хязгаарлаад өгчих юм байна.

Тэгэхээр хамгийн гол нь энэ хүмүүсийн яг ажилдаа хариуцлагатай байх, цаг хугацаандаа байх, идэвх оролцоогоо хангахад нь ямар хөшүүрэг,

зохицуулалтууд байгаа вэ гэж? Улсын Их Хурлын гишүүний дүрэм, хуулиар бол энэ 3 дугаар бүлэгт 3.9 жишээлбэл, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлоор хэн нэгэн хүн, хэсэг бүлэг хүмүүс, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжихийг хориглохоор бүүр заагаад өгчихсөн. 3.14-д гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачилж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дараа тухайн хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын хуралдааны хуралдааны хэлэлцүүлэг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллахыг хориглоно гэх мэтчилэн.

Энэ нөхдүүд чинь бол олон хууль санаачилсан нэртэй үе үеийн парламентад, дандаа энэ ямар нэгэн аж ахуйн нэгж, байгууллага бүүр үндэстэн дамнасан компани, корпорац бүүр сүүлдээ энэ чинь гадаадын тусгай албадад холбоотой байсан, уулзаж байсан, гадаадын байгууллагуудад үйлчилж байсан, тэднээс шан харамж авч байсан, сонгуулийн зардал, мөнгө гаргуулж байсан гэх мэт өчнөөн олон асуудлын юмнууд байгаа шүү дээ. Энэ бүх юмыг хаагаад өгчихсөн. Энэ ёс зүйн дүрэм, энэ хуулиа, энэ Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулиудтай хэр холбоотойгоор авч үзсэн бэ гэдэг юмыг, нөгөө хууль хоорондын зөрчил, салангид байдал юунууд чинь зөрчил дагуулдаг шүү дээ. Би тэр талаас нь юм асуух гээд байгаа юм.

Г.Занданшатар: Одоо Хаянгаагийн Болорчулуун гишүүн. Энэ чинь асуулт. Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын дарга хариулна. Чухал асуулт.

Н.Энхболд: Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журмын талаар дурдсан байгаа.

9.1 дээр хууль тогтоолын төслийн төрөл, онцлогийг харгалзан, төрөл онцлогийг харгалзаад тухайн төслийг

чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг зөвлөл тогтооно. Тэгээд нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг суудлын тоонд нь харьцуулаад нам бүлэгт. Тийм.

Тэгэхээр ингэж байгаа юм Бат-Эрдэнэ гишүүнээ ер нь төрөл онцлогийг харахад энэ зөвлөл гэдэг нь Даргын дэргэдэх зөвлөлийг хэлж байгаа юм. Даргын дэргэдэх зөвлөл бол дарга, дэд дарга нар, бүлгийн дарга нар, Байнгын хороодын дарга нар, Тамгын газрын дарга орсон хуулийнхаа том, бага, ач холбогдол багатай хууль гэж байхгүй. Ер нь том, бага, хамрах хүрээ, үйлчлэх хүрээ энэ юмнуудыг нь харгалзаж байгаад энэ хуулийг нийтдээ юу гэдэг юм 8 цаг хэлэлцэнэ ч гэдэг юм уу, 4 цаг ч гэдэг юм уу. Тэр нийт хугацаагаа суудал авсан тоонд нь пропорцлоод хуваачаад, тэрийгээ бүлгүүд нь, дотроо эс үгүй бол сул гишүүд нь дотроо яаж хуваарилахаа өөрснөө бас яриад тогтоод, энэ удаа би хэлье, энэ асуудлаар чи ярь гээд явах ийм бололцоотой байдлаар үзэл баримтлалаа хийж оруулсан юм. Олон оронд ийм байна. Энэ нь бас амжилттай сайн хэрэгждэг юм байна лээ.

Мэтгэлцээний хувьд бол бүүр тусгайлан заачихсан юм. Аливаа асуудал жишээ нь өнөөдөр бид нар хэлэлцэх асуудлаа хэлэлцэж, энэ дээрээ ер нь сайн ярья гээд. Тэр асуудлыг хэлэлцэхээс тусгайлан зориуд нэлээн илүү үндэслэлтэй зөвхөн тэр асуудалдаа төвлөрүүлж ярихын үүднээс нам, эвслүүдээс гарсан саналын дагуу мэтгэлцээн явуулъя. 2 цаг хийе. Бид нар ингээд хуралдаж байгаад мэтгэлцээн гэвэл Занданшатар дарга одоо мэтгэлцээн явуулна, яг энэ асуудлаар гээд 2 цагийн чөлөө өгөөд, танхимдаа эндээ сууж байгаад 2 цаг нөгөө асуудлаараа тал талаасаа мэтгэлцээд, тэндээс бол шийдвэрээр гарахгүй. Хүмүүс л байр сууриа яаж илүү ойлгуулах вэ гэдэг үүднээс ярьж байгаа юм. Тэгээд үргэлжлүүлээд явбал шаардлагатай гэвэл дахиад жоохон сунгах ийм

бололцооны тухай цоо шинэ зохицуулалт орж ирж байгаа юм.

Ерөнхий цагийн хувьд бол дахиад хэлье. Хэлэлцэж байгаа асуудлынхаа төрөл, онцлог, цар хүрээ, хамрах хүрээ юмнаас шалтгаалаад Даргын зөвлөл дээр ярьж шийдээд дотор нь хуваарилаад явъя гэсэн ийм л санаан доор, үзэл баримтлалын доор боловсруулсан юм.

Сахилга баттай холбоотой, ёс зүйтэй холбоотой олон асуудал дээр санал нэн байгаа. Бид нар ёс зүйн дүрмээ гаргасан, баталсан. Энэ Их Хурлын бас ёс зүйн хуулиа хийсэн. Ер нь 30 жил хийгээгүй байсан ажлыг л хийсэн. Хэдийгээр яг ёс зүйг хуульчилна гэдэг өөрөө их маргаантай асуудал байдаг ч гэсэн бид ямар ч байсан дундын хувилбаруудыг олоод хуулийн хэмжээнд аваачиж тавиад үүнийг хүн заавал уншиж байх, мөрдөж байх ийм зохицуулалт болгочихсон байж байгаа. Аливаа хууль бол бичсэн, бичигдээгүй.../минут дуусав./

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун.

Х.Болорчулуун: 90 оноос Монгол Улс 92 оноос парламентын засаглалтай болсон. Тэгэхдээ энэ 24 оны парламент бол шал өөр тогтолцоо бүхий шинэ парламент үүснэ. Анх удаа олон гишүүнтэй, 126 гишүүнтэй дотроо бол бас намын жагсаалтаар болон тойргоос сонгогдсон ийм байдлаар гишүүдийн ялгавартай ийм парламент үүснэ. Тэгэхээр энэ хэрээр бас нийт 126 гишүүд дотроо үүрэг, хариуцлага харилцан хүлээх үүрэг хариуцлагын хувьд бол бас өөр өөр байна.

Тэгэхээр энэ дээр мэдээж туслах, бие төлөөлөгч, зөвлөхийн тоо ч харилцан адилгүй байх нь зүйтэй нь мэдээж. Түүнээс гадна 126 гишүүн болохоор хүн болгон үг хэлж хуучин 76 шиг чадахаа болино. Энэ дээр бол намын бүлгээс, мөн хуулийн ажлын хэсэгт оролцсон байдлаас

болж мэдээж үг хэлнэ. Ялангуяа энэ дээр тойргоос сонгогдсон гишүүд бол бас илүү давамгай үг хэлэх ийм байдлыг, тойргийн эрх ашгийг, ард иргэдийн санал, гомдол бүх юм тойргийн гишүүдээр дамжиж ирнэ шүү дээ.

Тэгэхээр үг хэлэх гишүүний хувьд намын жагсаалтаар орох, гишүүдээс арай өөр байх талаар тусгасан зүйл байна уу? Байх ёстой шүү гэж бодож байна шүү. Энэ дээр хариулж өгөөч.

Хоёрдугаарт, ажлын хэсэгт орж ажилламаар байна. Ажлын хэсэгт орж ажиллая.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Нямаагийн Энхболд гишүүн асуултад хариулна.

Н.Энхболд: Тийм бид нар. Энэ шинэ Их Хурал зөвхөн би тэгж ойлгож байгаа. Бас хууль санаачлагч ч гэсэн тэгж ойлгоё. Энд зөвхөн тоо нь өөрчлөгдсөн асуудал биш. Энэ цоо шинэ бүтэц, зохион байгуулалт, магадгүй цоо шинэ агуулгаар үйл ажиллагааг нь явуулах. Ер нь бид өөр дээрээ жишээ авахад энэ үндсэндээ 76 гишүүнтэй байсан Улсын Их Хурлын үе дуусаад, Монголын парламентын түүхэнд цоо шинэ үе эхэлж байгаа. Ийм тооны хувьд ч тэр, үйл ажиллагааны зохион байгуулалт, асуудлаа яаж хэлэлцдэг агуулгын хувьд ч гэсэн их өөр ийм хурал болж байгаа учраас миний хувьд энэ Монголын парламентын түүхийн хоёр дахь том шатыг эхлүүлсэн ийм том шийдвэрүүд бид гаргасан. Одоо тэрийгээ яаж цааш нь амьдралд хэрэгжүүлэх вэ гэдэг тоглоомын дүрмээ ярьж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр Болорчулуун гишүүнтэй санал нэг байна. Энд бид нар Их Хурлын ажилд, Их Хурлыг их өөр нүдээр харж, иргэд сонгогч ч гэсэн өөр нүдээр харж дүгнэж байх явах ёстой юм байна лээ гэж бодож байна.

Тойрог, жагсаалт хоёрын хувьд бол бид нар Үндсэн хуулиа л барьж байгаа. Үндсэн хуулиар Монгол Улсын Их Хурлын гишүүн бол нийт ард түмний элч. Тойргоос сонгогдоно уу, жагсаалтаар сонгогдоно уу бүгд адилхан эрхтэй, бүгд адилхан санаа зовох юмтай, бүгд адилхан хэлэх юмтай ийм л улсууд. Түүнээс тойргоор яваагүй нь хөдөөгийн асуудлыг мэдэхгүй, хөдөө байгаа нь тойргоос сонгогдсон нь улсын нийт асуудлыг мэдэхгүй гэж ингэж ойлгож болохгүй. Үзэл баримтлал маань юу вэ гэхээр нэг л Монгол Улсын Их Хурлын төлөөлөгч юм бол ард түмний төлөөлөгч, яг адилхан эрхтэй, яг адилхан үүрэгтэй, яг л адилхан хариуцлагатай байх ёстой гэдэг үзэл баримтлалын хүрээнд энэ зүйлийг хийсэн.

Тэгэхээр өөр өөр тойргийн гишүүн ийм байна, нэрээс жагсаалтын гишүүн ийм байна гэж ялгах боломж байхгүй л гэж үзэж байгаа. Тийм тийм учраас оруулаагүй, тийм заалт оруулаагүй. Хүлээж авахад ч болохгүй, олон улсын парламент ч тийм юм байхгүй. Байхгүй ээ. Би хувийн юм хэлэх гэсэнээ өөрийгөө магтчих болчихлоо болилоо.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсэг дээр ороод саналаа хэлээд гадна, дотнын туршилагаа судлаад ярьж болно. Манай хуучин Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Өлзийсайханы дэлхийн маш олон улсуудын Дэгийн хуулийг харьцуулаад хийчихсэн судалгааны ном гишүүдэд тараагдсан байгаа шүү дээ. Тэрийгээ сайн үзээрэй. Ийм зузаан маш сайн ном байгаа. Маш сайн судалгааны ном байгаа. Тэн дээр энэ бүх зарчмууд байгаа.

Байнгын хорооны саналаар. Санал хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүд.

Жигжидийн Батжаргал
гишүүнээр тасаллаа. Жигжидийн
Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: *Байнгын хорооны хурал давхцаад түрүүн асуулт асуух ирцэд орчихсон байсан асуултаа асууж чадсангүй. Тийм учраас санал хэлчихье.*

Үзэл баримтлалынх нь хувьд энэ Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулийг аль алийг нь дэмжиж байгаа.

Тэгэхдээ хэлэлцүүлгийн түвшинд анхаармаар зүйлүүд байгаа. Биднүүсийн энэ Дэгийн хууль өөрөө яг энэ холимог системээр сонгууль явуулдаг улс орнуудын Дэгийн хуультай ер нь хэр нийцэж байгаа гэдэг асуудал байгаад байгаа юм. Хэдийгээр намаас нэр дэвшиж ард түмнээс мандатаа авч байгаа. Тийм учраас тэр ард түмний эрх ашгийг хангасан, үзэл бодлыг илэрхийлсэн дуу хоолой энэ хууль тогтоох дээд байгууллагын танхимд уул нь явж байх ёстой.

Тийм учраас хязгаарлалт хийнэ гэхээр сонин. Хязгаарлалт хийхгүй гэхээр бас нүсэр. Ямархуу байдлаар зөв зохицуулж, жин банг нь олж, балансыг нь ааруулах вэ гэдэг л асуудал бидэнд байгаад байгаа л даа. Үүнийгээ хэлэлцүүлгийн шатдаа их анхаарах ёстой. Энэ хэт хумигдчихвал чуулганы ирц, идэвх оролцоонд тааруу юм болж хувирна шүү. Тийм учраас үүнийг нэлээн бодох ёстой гэж ингэж хараад байна.

Би бол бодож байгаа. Тэр тойргоос сонгогдсон 78 гишүүн ер нь арай л ахиул дуугарах ёстой. Тэр бол ард түмний дуу хоолой энд явж байгаа. Намын нэгдсэн бодлогоороо сонгогдсон улсууд намынхаа бодлогод захирагдаж тэр намын бүлгийнхээ түвшинд үгээ хэлж явах асуудал нь байх ёстой болов уу гэдэг ийм зүйл энэ дэгээр зохицуулагдах болов уу гэж ингэж хараад байгаа гэж.

Хоёр дахь зүйл, Дэгийн хуульд бас анзаармаар юмнууд байгаад байгаа. Хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үеүдэд хуулийн үнэхээрийн хоорондоо зөрчилтэй, хийдэлтэй юм байна гэдгийг мэдсээр байж дэгийн энэ хайчинд ороод яаж ч чадалгүй гаргачхаад байгаа зарим зүйлүүд байгаад байгаа юм. Тэр Нийслэлийн түгжрэлийг бууруулах хууль, түүнийг дагасан тэр үл хөдлөх хөрөнгийн татвар энэ тэр гээд энэ хуулиуд чинь хоорондоо зөрчилтэй гарчихсан шүү дээ. Яг энэ ийм зөрчилтэй болчихлоо гээд хэлээд байхад одоо дэгээ хуулиараа ингэж явна, үүнээс өөр боломж байхгүй гээд мэдсээр байж тийм хууль хоорондын зөрчилтэй асуудлыг гаргачхаад байгаа юм байгаад байгаа юм. Үүнийг ер нь цаашид ямархуу байдлаар авч үзэж ийм нөхцөл байдал үүслээ гэвэл тэрүүн дээр ямар шалгууртайгаар асуудлыг дахиж авч үзэж шийдэж байх юм бэ, эцэслэх хүртлээ гэдэг энэ харилцаа юмнуудыг нь их тодорхой болгож оруулахгүй бол ийм зүйлүүд гарч ирээд байгаа юм.

Тэр Хууль тогтоомжийн хуулиар зохицуулна л гэж яриад байгаа юм. Зарим нэг хуулиудыг дагуулаад анхдагч хууль оруулаад ирчихдэг, ямар ч уг асуудалтай холбоогүй хуулиудын өөрчлөлт оруулаад ирчихдэг юм эд нарыг болих ёстой.

Дээр нь энэ маш шуурхай журмаар шийднэ гэж асуудал орж ирээд байдаг юм. Эд нарыг ер нь яаж зөв зохицуулах юм бэ гэдэг юмыг энэ дэгэн дотор, хэлэлцүүлгийн түвшинд, тал бүрээсээ ярилцаж энэ он удаан жил парламентын гишүүнээр суусан энэ олон сайхан Их Хурлын гишүүд бас оюун санаагаа чилээж, зөв зохицуулах асуудлаа авч үзэхгүй бол энэ бас тийм хиймэл гэдэг юм уу орон зай, хийдэл үүсгээд байгаа юм уу даа гэмээр юмнууд гарч ирээд болж өгөхгүй байгаад байгаа юм. Үүнийг анхаараач гэж ингэж хэлмээр байна. Үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Батжаргал гишүүний саяын хэлж байсан зүйлүүд үнэхээр яг ийм юмнууд байгаа. Одоо ийм юмнууд байгаа юм. Та түрүүн байхгүй байсан болохоор анзаараагүй байсан байж магадгүй. Жишээ нь, асуудлыг цааш нь зөвхөн үзэл баримтлалынхаа хүрээнд л ярьдаг байх хэрэгтэй. Тэрийг дагуулж, гуя дагуулж хүзүү оруулдаг юм бол энэ аль болохоор таслан зохих юмнуудыг энд оруулсан байж байгаа.

Хоёрт тэр та хэллээ шүү дээ яах аргагүй зөрчилтэйг нь мэдсээр байгаад бид нар гаргачхаад байна гээд. Тийм юм байгаа. Тэгэхээр тэрийг таслах жишээ нь, нэг механизм юу хийсэн гэхээр Байнгын хороон дээр хэлэлцэж байх явцадаа энэ чинь энэнтэй зөрчөөд, зөрчилдөөд байна, дахин үнэлгээ, дүгнэлт хийж байж үргэлжлүүлж хэлэлцүүлнэ гэдэг нэг ийм шат гаргаад өгчих. Тамгын газарт хэлээд нэг хууль ороод ирлээ. Хэдэн хууль дагалдаад ороод ирлээ. Хэлэлцээд явах гэсэн чинь хоорондоо зөрчилдөөд байна. Бусад тийм хуультай зөрчилдөөд байна.

Тэгэхээр Байнгын хороон дээр тэрийгээ зогсоогоод, Тамгын газраас дүгнэлт гаргуулж байгаад, шинжилгээ дүгнэлт хийж байгаад хуулийн талаас нь нөгөө саяын таны хэлсэн шиг уялдуулах юм нь болохгүй байгаа бол тэгвэл буцаах. Жишээ нь нэг л механизмыг нь тайлбарлахад ийм байна. Та хэрэв санал, онол бас нэмэх юмнууд байвал юу яачихна биз. Ажлын хэсэг байгуулагдах гээд тэн дээр санал юмаа өгчхөөрэй гэж хэлье.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасалчихсан. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхим цугларъя. Хоёр хуулиа л батлах гээд байна

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би Энхболд дарга би Бундестагийн жишээ ярья л даа. Бундестаг бол 736 гишүүнтэй байгаа. Тэгэхдээ ер нь Бундестаг чинь тоо нь хөвөгч, тоо нь бас тодорхой биш. Хөдөлдөг байхгүй юу даа. Жишээ нь, CDU буюу Христосын ардчилсан холбоо, эсвэл чинь тэнд 152 суудалтай. Жагсаалтаар орж ирсэн 152 гишүүнтэй, тойргоос сонгогдсон 30 орчим байгаа байх тийм гишүүнтэй.

Тэгэхээр нөгөө 152 нэг их тийм үг хэлэхгүй. Санал дээр ч гэсэн юу байдаг юм, бүлгийн дарга нь ганцхан карттай. Хэрвээ тодорхой яг нэг нам байр сууриа, тодорхой байр суурин дээр байх тохиолдолд бүлгийн дарга нь нөгөө 152 хүнийхээ картыг ганцхан хийгээд тэгээд “за” эсвэл “үгүй” гээд дарчихна. Үлдсэн тойргоос сонгогдсон нөхдүүд нь болохоор өөрсдийн дураар саналаа өгдөг байхгүй юу даа. Тэд нар үг хэлэх болохоор бас дахиад бүлгийн дарга нь зөвхөн тодорхой асуудлаар зөвхөн бүлгийн дарга нь юм уу, аль эсвэл яг тэр асуудлаар мэргэшсэн хүн нь ганцаараа үг хэлнэ. Үлдсэн бас тойргоос сонгогдсон тэр гишүүд нь дураараа үг хэлдэг. Энэ яаж байна гэхээр тэр тойргоос сонгогдсон хүн тэр гишүүд бол илүү хөдөлмөрлөж тэр тойрогтоо маш их ажил хийж бас иргэдийнхээ уулзалт, бүх санаа бодлыг бүгдийг нь сонссоны үр дүнд сонгогддог учраас илүү давуу эрхийг авдаг байхгүй юу.

Тийм учраас энэ Болорчулуун гишүүний хэлээд байгаа тойргоос дэвшсэн тохиолдолд бас тийм үгээ хэлэх, энэ ард түмний дуу хоолой болох тэр үндсэн ажлаа бас илүү эрхтэйгээр хийх ёстой байхгүй юу даа. Ийм учраас энийг бас Энхболд дарга хэлэлцүүлгийн явцад бас яг энэ байдлаар бас шийдвэрлэхгүй бол болохгүй. Бас бүх хүн үг хэлье гэвэл, үг хэлээд байвал тэр хууль батлагдахгүйгээр бантан хутгагдана.

Тийм учраас зарим нэгэн жагсаалтаар орж ирсэн тэр нөхдүүдийг

илүү хязгаарлах, бүлгийн дарга нь болон мэргэшсэн хүмүүс нь хариулах тэр асуудлаа шийдвэрлээд явах нь зүйтэй.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Олон гишүүд бас санал хэлж ажлын хэсэгт орж, зарим өөрчлөлт оруулах саналаа гарсан. Ажлын хэсэг дээрээ ажиллаад явна биз. Миний уншиж судалсан 99 улсын парламентын хуралдааны чуулганы дэгийн тухай хуульд холимог тогтолцоотой улсуудынх ялгаатай байдаг тал бий.

Гэхдээ хамгийн гол нь хэн үг хэлэхдээ гол биш, тэр мэтгэлцээн бүтээлч, ажил хэрэгч, ер нь ч яг тэр хуулийнхаа төслийг чамбайруулахад чиглэсэн ийм мэтгэлцээний болон ард түмний төлөөллийн болон намуудын байр суурийг л нэгтгэж хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнөхөд чиглэгдэж байгаа юм л даа. Энийгээ хэлэлцүүлгийн явцад анхаарна буй.

Хоёр хуулийн талаар санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын тухай Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Энэ бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар эхлээд санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 6-д Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай”, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулна. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэлэлцсэн.

15.45 цаг

Одоо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг.

Дэгээр санал хураана. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг, Байнгын хорооны саналаар Дэгийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 5-д

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Харин тийм. Та хоёр. Манай Дэгийн хууль хэлэлцэж байхад Баделхан, Сүхбаатар гишүүн их дэгтэй яг яс гарч, оролгүй суусанд бас баяр хүргэе.

57.1 хувийн саналаар гишүүдийн олонх дэмжлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд ишлэжүүлж байна.

15.47 цаг

Ер нь бас энэ өргөн барих процессыг бас их тодорхой болгоод, хэлэлцэх процессыг тодорхой болгоод, хяналтыг сайн болгомоор байна лээ. Тэгэхгүй бол үзэл баримтлалтайгаа зөрүүтэй хуулийн төсөл ороод ирдэг, үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг нь шийдчихдэг. Дараа нь нөгөөдөх нь гацаа, зөрчил үүсдэг. Ингээд Цэц дээр очих асуудал үүсдэг гэх мэтчилэн. Энэ хэлэлцүүлгээ сайн хийж, их чамбай хуулийн төсөл өргөн барьдаг байхыг л Хууль тогтоомжийн тухай хуулиар хийхгүй бол Хууль тогтоомжийн хуулиараа нэлээн чанга болчихсон. Сүүлийн үед гурилддаг болчихоод байна шүү. Хууль өргөн барихыг. Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Тэрийг чангалахгүй бол 127, 128 хууль санаачлагч субъект болохоор энэ их замбараагүй болж магадгүй.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 сарын 14-ний өдөр болсон Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын анхдагч хуулийг 2021 онд баталснаар Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгэн үе шат эхлээд 3 жил өнгөрч байна.

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу Улсын Их Хурал хяналт шалгалтын бүрэн эрхээ хуульд заасан 7 арга хэрэгслээр явуулж байгаа. Хууль санаачлагчийн илтгэл дотор энэ 7 аргачлалын арга хэрэгслийн талаар нэлээн олон тоо баримтууд хийсэн ажлуудын талаар байгаа учраас би түр эд нарыг орхиод материал тараагдсан гэж бодож байна.

Тэгээд энэ бол энэ удаагийн Улсын Их Хурлын хийсэн хамгийн том ажлуудын нэг бол Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны агуулга, хандлага, чиглэлд томоохон шинэ хуудас нээсэн ийм ажил болсон. Түүхэнд үлдэх ийм хууль гарсан. Үүний дагуу ажлаа зохицуулаад ирсэн.

Гэхдээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, шинэчлэх өөрөө тасралтгүй үргэлжлэх ийм үйл явц юм байна. 19 оны Улсын Их Хурлын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайдын эрх хэмжээ нэмэгдсэнээр хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хяналт тэнцлийг хангахад Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их

Хурлын хяналтыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхол, хүнд суртлаас ангид, хариуцлагатай гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэхэд Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааг чиглүүлэх хяналтын арга хэрэгслийг боловсронгуй болгох ийм шаардлага зүй ёсоор ажиглагдаж гарч ирж байна.

Ер нь үйлчилж байгаа хууль нэгдүгээрт, хоёрдугаарт Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын бүрэлдэхүүнд орж байгаа өөрчлөлтийг дагуулаад энэ шинэ хуулийн төслийг боловсруулж та бүхэнд танилцуулж байгаа юм.

Товчхон хэлэхэд энэ хэмжээндээ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихад Улсын Их Хурлын хяналт харьцангуй сул байгаа нь эрх зүйн зохицуулалттай холбоотой гэж ингэж үзэж байгаа юм.

Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11.3-д заасны дагуу үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайланг Засгийн газраас жил, хагас жил тутамд ирүүлдэг хэдий ч Байнгын хороод хэлэлцдэггүй, хэзээ хэрхэн хэлэлцэхийг нь хуульчлаагүй, тайлан зөвхөн үүрэг, чиглэл өгсөн заалтаар хязгаарладаг зэрэг нь хуулийн хэрэгжилтэд манай Их Хурлын зүгээс тавих хяналт үр нөлөөтэй болоход бас саад тотгор учруулж байна гэж үзэж байгаа.

Асуулт, асуулга тавих ажиллагаанд гишүүдийн болон төрийн албан тушаалтны хариуцлагыг өндөржүүлэх, Байнгын хороогоор хэлэлцэж, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох шаардлагатай гэж үзвэл нэгдсэн чуулганаар хэлэлцүүлдэг байхаар эрх зүйн орчныг нь сайжруулах шаардлагатай байна. Нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд хүндэтгэн үзэх шалтгаанаар ирэх боломжгүй бол Ерөнхий сайдын мэдээллийг түүний

томилсон Засгийн газрын гишүүн хийх өөрчлөлт оруулснаар бодлогын асуудлаар Улсын Их Хурлын гишүүд, цөөнхийн төлөөлөл хангалттай бүрэн мэдээлэл авахгүй, мэдээллийн үр нөлөө бага байна гэж гишүүд үзэж байна гэх мэтчилэн Улсын Их Хурал бодитой бүрэн мэдээлэлд тулгуурлан бодлогын баримт бичгийн биелэлтдээ хяналт тавих, энэ хуулийн заалтууд нэгдүгээрт сайжруулах шаардлага байна.

Хоёрдугаарт, одоо байгаа нь бүрэн хэрэгжихгүй байна гэсэн энэ үндэснүүд дээр энэ хуулийн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаа.

Би энэ танилцуулгын хэсгээсээ бас зарим зүйлүүдийг нь орхичихлоо шүү. Та бүхэн шаардлагатай гэж үзвэл тараасан материалаас үзчихээрэй. Энэ дээрх нөхцөл байдлыг харгалзаад Их Хурлын хяналт шалгалтын тухай шинэчилсэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан 8 бүлэг, 57 зүйлтэй. Энэ шинэчилсэн найруулгын төсөл нь 21 онд баталсан хуулийн суурь үзэл баримтлалыг хэвээрээ хадгалсан. Энэ удаа оруулж байгаа шинэчлэлийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийнхөө үзэл санаанд тулгуурлаад Их Хурлын 19-24 оны стратеги зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хэрэгжилтийг гүнзгийрүүлэх, ханган чиглүүлэхэд цаашидаа энэ зохицуулалтаар хяналтыг сайжруулах, шалгалтыг сайжруулах үндэс Улсын Их Хурал зөвхөн хууль батлахаас гадна хяналт шалгалт тавьж, хэрэгжилтийг нь хангаж байх тал дээр үүргээ биелүүлэхэд нийцсэн эрх зүйн орчныг сайжруулах ийм асуудлыг хамарсан гэж хэлж болно.

Энд юуны өмнө гишүүдийн тоо нэмсэнтэй холбогдуулаад ерөнхий хяналтын, хүний эрхийн, төсвийн нэр дэвшигчийн сонсгол явуулах, хүсэлт гаргах гишүүдийн тоог 15 байхаар,

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг 7-31 хүний хүртэлх бүрэлдэхүүнтэй байхаар, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, Засгийн газар Улсын Их Хурал ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад тавих хяналтыг сайжруулан энэ чиглэл өгсөн шийдвэрийн биелэлтийг тогтмол сонсож хэлэлцдэг болно.

Улсын Их Хурлаас хийх үр дагаврын үнэлгээний тайланг үр дүнтэй хэлэлцэж байх, Засгийн газрын нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг шаардлагатай тохиолдолд хянан үзээд хүчингүй болгодог, хариуцлага тооцдог зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан. Хяналт шалгалтын ажлын хэсгийн үйл ажиллагааг чанаржуулах, үр нөлөөг нэмэгдүүлэхтэй холбоотой ажлын хэсэг байгуулахад тавигддаг шаардлагыг нэмэгдүүлж байгаа. Ажлын хэсгийн явц байдалд үр дүнг холбогдох Байнгын хороо сонсоод, түүнийгээ харгалзаад ажлын хэсгийг татан буулгах уу, эс үгүй бол үргэлжлүүлэн ажиллуулах уу гэснийг шийдвэрлэдэг болно.

Хяналт шалгалтын төлөвлөлтийг бодитой болгох, биелэлтийг хангуулах хүчин чадлыг нэмэгдүүлээд хяналт шалгалтын цаглаврыг Улсын Их Хурлаар тогтоолоор батлаад, төлөвлөгөөт шалгалтуудыг хийх ийм боломжийг бүрдүүлнэ. Гишүүдээс гарч байгаа нэг шүүмжлэл бол одоо бид нар асуудлыг гарсан хойно нь шалгадаг, асуудал үүссэн, бэрхшээл гарчихсан үед нь шалгадаг энэ байдал бол хангалттай бус байна гэж үзэж байгаа. Тийм учраас цаглавар баталж байгаад төлөвлөгөөт шалгалтуудыг явуулдаг энэ тогтолцоог бас нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Ерөнхий сайдын 14 хоног тутамд мэдээлэл хийх зохицуулалтыг сард нэг удаа болгоод бодлогын чанартай асуудлуудаар хэлэлцүүлгүүдийг явуулж байя. Мэдээллийн цагийн үргэлжлэх хугацааг цаг 30 минутад багтааж байя. Хариулаагүй үлдсэн асуултууд, асуултын

хариунуудыг цахим системд байршуулах замаар Ерөнхий сайдын мэдээллийн хэлэлцүүлгийн чанар, өгөөжийг нэмэгдүүлэх зохицуулалт орж байна.

Улсын Их Хурлын гишүүний асуулт, асуулга түүний хариуг Байнгын хороонд танилцуулж хэлэлцүүлдэг болох зохицуулалт орж байна. Хяналт шалгалтын хүрээнд төсвийн хяналт шалгалтыг өргөжүүлэх төсвийн боловсруулалтыг үе шатад нь тавих ийм хяналтыг бий болгох зорилго тавьсан. Одоо бол Засгийн газраас төсөл боловсруулаад, төсөв боловсруулаад оруулж ирсэн хойно тэрэнд нь хяналт тавих ажлыг хийдэг бол одоо боловсруулах явцад нь үздэг, хянадаг, хуульд эс нийцэж байгаа эсэхтэй нь бас хяналт тавьдаг ийм тогтолцоо бий болгоё гэсэн санааг бас тусгасан байгаа.

Иргэний нийгмийн болон төрийн хяналт шалгалтын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны уялдааг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг тусгахаар орж байна.

Тухайлбал, энэ дотор Төрийн аудитын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагад Байнгын хорооны даалгаснаар Улсын Их Хурлын хяналт шалгалтыг нэрийнх нь өмнөөс явуулж байх ийм боломжийг бүрдүүлэх заалт оруулж байгаа.

Төрийн байгууллагын тайлан, илтгэл, хэлэлцэх хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийхэд хөндлөнгийн хараат бус байгууллага, мэргэшсэн судлаачдаар дүн шинжилгээ хийлгэдэг, оролцоог нэмэгдүүлдэг энэ механизмыг нэвтрүүлж гэсэн санаа оруулж байгаа. Ингээд Хянан шалгах түр хорооны эрх зүйн зохицуулалтыг сайжруулаад, хууль хэрэгжүүлэх шатад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд Түр хороог байгуулах, татан буулгах асуудлыг Их

Хурлын тухай хуульд зааснаар шийдвэрлэж байна.

Түр хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлага Түр хорооны даргын эрх, үүргийг тодотгон зааж байгаа. Түрүүчийн хууль хэлэлцүүлэг явж байхад жишээ нь, манай гишүүдийн зүгээс энэ эрх зүйн ашиг сонирхлын зөрчилгүй байх асуудал дээр бас онцгой ёс зүйтэй уялдуулж ярьж байсан. Та бүхэн санаж байгаа байх.

Хянан шалгагч, шинжээч нарын эрх зүйн байдлыг тодорхой больё, тавигдах шаардлагыг нэмэгдүүлбэ, бас ашиг сонирхлын зөрчилгүй болгоё. Хэрэв худлаа мэдээлэл өгсөн бол ноогдуулдаг үүрэг, хариуцлагыг нь чангатгая гэсэн ийм заалтууд орж байгаа.

Гэрч дуудах зохицуулалтыг сайжруулна. Гэрчийн нэрсийг гаргах, танилцуулах хугацааг нь тодорхойлох, мэдэгдэх хуудсыг ямар хэлбэрээр байх вэ, оролцож чадахгүй энэ тэр гэсэн ийм зүйл гарвал хүндэтгэн үзэх, ямар тохиолдолд хүндэтгэн үзнэ гэх вэ гэх мэтчилэн зүйлүүдийг нь илүү тодорхой болгосон заалтууд оруулсан.

Тэгээд энэ хуулийн төсөлтэй хамт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулсан байгаа. Энэ төслүүдийг баталснаар Үндсэн хуулийн хүрээнд Улсын Их Хурлын хяналт шалгалтын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд бодитой хувь нэмэр болсон зохицуулалт болно гэж хууль санаачлагчийн зүгээс үзэж байна.

Та бүхнийг Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн

найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Маргааш хэлэлцье. Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Лхагвын Мөнхбаатар, Ганзоригийн Тэмүүлэн нараас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Улсын Их Хурал 2023 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгон сонгуулийн холимог тогтолцоотой байхаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 44 дүгээр тогтоолын 2 дахь заалтад Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг нийцүүлэхээр заасан.

Хууль санаачлагч Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, Монгол Улсын Их Хурлын 2019-24 оны

стратеги төлөвлөгөөний зорилтыг ханган биелүүлэх, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн хэрэгжилтийн шатанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, зөрчил, давхардал, хийдлийг арилгах чиглэлээр хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг *d.parliament.mn* цахим хаягт байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Хуулийн төсөлд Улсын Их Хурлаас хууль тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн биелэлтийг тогтмол сонсож хэлэлцдэг байнгын механизм бий болгох, Улсын Их Хурлын хяналт шалгалт явуулсны дараа авах арга хэмжээ, Засгийн газраас хэрэгжүүлсэн ажлын тайланг сонсож, хэлэлцэх үйл ажиллагааны журмыг тодорхой болгох. Мөн Засгийн газрын болон төрийн бусад байгууллагын хяналт шалгалттай давхцахгүй харилцан уялдаатай байх, Улсын Их Хурлаас байгуулагддаг ажлын хэсгийн үйл ажиллагааг сайжруулах, ажлын хэсэг байгуулахад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, үр дүнг холбогдох Байнгын хороо сонсож, шаардлагагүй бол татан буулгаж, үргэлжлүүлэн ажиллуулахыг Хяналт шалгалтын үйл ажиллагаандаа судлаач, мэргэжлийн, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах оролцоог өргөжүүлэх, Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болсонтой уялдуулан сонсгол явуулах, хүсэлт гаргах гишүүний тоо 9 байсныг 15 болгон өөрчилж, Түр хорооны бүрэлдэхүүнийг 7-31 гишүүнтэй байх зохицуулалтуудыг тус тус тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавигдах хяналт шалгалтыг байнгын шинжтэй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нэр дэвшигчийн сонсголыг явуулахдаа хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хаалттай хэлэлцэж болох

эсэх асуудлаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Би бас олон нийтдээ бас мэдээлэл өгөх үүднээс сая нэг гишүүн маань хэллээ л дээ Улсын Их Хурал хяналт шалгалт хийх хэрэггүй ээд. Ер нь яагаад бид нар энэ Хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их

Хурлын хяналт шалгалтын тухай хууль байх ёстой юм бэ гэдэг дээр бас олон нийтдээ тайлбар өгөөч гэж хууль санаачлагчаас хүсье.

Би асуултаа асууя. Энэ парламент бас харьцангуй хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах, Түр хороо байгуулах, нээлттэй сонсгол зохион байгуулах энэ үйл ажиллагааны бас тодорхой эхийг тавьж чадсан ийм парламент болсон гэж би ойлгож байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол “Оюу толгой”-н түр хороо, Нүүрсний түр хороо, одоо яг Эмийн түр хороо үйл ажиллагаа явуулж байна. Ирэх 15, 16, 17-ны өдрүүдэд нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголоо зохион байгуулах гэж байна. Мөн Уул уурхайн ашигт малтмалын лицензийн үйл ажиллагаанд хяналт тавих түр хороо бас байгуулагдах гээд ажиллаж байна.

Би энэ өмнөх ямар ч гэсэн 3 Түр хороонд ажилласан хүний хувьд бас хэд хэдэн зүйлийг тодруулъя гэж бодож байна. Энэ дээр нэр дэвшигчийн сонсгол бид нар зохион байгуулдаг байгаа. Энэ нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахад тэр юу их анхаарал татдаг вэ гэвэл яг Байнгын хорооны гишүүдэд нэр дэвшигчдэд цензур тавих гэдэг юм уу, хяналт тавих тэр тогтолцоо үнэндээ байдаггүй. Одоо 3 нэр дэвшигчийн асуудлыг хэлэлцэнэ гээд л 3 хүн л орж ирдэг.

Өмнө нь яагаад хэлэлцэгдээд өөр сонголт байхгүй байгаа юм бэ гэдэг л гэхээр журмаар зохицуулагддаг учраас гэдэг ийм тайлбарыг хэлдэг л дээ. Нэр дэвшигчийн сонсголыг тодорхой хүн орж ирэхээр сонголт хийх тэр боломжтойгоор нь нэр дэвшигчдийг оруулж ирж, нээлттэй сонсголыг нь хийж болдоггүй юм уу гэдэг зүйлийг би бас тодруулах гэсэн юм.

Түр хорооны асуудал дээр гэрч дуудах зохицуулалт, хариуцлага, мөн

хянан шалгагч, шинжээч томилох энэ асуудлыг бас бид нар ярих ёстой. Өнөөдөр гэрчээр дуудах энэ зохицуулалт дээр юу анхаарал татаж байна вэ гэвэл сүүлийн Түр хорооны хурлууд дээр гишүүд гэрчээр дуудагдаж байгаа этгээд маань зөвхөн өөрийн бие төлөөний хүнийг явуулах гэдэг юм уу, өмгөөлөгчөө явуулах гэдэг юм уу ийм байдал үүссэн. Тэгэхлээрээ бид яг гэрчээс мэдүүлэг авах, гэрчээс тайлбар авах энэ боломж үүсэхгүй байгаа болохлоор энэ дээр ямар зохицуулалт орж ирж байгаа вэ гэдэг зүйлийг бас асууя.

Ер нь ингээд Түр хороо ажиллалаа, үр дүнгээ тайлагнаж байна. Түр хороо тайлангаа тавьснаараа Түр хороо татан буугдана гээд ингэдэг.

Гэтэл Түр хорооны үйл ажиллагааны үр дүн нь юу байсан юм бэ гэдэг дээр олон нийт маш ихээр асуудаг. Та нар Түр хороо байгуулагдаад ажиллаад байдаг яг үр дүн юу байсан юм бэ? Магадгүй эдийн засгийн эерэг үр дүн байгаа, Оюу толгой дээр ч гэдэг юм уу, Нүүрс дээр ч гэдэг юм уу, Хөгжлийн банкны түр хороон дээр бид нар эдийн засгийн маш томоохон амжилтуудыг авчирсан боловчиг яг хариуцлага тооцох тэр тогтолцоо нь байна уу, үгүй юү гэдэг зүйлийг олон нийт биднээс шаарддаг. Тэгэхлээр энэ дээр бас тайлбар өгөөч. Хэдийгээр хууль хяналтын болон хариуцлага тооцох дүн шинжилгээг нь бид нар гаргаад өгч байгаа боловчиг Их Хурлаас шаардах шаардлага бас олон нийтийн дундаас байгаа гэдгийг бас тодруулах гэсэн юм.

Асуудал үүссэн юм уу, улсад хохирол учирсны дараа бид нар Түр хороо байгуулаад байгаа. Жишээ нь, Ногоон автобусны түр хороо ч гэдэг юм уу, Нүүрсний түр хороо, Хөгжлийн банкны түр хороо тэр. Аливаа асуудал дээр бид нар саналаараа тэр заавал тэр улсад үүссэн хохирлын дараа биш Түр хороо байгуулах энэ саналыг ер нь ямар зохицуулалтаар бид нар Их Хуралд

тавьж болох вэ гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм. Энэ дээр бас нэг асуулт байна.

Энэ бол гэрч мэдүүлэг өгөхтэй холбоотой зардлаа нотолсны үндсэн дээр улсын төсвөөс нөхөн төлүүлэх эрхтэй. Гэрч мэдүүлэг өгөхтэй холбоотой зардлаар. Хэрвээ тэр гэрч гадаад улс оронд байж байгаад би Монголд очиж энэ сонсголд оролцох нь гэвэл тэр зардлаа улсаас авах нь, төсвөөс авах нь. Тэгэхлээр энэ дээрээ тодруулга мэдээллийг өгөөч. Тодруулж асууя. Тайлбарын дараа.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн, хууль санаачлагч.

Н.Энхболд: Ер нь Их Хурал хянан шалгах ажил хийх хэрэгтэй юм уу, үгүй юм уу? Байх ёстой юм уу, үгүй юм уу гэдэг тухай асуудал тавигдаж байна. Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.8 дахь заалтад Монгол Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй гээд заачихсан. Тэгэхээр энэ шалгаж байх ёстой юу, үгүй юү гэдэг бол асуудал аль хэдийн шийдэгдчихсэн өнөөдөр тавигдаж байх ёстой асуудал биш байна. Энэ Үндсэн хуулиар бид нар ийм онцгой бүрэн эрхтэй. Энэ үүргээ хэрэгжүүлэх ажил маань харин тийм ч хангалттай биш явж ирснийг түрүүн олон гишүүн хэлсэн. Энэ удаагийн хурал бол энэ хуулийг нь батлаад, шинэ шатад гаргаад Монголын парламентын түүхэнд үйл ажиллагааных нь маш том бүлгийн эхлэлийг тавьсан ийм онцгой үүрэг гүйцэтгэсэн гавьяатай гэж хэлж болох Их Хурал гэдгийг хэлэх байна.

Тэгэхээр энэ бол Үндсэн хуулийнхаа дагуу бид нар хууль тогтоохын хажуугаар үүнийхээ хэрэгжилтэд хяналт тавьж байх гол үүргээ биелүүлж яваа ажил гэж хэлэх байна.

Нэр дэвшигчийн сонсголыг ерөнхийдөө хоёр шаттай явуулдаг. Агуулга талаас нь аваад үзвэл жишээ нь, сонсгол хийх гэж байгаа бид нар нэр дэвших, сонгож авчхаад тэрийгээ өөрснөө асуугаад, сонсоод сууж байх бол утгагүй. Логик ямар ч тийм учир шалтгааны холбоогүй, логикгүй асуудал болно.

Тэгэхээр нэгдүгээрт, нэр дэвших ажлыг бол янз бүрийн шатад янз бүрээр явуулж байгаа байх. Урьдчилаад болзлуудыг нь зарлаад ийм ийм шаардлагыг хангасан ийм ийм хүмүүсийг урьдаг, тэрүүнийг нь бас тодорхой шатад шалгаруулдаг, эс үгүй бол ийм хүмүүсийг шалгах ёстой байна гээд асуудал тавигдангуут мэдээж хувь хүмүүс ч саналаа илэрхийлнэ, байгууллагууд ч санал, сонирхлоо илэрхийлж болдог. Энэ хүрээнд нь авч байгаад хоёр дахь шатад нь нэр дэвшигчийн сонсгол гэж. Бид нар тусдаа өөрөөр хэлбэл, өөр нэг газраар сонгуулчхаад, эс үгүй бол саналаа өгсөн хүмүүсийг нь, дараа нь өөрсдийнхөө хэмжээнд сонсгол явуулдаг учраас сонсголын явцад дахиад хүний нэр дэвшүүлэх тухай энэ тэр асуудал бол зохион байгуулалтын хувьд жоохон тийм зохистой биш байдаг л даа. Урьд нь хангалттай хугацаа өгөөд шалгараад, шалгаруулаад гараад ирдэг болохоор ийм зүйл хэлэх байна.

Гэрч, шинжээч сонгохтой холбогдсон асуудал дээр Үнэнбат дарга. Заалтууд дээр нь бас тодорхой зүйлүүд.

Г.Занданшатар: Үнэнбат. Хаанаас оруулах юм? Ажлын хэсэг индрээс.

М.Үнэнбат: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуултад хариулъя.

Гэрч, хянан шалгагч томилохтой холбоотой зохицуулалтуудыг илүү нарийвчлан зохицуулж Хяналтын хууль

дээр, хуулийн төсөл дээр тусгасан байж байгаа. Хянан шалгагч томилоход ямар шаардлага хангасан байх ёстой вэ гэсэн энэ зохицуулалтуудыг илүү нарийвчлан зохицуулсан сүүлийн. Тухайлах юм бол сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхлээгүй ч гэдэг юм уу энэ зохицуулалтуудыг хуулийн төсөлд нарийвчилж оруулж, хянан шалгагчийн хийх бүрэн эрхийг тодорхой зааж, илүү нарийвчлан зохицуулсан.

Түүнчлэн гэрчтэй холбоотой зохицуулалт өнгөрсөн хугацаанд Хяналтын хууль дээр хэрэгжихэд бол гэрчийг хэрхэн дуудах, хэрвээ гэрч дуудаад хүндэтгэн үзэх шалтгаанаар Хянан шалгах түр хорооны сонголд ирээгүй тохиолдолд гэрчтэй холбоотой асуудлыг хууль, хяналтын байгууллагад өгч яаж шалгуулах вэ, тэр нь хүндэтгэн үзэх шалтгаан гэж юуг үзэх вэ гэх мэтчилний зохицуулалтыг бол хуулийн төслийн 39, 40 дүгээр зохицуулалт зүйлээр нарийвчлан зохицуулж өгсөн байгаа.

Ингэснээрээ бол тухайн хянан шалгагч хянан шалгах түр хорооны сонголттой холбоотой оролцогчдын эрх, үүргийг нь нарийн, тод зохицуулахаас гадна ямар нэгэн байдлаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрч ирээгүй тохиолдолд мөн холбогдох хариуцлагыг нь шийдэх энэ хуулийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд илүү оруулж илүү нарийн нарийвчлан зохицуулсан зохицуулалтуудыг тусгаж өгсөн байж байгаа дарга.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн гүйцээж хариулъя.

Н.Энхболд: Хэнийг гэрчээр дуудахаа Түр хороо өөрөө шийднэ. Ингэхдээ тэр хүнд заавал ийм тусгай шалгалтын ийм сэдвээр, ийм асуудлаар мэдүүлэг авна гээд болох он, сар, өдөр, цаг, та өөрөө ийм эрхтэй шүү, ийм хариуцлагатай шүү гэдгийг нь заавал

дурдсан тийм баримт бичгээр зарыг нь хүргээд гэрчээр дууддаг.

Хянан шалгагч нарыг бол сая Үнэнбат дарга хальт хэлчихлээ. Бас Түр хороонд оролцсон гишүүдийн гурваны хоёроор саналаар тодорхой болзлуудыг хангаж байгаа буюу тухайлбал 5 жил улс төрийн албан тушаал, улс төрийн намын удирдах нь албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй, мэргэжлийн дүгнэлт гаргах чадвартай, 3-аас доошгүй жил тухайн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан туршилагатай ийм Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна гэж заагаад энэ гэрч нар, шинжээч нар, хянан шалгагч нар ажилдаа ямар нэгэн ашиг сонирхлын зөрчлөөс болж худал мэдүүлэг өгсөн, буруу, зөв дүгнэлт гарсан бол эдгээрт тэр зөрчлийнх нь хүнд, хөнгөн байдлыг харгалзаж үзээд Зөрчлийн тухай хуулиар юм уу, бүүр шаардлагатай гэж үзвэл Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх ийм зохицуулалтууд бас орсон байгаа.

Г.Занданшатар: Тодруулж асууя. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Өмнөх түүх ч гэдэг юм уу, өнөө өмнөх практик дээр харж байхад Нүүрсний түр хороон дээр ч тэр, Эмийн түр хороон дээр ч тэр хянан шалгагчаар сонгогдсон, томилогдсон эрх бүхий этгээд хамаарал бүхий боллоо гэдэг байдлаар, хамаарал бүхий нөхцөл байдал нь илэрлээ гэдэг юм уу ийм байдлаас шалтгаалан Түр хорооноос эрхийг нь түдгэлзүүлэх ийм тохиолдол гараад байна л даа. Хэд хэдэн удаа. Тэгэхлээр үүнийг чангатгах, магадгүй эргээд түүнд хариуцлага тооцох тэр механизм бүрэн байж чадаж байна уу, үгүй юү?

Өөрөөр хэлэх юм бол нууцын мэдээлэлтэй холбоотой мэдээллийг бүхэлд нь авсны дараа би хамаарал бүхий болчихлоо. Тийм учраас би ингээд энэ

ажлаа өгье гэдэг ийм өргөдөл гаргаад ирж байгаа байхгүй юу.

Гэтэл тодорхой хугацаанд ажилласан тэр залиланг нь бид нар улсын төсөвт оруулахаас гадна хариуцлага тооцох тэр механизмыг яаж бий болгох вэ? Мөн гэрчийг яг өөрийн биеэр ирэх тэр боломжийг нь яг хуулийн заалтаа оруулсан уу? Зөвхөн гэрч өөрөө ирэхгүй болохоороо бие төлөөлөгчөө, өмгөөлөгч явуулах ийм нөхцөл байдал руу шилжчихээд.../минут дуусав./

Г.Занданшатар: Түрүүн ер нь хяналт шалгалтын асуудал хэрэггүй Улсын Их Хуралд гэсэн асуудал зарим гишүүд ярьж байна гэдэг дээр сайд гишүүд ярьсан юм байлгүй, Жаргалмаа гишүүн асуусан.

Ер нь энэ Улсын Их Хурал бол хууль тогтоох, түүнийхээ хэрэгжилтийг хянан шалгах хоёр үүрэг хэрэгжүүлнэ. Энэ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлаас хуулийн биелэлтийг хангуулах зорилгоор Хяналт шалгалтын түр хороо байгуулах ийм заалтыг Үндсэн хуульд оруулсан. Үндсэн хуулийн 28.2-т оруулсан.

Үүнийхээ дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг бид Германы Хяналт шалгалтын, Улсын Их Хурлын мөрдөн шалгах ажиллагааны тухай хууль гэдгийг загвар болгож аваад орчуулаад тэн дээрээ суурилж боловсруулсан. Бямбацогт гишүүнээр өргөн бариулаад тэр үед Төрийн байгуулалтын байнгын хороон дарга байсан учраас тэгээд энэ хууль батлагдаж, хэрэгжиж эхэлснээс хойш энэ хяналт шалгалтын сонсголууд, нээлттэй сонсголууд, Хяналт шалгалтын түр хороо байгуулах талаар, байгуулж хуулийн хэрэгжилтийг хангах талаар ажилласнаараа энэ олон асуудлууд, олон жил бугшсан асуудлууд ил тод, нээлттэй

болох энэ их үндэс болсон. Бугшмал энэ асуудлуудыг илчилж эхэлсэн.

Тэгээд үүнийгээ цаашидаа улам боловсронгуй болгохгүй бол мэдээж асуудлыг хэт мурийчихсан учраас тэгшилэхийн тулд хэтрүүлж нугалж байгаа тал ажиглагдаж байгаа юм. Тийм учраас процессыг нь илүү сайн тодорхой болгох тал дээр Улсын Их Хурлын ажлын хэсэг энэ төсөл дээрээ бас сайн үргэлжлүүлж ажиллаж болно бас. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн энэ хуулийн ажлын хэсгийн даргаар нь ажилласан хүн чинь манай Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн байгаа.

Ж.Сүхбаатар: Би харин их юм хэлэхгүй байя гэж бодсон ч гэсэн түрүүн хэллээ ажлын хэсгийн ахлагч бас. Парламентын түүхэнд тэмдэглэгдэх хууль байгаа. Энэ бид нар Хяналт шалгалтын шинэчилсэн найруулга гээд хийчихээр дахиад шинэ хуультай болж байгаа юм шиг биш. Энэ 2020 оны парламент эхлэхэд Занданшатар дарга надад үүрэг өгөөд энэ Бямбацогт нарын 20 гаруй гишүүдийн санаачилсан хууль.

Яг уг түүхийг нь яривал 2019 онд Их Хурлын даргын ахлах зөвлөхөөр ажиллаж байхад Занданшатар дарга надад бас үүрэг өгөөд Фридрих Эбертийн санд хандаад Германы холбогдох хууль эд нар судлах тухай ийм үүрэг өгөгдөж байсан юм.

Дараа нь Улсын Их Хурлын Тамгын газрын төсөл хэрэгжүүлээд стратеги төлөвлөгөөнийхөө дагуу бид нар энэ парламентыг ард түмний засаглах бүрэн эрхийг хангах тэр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах хүрээнд энэ ажлыг хийсэн юм. Үүнийг бас хэлмээр байгаа юм энэ завшаанаар. Энэ хүрээнд юу вэ гэхээр парламент өнгөрсөн 30 жил парламент хууль батлан гаргах, үйлдвэрлэх ажил хийсэн. Яг амьдрал дээр хуулийн гүйцэтгэл, биелэлт хангалтгүй байна

гээд байдаг. Үүнийг Засгийн газар хариуцдаг.

Тэгтэл яг энэ дэлхийн улс орнуудын хамгийн гол парламентын гол үүрэг нь бол хууль тогтоох, тэр төлөөлөх тэр байгууллагаасаа гадна яг тэр хуулийнхаа араас гүйцэтгэлд нь хяналт шалгалт тавьдаг үндсэн чиг үүрэг энэ нь сүүлийн 30 жил орхигдсонтой холбоотойгоор Монголд энэ хууль ёс, шударга ёсны асуудал чинь тавигдаад байсан.

Тийм учраас бид энэ анхдагч хуулийг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ингэж батлуулж байсан. Одоо манай туршлагатай гишүүд болох Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нарын гишүүд үүнийг оруулж ирж байна. Дараагийн парламентдаа бид суурийг нь дэвсэж өгөх гэж байгаа.

Энд анхаарах юм байгаа. Энхболд гишүүн бол манай Улсын Их Хуралд хамгийн олон сонгогдсон ер нь парламентын ой санамж болсон энэ Бат-Эрдэнэ гишүүн хоёр сууж байна л даа. Тэгэхээр энэ дээр сая энэ хууль гарсан учраас бид Жаргалмаа гишүүн ч хөндөж байна. Хууль гарсан учраас бид Нүүрсний сонсгол хийсэн, Хөгжлийн банкны сонсгол хийсэн, Эмийн сонсгол хийх гэж байна, тэр автобустай холбоотой сонсгол хийх гэж байна. Энэ хууль гараагүй бол энэ хийгдэхгүй. Сонсголын тухай хууль байсан ч гэсэн яг энэ хэмжээгээр бид парламентын мөрдөн шалгах түүх байхгүй.

Тийм учраас гишүүдэд нь ур чадварын асуудал байгаа, Тамгын газарт нь чадавхын асуудал байгаа. Энэ бусад улс орны парламент шиг гэнэт тэнгэрээс унаж ирээд чадавхтай болоогүй. Одоо бид юмны түүхийн эхлэлийг нь тавьж парламент хянан шалгадаг тэр популист зөвхөн тэр хууль үйлдвэрлээд бүүр бид хууль баталчихлаа биш, тэр хууль амьдралд яаж байгаа юм бэ гэдгийг яг хянан шалгадаг тэр дэлхийн жишиг

болсон арга хэрэгслүүдийг одоо л зүгшрүүлж ашиглах гэж саяын эхний оролдлого хийгдсэн. Энэ 126 гишүүнтэй парламент замбараагүй болно, хэцүү болно. Үнэн.

Яагаад гэвэл бид парламентын хөгжлийн явц болгонд хүндрэл бэрхшээл туулаад байгаа байхгүй юу. Би гол байр суурийг нь хэлэх гэж, асуух гэж байгаа юм нь Энхболд даргаа та нөгөө, тухайн үед би шүүх дээр байгаа хэрэг маргааныг Түр хороо байгуулахгүй гэхээр нь зэрэг тэр заалтыг нь авч хаяулчихсан учраас энэ олон хэргүүдийг сая сонсох л болсон шүү дээ.

Гэтэл эргээд Их Хурлын хууль дээр би хэлээгүй юм. Яллах дүгнэлт өгөөд шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар Түр хороо байгуулахгүй гэхэж байгаа юм. Энэ чинь тэр нюанс дээр нөгөө талын туйл руу нь орчхож байгаа юм. Би энэ дээр ямар байр суурьтай байгаа юм гэхээр яллах дүгнэлт үйлдээд шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэг 2 жилийн хугацаа өнгөрөөгүй бол байгуулахгүй л байх ёстой байхгүй юу.

Ер нь дэлхийн улс орнууд ужгирсан, удчихсан асуудлууд тэр хуулийн байгууллагууд шийдэгдэхгүй удчихсан асуудал дээр нь байгуулдаг. Хэрвээ энэ заалтыг хийчих юм бол цаашидаа нөгөө сонсголууд хийгдэх, том хэргүүддээ сонсгол хийж чадахгүй. Зоригийн хэрэг шиг олон арван жил болж байгаа хэргийн асуудлууд ингээд шийдэгдэхгүй ч гэдэг юм уу ийм болчхож байгаа юм.

Тэгэхээр хэдүүлээ конпремис хийгээд хугацаа зааж өгье. Хуулийн байгууллагууд 1 юм уу, 2 жил. Ер нь 2 жил л байдаг юм даа. Ер нь дээд хугацаа аль ч улс орны процесс дээр 2 жилийн хугацаагаа өнгөрөөгүй бол Түр хороо байгуулмааргүй. Одоо манай Түр хороод ч яаж байна вэ гэхээр 6 сар болоогүй байхад зэрэгцээд байгуулж байгаа нь бас

буруу хандлага, буруу юм байгаа юм. Буруу асуудал болж байгаа юм. Адилхан мөрдөгч хийх гээд байгаа юм уу, шүүгч хийх гээд байгаа юм уу болчхож байгаа.

Хуулийн байгууллагуудын боломжит хугацаа өнгөрөөд олон нийтийн хүлээлтэд хэн ч хариулт өгөхгүй байгаа бол ард түмний төлөөлөх энэ байгууллага энэ эрхээ хэрэгжүүлэх ёстой л байхгүй юу юу. Энэ дээр би асууж байгаа юм.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

Н.Энхболд: Тэгээд одоо ажлын хэсэг гарна. Би саналаа Их Хурлын даргад хүргүүлсэн байгаа. Танилцуулчихсан байх гэж бодож байна. Сүхбаатар гишүүнийг энэ дотор ороод ажиллаасай гэж бодож байгаа. Та хэрэв ороод ажиллавал сайн юмнуудаа хийгээд явж болно.

Яагаад яг анхны хувилбарт ороогүй вэ гэхээр энэ одоо буруу хэлж ойлгосон хүмүүс бас уучилна биз. Манай нийгмийн сэтгэлгээ аливаа дуулиантай хэрэгт хандах хандлага, тэрийг тойруулж хийж байгаа улс төр энэ тэр юмнуудаас бас жаахан болгоомжилсон талууд бий. Цоо шинэ дээр нь яах ийхийн зуургүй л хэрэг үүсгэхээд шийдэхгүй удаагаад байна гэдэг бол нэг өөр асуудал. Заавал нэг л учир байна шүү дээ. Тэсэж ядаад тэр үед нь ямар хугацаанд байх юм? Энэ ерөөсөө болохоо байлаа. Жишээ нь, саяын таны хэлсэн тодорхой хугацаа өнгөрчхөөд нийгмийн анхаарал татсан асуудлууд шийдэгдэхгүй бол тэрний хойноос явж байж болно. Тэр утгаар нь. Яг өнөөдөр хэрэг гарлаа, маргааш нь сошиалаар баахан шуугиуллаа, уур амьсгал бүрдлээ, хууль, хяналтын байгууллагууд дарамтад орох бас ийм болгоомжлол байх тал.

Ялангуяа манайх шиг бол юмнууд дөнгөж эхэлж байгаа энэ үед бол. Тэр үүднээс болоод яг тэр түрүүчийн таны

хэлсэн эрүүгийн хэрэг үүсгэхээд байгаа хэргүүд дээр бол хэрэггүй гэсэн тэр агуулгаар оруулсан. Таны саяын хэлсэн маягаар үнэхээр ужгираад бүүр дарах гээд, нуух гээд, баллах гээд байгаа нь ерөнхийдөө ойлгомжтой болчихсон хэргүүд бага гардаг шүү дээ тийм ээ? Магадгүй тэр үед тодорхой хугацааны юу тавьж байгаад яг бүүр болохгүй бол гэсэн тийм томъёололтой ороод ирвэл бидний хувьд энд тэндээс их татгалзаад байх зүйл байхгүй.

Яг энд ороогүй шалтгаан нь өнөөдрийн нөхцөл байдалтайгаа уялдуулаад л бас л тэгээд сонгууль ч дөхчихсөн байна элдэв юмтай холбоод л хийсэн юм байгаа юм.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Яах вэ дараагийн хүмүүс энэ протоколыг үзэх учраас л би энэ протоколд оруулж байгаа юм.

Яагаад гэвэл энэ эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлыг хяналт санал, хяналт шалгалтын энэ чиглэлийн сонсголыг зэрэгцүүлж хийх асуудал бол маргаантай боловч дэлхийн улс орнуудын жишиг бол удаашираад олон жил болчихсон асуудал дээр л яг энэ парламентын эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудал дээр хийринг /hearing/ хийж болдог байгаа. Тэр нь яах вэ 1, 2 жил биш л дээ тэр чинь олон жил болж байгаа. Таны хэлдэг үнэн.

Ер нь хэрэг бол хагас жил эд нар болж байгаа асуудлууд эрүүгийн хэрэг чинь төвөгтэй байдаг учраас 1 жил, ер нь 2 жилийн хугацаа ихэвчлэн болдог. Ер нь манай энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг харахад, энэ мөрдөн байцааж байгаа байдал эд нар. Тэгэхээр парламент хэзээ оролцох вэ гэдэг асуудал л байгаа юм.

Тэгэхээр хэзээ оролцох вэ гэхээр миний түрүүний хэлдэг эрүүгийн хэргийг

боломжит тэр дээд хугацаа 2 жил ч гэдэг юм уу, хугацааг шийдэж чадахгүй олон нийтийн дунд эргэлзээ тайлагдаж өгдөггүй ингээд байгаад байх юм бол энд нь механизм нь хэвээр үлдэх ёстой гэдэг энэ утгаар нь хэлж байгаа юм. Түүнээс биш ер нь үнэн л дээ. Одоо олон нийтийн дуулиан шуугиан ашиглагдаад бүүр.../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн хариулах уу? Үнэхээр үндсэндээ санал хэллээ. Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би түрүүн бас хэлсэн. Ер нь бол энэ Улсын Их Хурал хянан шалгах энэ үйл ажиллагааг нэлээн үр нөлөөг нь дээшлүүлэх хэрэгтэй гэж. Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 20 онд батлагдахаас өмнө бол ер нь их хэцүү шүү. Үе үеийн Засгийн газрын Ерөнхий сайд, сайдуудад бид нар асуулга тавьдаг. Асуулт хуулийнхаа хүрээнд. Тэрний үр нөлөө их багатай.

Нэг тодорхой жишээ хэлэх юм бол цаг үеийн ач холбогдол нь багасчихсан үед хойно хуримтлагдаж хуримтлагдаж байгаад л сонссон болоод байна. Энэ өвөлжилтийн бэлтгэлийг хангахдаа асуулт тавиад тэр бол ач холбогдлыг нь өнгөрүүлчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг яаж зохицуулсан бэ гэдэг нэг юм.

Нөгөө юм бол энэ ажлын хэсэг байгуулдаг, Түр хороо байгуулна. Ажлын хэсгийн гишүүд тодорхой тоог нь зааж өгөхгүй бол ажлын хэсэгт орно орно гээд орчхоод ажилдаа ирдэггүй, хуралд оролцдоггүй ийм л байдаг шүү дээ. Ерөөсөө үүнийг чинь бол үйлийг нь үзсэн хүн би сууж байгаа шүү дээ. Оюу толгойн чиглэлээр энэ Улсын Их Хурал дээр 2017 оны 11 сард шаардсаар, шахсаар байгаад ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэгт нь хүн ирдэггүй. Аргаа бараад ажлын хэсгийн ахлагч Дэндэвийн Тэрбишидагва бүүр

нээлттэй ил захидал хүртэл бичсэн шүү дээ. Иймэрхүү маягтай л явдаг. Нөгөө нэг юм нь бол энэ дээр яг тоо байг нь зааж өгөх, энэ хүмүүс ажлын хэсэгт орчхоод. Би бол ер нь зориуд сүүлдээ бүүр бодсон юм шүү. Энэ зориуд ажлын хэсэгт орж байгаад үүнийг ингэж жадлан эсэргүүцэх, унагах тийм арга тактиктэй ажилладаг юм биш биз дээ гэж. Тэгэхээр энэ дээр тодорхой хариуцлагыг нь нэмэгдүүлэх ямар механизм юм хийж өгсөн юм бэ? Тэгэхгүй бол энэ чинь үнэхээр болохгүй юм байна лээ.

Нөгөө нэг юм нь ерөөсөө ажлын хэсгийн тоог бүүр хэм намгүй тоог нэмэгдүүлдэг. Одоо ний нуугүй л бодит юмыг хэлье. 2012-16 онд эрх барьж байсан нөхдүүд маань энэ урт нэртэй хууль гэж. Байгаль экологийн тэнцвэрийг хадгалах энэ чухал ач холбогдолтой хуулийг унагаж тэр ойн сан бүхий газар, усны эх бүрэлдэх хэсэг, усны сав дагуу газар алт ухуулах үүднээс нөгөө хуулийг сэглэхийн тулд 19 Улсын Их Хурлын гишүүнтэй ажлын хэсэг хүртэл байгуулсан шүү дээ. Үгүй арай гэж юм буцаасан, дахиад байгуулсан ийм л юмнууд явдаг учраас энэ талаас нь ямар юм байна гэж?

Сүүлийн шинэ түүхийн юм ярья. Хөгжлийн банктэй холбоотой. Хөгжлийн банкны чанаргүй зээл, энэ дампуурал бол зөвхөн банк дампуурах тухай асуудал биш улсаа дефолт руу чирсэн ийм асуудал болсон шүү дээ. Тэгээд Засгийн газар одоо байгаа байдлыг нь нийтэд ил тод мэдээлээд, энэ бол улс төрийн нөлөө бүхий хүмүүс орчихсон учраас энэ асуудлыг бид дийлэхгүй, Засгийн газар ганцаараа хүчрэхгүй байна гэдэг асуудлыг тавиад Их Хурал дээр шаардлага, шахалт тавьж байгаад Занданшатар дарга ажлын хэсгийг шуурхай байгуулж өгсөн. Баттөмөрөөр ахлуулсан, 5 гишүүнтэй. Бид нар 56 хоног энэ ажлын хэсэг дээр ажиллаад бүх булхай юмыг нь гаргаад, ерөнхий сонсгол хийгээд, Түр хороо

үргэлжлүүлж байгуулаад ингээд 1.6 их наяд төгрөгийг нь эргүүлж төлүүлээд ингээд нэг ийм улсаа дампуурлаас гаргах юмнаас гаргаж авсан шүү дээ. Энэ дотор бол юу аль харагдаж байсан гэхээр зэрэг тэр дэд ажлын хэсэг байгаа юм. Бид нар төрд тангараг өргөчихсөн энэ холбогдох төрийн байгууллагын хүмүүсийг 40 гаран хүн татаж авчраад ажиллуулсан экспертүүд, мэргэжлийн хүмүүс гэж байгаа юм. Тэр дотор бол бас явдал байсан шүү.

Тухайлах юм бол энэ Хөгжлийн банкнаас улс төрийн нөлөө бүхий хүн зээл авчхаад ирээдүйд олох орлогоороо иргэдэд тийм нөхцөлтэй зээл олдох уу? Ёстой харагдаач гэдэг шиг л юм болно шүү дээ. Тэр бол хуулийн зөрчилтэй шаардлага хангахгүй байна гэж.../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн хууль санаачлагч асуултад хариулна.

Н.Энхболд: Энэ гурван хууль гурвуулаа хоорондоо бас уялдаатай гэдгийг түрүүн хэлчихсэн байж байгаа. Яг энэ хуулийн хувьд Түр хороонд орох, Хяналт шалгалтын түр хорооны гишүүний бүрэлдэхүүн 7-31 хүнтэй байна. Мэдээж хэлэлцэж байгаа асуудлын хамрах цар хүрээ, шалгалтынхаа их, багаас хамаараад энэ тоог нь тухай тухай үедээ тогтоогоод явна.

Тэгээд 1 гишүүн үйл ажиллагаа явуулж байгаа 1-ээс дээш Түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллахгүй гэж. Өөрөөр хэлбэл би Бат- Эрдэнэ гишүүний ярьж байгаатай бас санал нэг, бид нарын бас нэлээн хэдэн жил Их Хуралд явах тийм тохиолдлууд гарч байсан. Энэ хууль байхгүй байхад аливаа ийм асуудлыг шалгахдаа ажлын хэсэг гэж юм гаргадаг байсан юм. Учиргүй ингээд хэсэг хүн санаачлаад явдаг тэгээд зайлшгүй л сонсохоор, үнэхээр тийм шалгах шаардлага байгаа юм шиг санагдаад

ажлын хэсэг байгуулдаг. Нөгөө улсууд өөрснөө ордог, зарим нь тодорхойлдог, 2, 3 тийм жишээ хэлж болно.

Эцсийн сонирхол нь яг өөрсдийнх нь нөгөө эрх ашигтай зөрчилдсөн зүйлийг, эс үгүй бол магадгүй эрхэлдэг бизнесийнх нь өрсөлдөгчтэй холбоотой юмыг шалгах түрүүгээрээ эргээд янз бүрийн өөрсдөдөө ашигтай шийдвэр гаргуулах юм хийх гэж оролдож байсан зүйлүүд нь ч хүртэл илэрч л байсан юм байгаа юм. Тэгэхээр энэ хуульгүй үед нэг тиймэрхүү юм байсан.

Тэгээд хуультай болсноос хойш эрх ёсны хуулиар зохицуулалттай болохоор ашиг сонирхлын зөрчлийнх нь асуудлуудыг нь шалгадаг, бас тодорхойлдог тийм байгаа бол оруулахгүй байх зохицуулалтыг хүртэл Түр хорооны бүрэлдэхүүнд оруулахгүй гээд, хориглоно гээд заачихсан байгаа ийм.

Тэгээд бүүр цаашилбал жишээ нь, шалгалтын сэдвээс хамаараад хэрэв шаардлагатай гэж үзвэл тэр цөөнхийн төлөөллөөс даргыг нь томилж байж болох тухай заалтыг хүртэл энэ дээр оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ бол урьд нь гарч байсан шиг тийм зүйлүүд гарах ийм хаалтууд болж чадаж байгаа болов уу л гэж ингэж үзэж байна. Ер нь хувь хүний ухамсар тэр хүний ажлын хэсэгт оръё гэж байгаа, эс үгүй бол Түр хорооны бүрэлдэхүүнд оръё гэж байгаа яг тэр хувийн цаад дотроо бодож байгааг нь тодорхойлоход хэцүү л дээ. Зүгээр амьдрал, ажлынх нь түүх, бусад юмнаас нь эрхэлдэг ажил, ар өвөр, хэлхээ холбоо юмнаас нь судалгаа хийж байгаад энэ дээр яах аргагүй эрх ашгийн зөрчилтэй байна гэдгийг нь тодорхойлж болох ийм бас боломжууд байгаа. Үүнийг хуулиар зориуд бий болгож өгснөөрөө л энэ хууль ач холбогдолтой болно л гэж ойлгож байна. Бусад зүйл дээр бол гишүүнтэй санал нэг байна.

Г.Занданшатар: Бадмаанямбуу-

гийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Би түрүүн цаг багтаагүй юм. Тэр Хөгжлийн банкны асуудал чинь бол амь өрссөн гэдэг шиг энэ улсаа дампууруулах уу яах вэ гэдэг дээр холбоотой асуудал байлаа шүү дээ. Тэгээд улс төрийн нөлөө бүхий дандаа улсууд, ирээдүйд бий болох үл хөдлөх, ирээдүйд олох орлогоор барьцаалаад хэчнээн зуун арван, хэчнээн зуун тэрбумаар нь зээл авчихсан. Тэрийгээ эргүүлж төлдөггүй, чанаргүй зээлийн ангилалд оруулчихсан. Хамгийн ноцтой нь бол тэр ажлын дэд хэсгийн мэргэжлийн гэж байгаа хүмүүс хуулийн зөрчилтэй байна, шаардлага хангаагүй байна гээд ингээд цаасан дээр хараар бичиж ажлын хэсгийнхэнд танилцуулчихаад 2 хоногийн дараа хуулийн зөрчил байхгүй, шаардлага хангасан гээд ингээд оруулаад ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бол энэ хуулиар тэр хүмүүст ямар хариуцлага тооцох юм бэ? Тэд нар чинь төрд тангараг өргөчихсөн улсууд байгаа шүү дээ. Гэхдээ л ийм хандлага гаргадаг, ийм бүүр арай хэтэрмээр ийм зүйлүүд гарч байсан тохиолдол бий байхгүй юу. Тэгэхээр энэ дээр зохицуулалтыг нь хийе.../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга.

Н.Энхболд: Бат-Эрдэнэ гишүүний ярьсан асуудлууд жишээ нь, гэрч дээр ч гарч байгаа юм, хянан шалгагч дээр ч гарч байгаа юм, шинжээч дээр ч гарч байгаа юм. Янз бүрийн байр сууриас өнөөдөр гаргасан юмаа маргааш нь өөрчилдөг, эс үгүй бол анхнаасаа санаатайгаар, зорилготой тийм мэдүүлгүүд, дүн шинжилгээ гаргаж өгдөг ийм зүйлүүд сая бид нар хуулиа батлаад хэд хэдэн удаагийн сонсгол явуулахад Түр хорооны сонсголууд

явуулахад ажиглагдсан гэж явцаас нь дүгнэж байгаа.

Тийм учраас нэгдүгээрт яг ямар хүмүүсийг шинжээчээр томилох вэ, гэрчээр дуудах вэ, хянан шалгагчаар томилох вэ гэдгээ энэ дээр үзүүлэлтүүдийг нь тавьж өгсөн. Тэр үзүүлэлтүүдээ нарийн баримтлаад, зөв томилох асуудал бол тэр Түр хорооны өөрийнх нь хариуцлагын асуудал болж байгаа юм. Хэрэв тэр томилогдсон улсууд гэрч, шинжээч, хянан шалгагч санаатай, санаандгүйгээр ямар нэгэн байдлаар буруу шийдвэр гаргаж өгсөн тэр нь хяналт шалгалтын ажилд муугаар нөлөөлсөн ийм нөлөөлсөн юм уу, нөлөөлөх байдалтай байвал зөрчлийн, бүүр хүндрүүлэх шалтгаантай гэж үзвэл Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх ийм заалтууд л орсон байгаа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн бас дахин давтан асуусан. Энэ Хөгжлийн банкны ажлын хэсгээр энэ хяналт шалгалтын хууль 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан. Манай Сүхбаатар нарын, Сүхбаатар гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаад ингээд яг 1 сарын 1-нийх нь өдөр Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн, Баттөмөр гишүүн нарын санаачилгаар Хөгжлийн банкны асуудлаар хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг дээр энэ Хөгжлийн банкны асуудлууд, мэдээллүүд ирж, энэ Хөгжлийн банкны зээлтэй холбоотой болохоор төсвөөр чинь нийгмийн анхааралд ороод тэгээд дараа нь 4 сарын 15-ны өдөр Хяналт шалгалтын түр хороо байгуулаад Хяналт шалгалтын түр хороо энэ нээлттэй сонсгол зохион байгуулсныг 3 үе шаттай сонсгол болсныг та бүхэн мэдэж байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсгийг Хяналт шалгалтын түр хороо руу дараа нь асуудал байвал явуулдаг ийм механизмыг энд хуульд 9 дүгээр зүйлд хийж өгсөн байгаа юм.

9 дүгээр зүйлд хяналт шалгалтын сэдэв, тоо заагаагүй. Тэгэхдээ сэдэв, хүрээ, яаж ажиллах журам удирдамжийг батлахаар энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан. Бас энэ ажлын хэсэг тэгээд л ажиллахгүй яваад байвал 12 сардаа бүх Байнгын хороод энэ хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн ажлыг дүгнээд, байгуулсан ажлын хэсэг дээрээ дүгнээд цаашид ажиллуулах уу, үгүй юү гэдгээ шийддэг хуралдаанаараа. Татан буулгавал хэрэггүй бол татан буулгаад явдаг ийм механизм хуульчлагдсан байгаа.

Ер нь энэ хуулийн л үр дүнд энэ бүх далд байсан хулгайнууд ил гарсан гэдгийг л бид бас онцлон тэмдэглэх ёстой.

Г.Занданшатар: Одоо Дашдондогийн Ганбат гишүүн. Энэ хуульд идэвхтэй ажилласан гишүүн шүү дээ манай.

Д.Ганбат: Энэ юу л даа. Энэ хууль дээр засаж сайжруулах ийм зүйл олон байгаа. Гэхдээ нэг авууштай юм нь энэ парламентаар бид бүхэн энэ хуулийн хэрэгжилт, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулдаг болсон. Үүнийг бас онцлон тэмдэглэх ёстой. Тэгээд үүгээр илэрч гарч ирж байгаа юм бол ард түмэн үнэхээр мэдээд зах зухаас шүү дээ. Энэ чинь нөгөө хүрээний бузрын бараг 100-ны 1 нь л гарч байгаа байхгүй юу. Зах зухаасаа.

Энэ чинь бараг юу л даа бусад газруудад хяналт шалгалтын хороо энэ ардчилсан улс орнуудад бүгд л байдаг, ажилладаг. Энэ парламентын бас л нэг хэрэгсэл л дээ. Манай Монгол Улсад бүх юм нь байгаад байх шиг байгаа юм. Ажлын, институтийн. Тэгсэн мөртөө нэр төдий бүгдээрээ. Нөгөө ард түмнийг засаглах эрх нь бүүр тийм сайн хангагдаж өгөхгүй байна шүү дээ. Манайхан чинь хүн ам цөөтэй ч юм, нутаг нугаараа их ч тал нутаг руу ч яах юм, анги юугаараа ч бас явах юм,

намаараа ч явах юм. Эцэст нь ард түмэн л хохироод байгаа юм л даа. Уул нь тэр Германы хуулиас хуулбарлаад аваад хэрэглэсэн. Тэнд энэ сонсголыг цөөнх нь удирдаж явуулдаг л даа. Тэгж байж байж энэ сонсгол үр дүнтэй, хэрэгтэй болдог.

Гэтэл үүнийг олонх нь илүү тоотой байхаар. Олонхоос тавьсан хүн удирдахаар, тэр байтугай Засгийн газрын гишүүн сайд хүн удирдахаар ингэж хийгээд байгаа байхгүй юу. Анхны тэр сонсголыг хийе гээд тэр Хөгжлийн банкин дээр, бас нүүрсний хулгай дээр явуулсан. Доржханд гишүүн бид хоёр санаачлаад 21 хүний гарын үсэг зуруулаад явсан. Ингээд явж байхад, харж байхад бол бие бие дотроо зүгээр гарах юмаа гаргаад, гаргахгүй юмаа гаргахгүй ийм байдалтай явж байна. Нөгөө ирж байгаа гэрчүүд нь ирэх, ирэхгүй янз янз байна. Ирчхээд тэр индрийг ашиглаж хүмүүсийн толгойг угааж байна. Бусад сонсгол явуулж байхад бол яг тэр Үндсэн хууль дээр нь гараа тавиад үнэнийг мэдүүлээд, хэрвээ худал мэдүүлсэн байдаг юм бол, худал ярьсан байдаг юм бол зохих хариуцлагаа хүлээгээд, шийтгэлтэй байдаг. Мөн гэрч нь ирэхгүй бол тэр байтугай 6 сараар хорьдог иймэрхүү зүйл, заалтууд оруулсан уу? Тэгэхгүй бол эрэмдэг зэрэмдэг хууль хийчхээд тэрийгээ хэрэглэж байна гээд яваад байдаг, үр дүн нь байхгүй гээд.

Энэ монголын ард түмэн, монголчууд маань болоогүй байна, эд нарын хэр хэмжээнд нь тааруулсан ийм юм хийгээд одоохондоо аргалаад явж байя гэсэн иймэрхүү маягтай явж болохгүй байна. Одоо шинэ бүрэлдэхүүн гарч ирэхээр энэ хуулийг нэлээн сайн сайжруулах ёстой гэж би бодож байна. Энэ хуулийн хэрэгжилтийг шинэчилж байгаа нь сайн байна, сайжруулж байгаа нь сайн байна. Хэдийнээс хэрэгжиж эхлэх юм, яах юм? Нөгөө заавал хэн нэгэн хүний илд байна л гээд байгаа. Үгүй энэ чинь ард түмний л илд байх ёстой шүү

дээ. Иймэрхүү маягаар бас ажиллаж болохгүй. Энэ дээр нь зохих хэмжээний зөв чиглэл рүү нь явуулах энэ заалт юм, хум орж ирж чадаж байна уу, үгүй юү? Наад шинэчилсэн хуулийн ажлын хэсэг байгуулагдах байх. Олонхоос л дандаа санаачлалдаг хэдэн гишүүн.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн. Төрийн байгуулалтын байнгын хороон дарга асуултад хариулна.

Н.Энхболд: Ганбат гишүүний асуултад хариулъя. Түүрүүн би уншсан энэ заалт дээр байж байгаа. Жишээ нь, цөөнхөөр удирдуулж байх заалт орсон байгаа. Асуудлаа ярьж байгаад дотроо цөөнхөөр удирдуулбал урьд нь тийм юм байхгүй байсан шүү дээ. Анхдагч хууль болохоор бас бидэнд дутуу хүтүү бодсон зөндөө л юм байсан байх. Тэгэхдээ нэг юман дээр бүх гишүүд санал нэгдэж байгаад би их баяртай байна. Энэ Их Хурал энэ хуулийг батлаад, хэрэгжүүлэх энэ ажлыг хийж эхэлчихсэн юм.

Тийм учраас би түүрүүн бас танилцуулга дээрээ ч хэлсэн. Энэ түүхэн ажлыг эхлүүлсэн түүхэн гавьяа байгуулсан Их Хурал тэрний нэг нь энэ ажил мөн шүү гэж. Энэ дээр Ганбат гишүүн санал нэг байгаад би бас буруу дүгнэлт хийгээгүй юм байна гэж өөрийгөө бодож сууна.

Нэгдүгээрт, тэр цөөнхөөр удирдуулдаг тогтолцоо орж байгаа. Түр хорооны тусгай шалгалтын сэдвээс нь хамаараад шаардлагатай гэж үзвэл Түр хорооны даргыг Түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн төлөөллөөс сонгоно гээд үгээр бичээд оруулчихсан шүү. 33.7 дээр байгаа. Гамбаа гишүүнээ та хараарай.

Шүүмжлэлтэй хандсан бас зүйл байна. Жишээ нь, нэг Түр хороог сайд удирдаад яваад байна гээд. Сайд чинь мэдээж олонхын төлөөлөл байж таараа. Тэгэхээр энэ удаа бид нар ер нь Байнгын хороо, Түр хороо, Дэд хороонуудыг сайд

нар, ерөөсөө Засгийн газрын гишүүд удирдахгүй, Ерөнхий сайд удирдахгүй гэсэн заалт бас хуульд оруулаад батлуулах гээд явж байна. Дэмжээд явчихвал таны саяын тэр одоогоор мөрдөж байгаа хуульд байгаа дутагдлуудын нэг энэ байна шүү гэдэг нь явчихна шийдэгдчихнэ. Яг энд батлагдчихвал.

Хэдийнээс эхэлж мөрдөх юм бэ гэж байгаа. Бид нар ер нь энэ шинэ Их Хурал 24 оны сонгуулиар байгуулагдаад л үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс л мөрдөгдөнө гэж тооцоод бүүр тэр үгээр нь оруулчихсан байж байгаа. 24 оны ээлжит сонгууль байгуулсан Их Хурлын анхдугаар чуулган хуралдаан эхэлсэн өдрөөс эхлээд дагаж мөрдөнө гээд оруулчихсан байж байгаа. Энэ анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч зарладаг болохоор яг хэдийд яаж зарлахыг мэдэхгүй. Чуулган эхэллээ тэр өдрөөс хүчин төгөлдөр мөрдлөг болно.

Олонхоос оруулсангүй гэнэ. Би олонхоос орооч гэж санал тавьсан Ганбаа гишүүнээ. Хэнтэй айн? Цогтгэрэл даргатай уулзсан, Одонтуяа даргатай уулзсан. Үүнийг хамтраад боловсруулъя гэсэн та нар өөрснөө боловсруулчих, бид нар хэлэлцэхэд нь оролцоод явъя гэсэн. Түүнээс бид санаатайгаар энд л цөөнхийг оруулахгүй юм шүү гэж ингээгүй юм шүү. Тэрийг та бас ойлгоорой. Мэдээлэлгүй байж магадгүй. Ийм байна.

Н.Энхболд: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна.

Д.Ганбат: Яах вэ ард түмэн аргаа бараад ирэхээр Улсын Их Хуралд найдлага тавьдаг л даа. Энэ хулгайч, энэ авлига, хээл хахууль гараад ирэхээр энэ цагдаагийнхан, хулгайч нар засаглаж эхэлдэг ийм зүйл байдаг. Ер нь манайх тэр рүүгээ л явж байна. Явчихсан, бие биеэ барьцаалчихсан. Энэ чинь хэд хэдэн сонсгол дээр суулаа. Ингээд харж байхад энэ Их Хурлын бараг тал нь гэрчээр

дуудагдаад суучих юм байна шүү дээ. Тэгээд л энэ талд гараад, нэг цаад талд гараад л зовлонтой юм байна лээ. Хэн ч асуугаад байгаа юм, хэн ч хариулаад байгаа юм. Нэг тийм юм байх юм. Тэрийг яадаг юм? Одоо тэгээд нүүрсний хулгайч нар, Хөгжлийн банкны зээл авагчдын хамаатан садан, гэр бүлүүд бүгд нэр дэвшинэ гээд явж байна шүү дээ. Энэ сонсголын чинь үр дүн, энэ хуулийн чинь үр дүн ийм л байна шүү дээ.

Г.Занданшатар: Ингээд асуулт уу, санал шүүмжлэл үү гэсэн асуултад хариулах юм байна даа. Нямаагийн Энхболд гишүүн хариулчих.

Н.Энхболд: Би Ганбат гишүүнийг ерөнхийдөө саналаа хэллээ. Өнөөдөр нийгэмд байгаа зүйлүүдийг. Жишээ нь, энэ сонсгол дээр нэг нөхөр орчхоод л нэг гэрч болоод л, нэг байцаагч болоод л суугаад байх юм тэрийг яах юм бэ бид одоо би яг энэ танд хариулж мэдэхгүй байна. Миний санаачилсан хууль батлагдаад, мөрдөгдөөд эхэлбэл тийм зүйл гарахгүй байх л гэж би бодож байна. Тийм тийм.

Н.Энхболд: Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би асуулт асуухгүй. Хэдэн санал хэлье. Энэ удаагийн парламентын хамгийн чухал баталсан хууль бол энэ Хяналт шалгалтын хууль. Үүний дагуу бол маш олон сонсголууд хийж, үр дүнд хүрч байгаа. Би энэ Түр хорооны даргаар, гишүүнээр ажиллаж байсан хүний хувьд хэдхэн зүйлийг их тодорхой болгох их шаардлагатай юм байна лээ гэж үзээд байгаа юм.

Жишээлбэл, энэ шинжээч хянан шалгагчдыг өмнө нь огт шалгуур байхгүй хэн ч орж болохоор ийм зүйлүүд байгаа юм. Тэгэхээр би бол цаашидаа гадуур бас хүн хайдаг. Тэрний оронд Их Хурлын Тамгын газар бүтцэдээ ерөөсөө хяналт шалгалтын хэлтэс дээрээ бүүр мэргэшүүлээд хэдэн шинжээч, хяналт

шалгагчтай болмоор юм билээ. Тэд нар өөрөө мэргэшээд, тэгээд цаашаа тухайн сэдвээсээ шалтгаалаад мэргэжлийн инженер юм уу яг тэр салбарын шинжээчдийг нэмж авах шаардлагатай бол нэмээд шинжээч, хянан шалгагчдыг аваад явдаг ийм механизм руу орохгүй бол их төвөгтэй байгаа юм.

Дараа нь тэр шинжээч нар, хянан шалгагч нар гаргасан дүгнэлтдээ хариуцлага хүлээдэг. Хэрэв буруу дүгнэлт гаргаад хэн нэгэн хүнийг буруутгачихсан байх юм бол тэндээ өөрөө хариуцлага хүлээдэг байхгүй бол ямар ч хамаагүй дүгнэлт гаргаад. Өмнө нь бас маш дутагдалтай, буруу дүгнэлтүүд гаргасан юмнууд зөндөө байгаа.

Цаашидаа энэ Түр хорооны даргын эрх, үүрэг нь, гишүүдийнх нь эрх, үүргийг жаахан тодорхой болгож өгөхгүй бол одоогийн байгаа байдлаар энэ Түр хорооны гишүүд бол ирц бүрдүүлдэг, шинжээч, хянан шалгагчийг томилоход оролцоод л, сүүлд нь гэрч дуудахад оролцоод л ингээд л бусад юманд нь ерөөсөө оролцож байгаа юм ерөөсөө огт байхгүй байгаа юм.

Тэгэхээр зэрэг үүнийг бас энэ гишүүд нь, олонх нь шаардах юм бол хуралдаж тэр асуудлуудаа сонсдог ийм юм руу явахгүй бол ганцхан ингээд даргын өөрийнх нь үзэмжийн асуудал болоод явж болохооргүй байгаа юм.

Нөгөө талаасаа нийгэм бол ганцхан хүсээд байгаа юм нэг ийм л байна л даа. Энэ сонсгол хийгээд ямар үр дүн гарсан бэ гэдгийг асуух юм. Нүүрсний сонсгол хийгээд хэдэн хүн шийтгүүлсэн юм, тэндээс хэдэн төгрөг буцааж хурааж авсан юм гэдэг юмнууд байнга асуух юм. Тэгэхээр зэрэг энэ Түр хорооны сонсгол хийгээд дуусах биш, дараа нь үүний үр дүнг тайлагнадаг заалттай болмоор юм билээ. Энэ сонсголын дагуу ямар арга хэмжээ авав? Тэр хуулийн байгууллагууд нь бас нийтийн эрх ашиг

хөндөгдөөд сонсгол хийсэн асуудлаар бас арай жаахан түргэвчилсэн горимоор хэлэлцэж барьдаг ч юм уу ийм зүйлүүдийг оруулж явахгүй бол их төвөгтэй байгаа юм.

Ер нь цаашидаа энэ Түр хороо байгуулахад саяын хэлээд байгаа ер нь цөөнхийн хүмүүс дарга болно гэдэг бол ерөөсөө бас буруу зүйл биш юм байна лээ. Тэгэхгүй энэ дээр ингээд бөөрөнхийлчихсэн. Хэлэлцэж орж тухайн асуудлаас шалтгаалаад гэж байгаа байхгүй юу. Үгүй ямар асуудал байвал цөөнх нь даргалах юм? Ямар асуудал байх юм бол олонх даргалж болох юм гэдгийгээ тодорхой заахгүй бол тэгээд л ярьж байгаад л энэ болохгүй асуудал байна л гэвэл л олонх даргалаад л явахаар ийм юм байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бас жаахан маш тодорхой заалтууд оруулах ёстой юм байна лээ.

Тэр хяналтын ерөнхий сонсголыг ч гэсэн ер нь бол арай өөр хэлбэр рүү энэ гаднын орны сонсголын хэлбэр рүү оруулаад тэр иргэдийн, тухайн ганц иргэний өмнө хөндөгдсөн асуудлаар сонсгол хийнэ, хяналтын ерөнхий сонсгол хийнэ гэх юм бол их төвөгтэй юм байна лээ шүү дээ. Бид нар чинь энэ ордонд л сонсгол хийх гэж бөөн хүмүүс, энэ их танхимаар дүүрэн хүмүүс орж ирээд л орилж чарласаар байгаад л сонсголотой манатай юм болоод л гарсан. Үүнийг бас их тодорхой болгож, хяналтын ерөнхий сонсголыг ямар асуудлаар хийх юм, тэрийг нь яг ямар журмаар бүүр журамлаад чуулган дээрээ хийх юм уу, эсвэл тусад нь тийм хороо байгуулж хийх юм уу гэдгийг их тодорхой болгож явахгүй бол энэ ажлын хэсгүүдэд нь ороод бас энэ Хяналт шалгалтын хуулийг маш.../минут дуусав./

Г.Занданшатар: Санал хэллээ.

Гишүүд ээ чуулганы хуралдааны танхимд цуглая. Санал хураалт явуулна.

Үүний өмнө дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу?

Адьяаа, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Занданшатараар төгсгөлөө. Дашдондогийн Ганбат гишүүн. Үгүй ээ, үгүй үг хэлэхгүй.

Д.Ганбат: Ер нь энэ Хяналт шалгалтын хуулиа сайжруулах нь зүйтэй. Гэхдээ бас ямар ч байсан ингээд саяын Улсын Их Хурлын бүрэн эрхийн ийм ард түмэн бас бага ч гэсэн мэдэх эрхээ эдэлж чадлаа. Тэрний зах зухаас нь мэдэхэд үнэхээр нүд нь орой дээрээ гарч байгаа байхгүй юу. Ийм байдаг юмаа тээ, тэр олон том компаниуд, сүрхий бизнесменүүд гээд байсан чинь бүгдээрээ л татвар төлөгч бидний мөнгөнөөс маш их хямдар 3-хан, 6-хан хувийн хүүтэй зээл авчхаад төлдөггүй л юм байна шүү дээ гэж байгаа байхгүй юу. Ийм л байсан юм байна. Тэр хэн хэн байгааг нь бүгд харж байна. Зах зухаас нь гэх мэтчилний ийм сайн талууд байна байна.

Нөгөө талаар сая манай гишүүн үг хэллээ. Тэр үнэн л дээ. Захиалгаар явдаг, дэглэдэг, үгүй тэгээд үр дүн дараа нь байхгүй. Одоо үүнээс нь дараа нь ард түмэн чинь залхаж эхлэх гээд байна шүү дээ. Тэр сайн сайн юмнуудыг оруулж ир. Орж ирээд худлаа ярьж байна. Мөн энэ олон хэрэгтэй, хэрэггүй Байнгын хороо зөндөө л байх юм. Яг энэ хэрэгтэй юман дээрээ тодорхой тооны энэ хурлыг зохион байгуулах хүмүүсийг тавихгүй бол мөнгө санхүү нь байхгүй. Зайлуул энд тэндээс 5 төгрөг олчих уу, 10 төгрөг олчих уу, яаж хийх вэ гээд ажил хийх гээд гүйгээд явж байгаа олон, бас энэ сонсголыг удирдаж байсан дарга нарыгаа бас хараад гишүүдийгээ хараад бас үгүй ээ ингэж явуулаад яах вэ дээ энэ олонх энэ тэр гэж заримдаа бодогддог юм байна лээ шүү. Гэхдээ яах вэ ямар ч байсан эхэлсэн нь сайн байгаа.

Нөгөө талаар тэр сонсгол яаж явж олон түмэн мэддэг болчихжээ. Ард түмнээ битгий бас. Бид нар чинь Солонгост очиж байна, ажиллаж байна,

амьдарч байна. Америкт очиж байна, амьдарч байна. Энэ залуучууд чинь бүгд Англи хэлтэй болчихсон байна, мэдээлэл авч байна. Хаана, ямар сонсгол яаж явж байгааг харж байна шүү дээ. Тэр хулгайч нар чинь шууд хууль, хяналтын байгууллагад шилжээд л явчхаж байгаа байхгүй юу. Тийм үр дүнтэй сайн сонсголдууд хийх хэрэгтэй.

Нөгөө талаар саяын өнгөрсөн 4 жилд бас Ерөнхий сайдын мэдээллийг бид нар Улсын Их Хурлын чуулган дээр 5 дахь өдөр ерөөсөө сонссонгүй шүү дээ. Ийм 4 жил өнгөрлөө. Уул нь энэ их ард түмнийг төлөөлж байгаа, том ард түмнийг төлөөлж байгаа бага ард түмэн. Тэгээд Ерөнхий сайд чинь ажил хийж байгаа л хүн байхгүй юу. Тэр хүн ирээд ард түмэндээ тайлангаа тавиад, буруу, зөвөө сонсоод Засгийн газраа сайн ажиллуулчих ийм боломж, бололцоог бусад газрууд дүүрэн ашигладаг байхгүй юу. Гэтэл манайд тийм юм байсангүй.

Тэгээд хоёрын хооронд яльтай шальтай юмаар сонсгол хийхээ болих хэрэгтэй. Тэр яг нийтийн эрх ашгийг хамарсан тийм сонсголдуудыг явуулах хэрэгтэй. Тийм сонсголдууд нь аягүй удаан байна. Тэр ногоон автобусны цавчаа байна, чанаргүй эмийн асуудал байна, энэ ажилгүйдлийн асуудал байна. Энэ хөдөө орон нутагт бэлчээр, малчдын амьдрал ахуй хүндэрчихсэн байна. Үгүй энэ гурилын үнийг буулгах гэж юу вэ бараг хагас жил болж байна уу, бүтэн жил болж байна уу? Үгүй ядаж би тойрог руугаа гурилын үнийг нь жосоохон хямдруулчихаад ч болох нь очих юм сан. Тэр хуралд нь суух гээд би хүлээгээд байгаа. Юун дээрээ саатаад байдаг юм, яадаг юм? Болохгүй бол сонсгол хийх ёстой юм уу ийм мэтчилний юмнууд байх юм. Тэгэхээр энэ хуулиа сайхан янзлаад оруулчих. Дэмжиж байна.

Гэхдээ хамгийн түрүүнд орж ирээд дараагийн Улсын Их Хурал дээр хамгийн түрүүнд хамгийн сайжруулах зүйл бол энэ. Магадгүй та нар цөөнх

болчихсон байх тэр үед. Ер нь тэр яагаад хүүхдийн хүчирхийллийг бэлгийн хавьталд 14 наснаас дээш орж болно гээд заачихсан.Одоо та нар ялах юм бол аягүй л 12 наснаас, 10 наснаас доош гэж хуульд өөрчлөлт оруулах нь л дээ. 2017 онд ингэчихсэн. Тэрийг чинь энэ.../минут дуусав./

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Өнөөдөр энэ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж байна л даа. Энэ 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын үйл ажиллагааг ард түмэнд нээлттэй байлгах, ард түмний мэдэх эрхийн хүрээнд хууль тогтоох байгууллага тодорхой мэдээлэл өгөх ийм зорилгоор энэ Хяналт шалгалтын тухай хуулийг баталсан гэж ойлгож байгаа. Энэ хяналт шалгалтын тухай хуулийн дагуу энэ Улсын Их Хурал олон Түр хороо байгуулж, хяналт шалгалт явуулсан. Энийг ард түмэнтэйгээ бид энэ төртэйгөө хамт мэдэж байгаа. Үүний үр дүн юу болов? Энэ асуудалд бид маш их тодорхой бодлоготой, тодорхой хуулийн хүрээнд энэ өөрчлөлтийг хийх ёстой.

Энэ сонсголдууд өнөөдөр ард түмэн их юм хүлээж байсан.

Гэтэл үүний үр дүн гэж ерөөсөө байхгүй. Өнөөдөр сонсголыг зохион байгуулж байгаа, сонсголыг даргалж байгаа хүмүүс өөрсдийгөө мөрдөгч гэж ойлгодог. 1937 оны Онцгой бүрэн эрхт комисс шиг л юм болсон шүү дээ. Тэгээд өнөөдөр тэр Нүүрсний сонсгол, Хөгжлийн банкны сонсголын үр дүнд юу болов гэдэгт бид бүгдээрээ харж байгаа. Энэ сонсголыг тодорхой зорилгоор явуулах ийм муухай жишиг энэ Улсын Их Хуралд тогтсон л гэж харж байгаа. Өөрсдийнхөө намын зөрчилтэй, улс төрийн өш хонзон авах ийм зорилготой хүмүүсийг тодорхой зорилгоор ялладаг,

сөрөг хүчнийгээ энд хамаатуулахыг оролддог, том том гэмт хэргүүдийг дардаг, жижиг зүйлийг том болгож харуулдаг ийм жүжиг болгох асуудал энд байж болохгүй. Энэ асуудлыг ингэж бид Улсын Их Хурал дээр авч ирж, аливаа асуудлыг шүүдэг, цагддаг, мөрддөг ийм байдлаар энэ асуудлыг шийдвэл энэ төрийн эрх барих дээд байгууллага, төрийн эрх мэдлийн хуваарилалт чинь юу болох юм бэ гэдэг ийм эргэлзээг ард түмэнтэйгээ бид харсан.

Улсын Их Хурал өөртөө мөрддөг, шалгадаг ийм байгууллага байна гэж ард түмэнд харуулахыг оролдоод энэ нь эсрэгээрээ төрийн эрх барих дээд байгууллагын нэр хүнд ямар түвшинд очив, ямар асуудалд очив гэдэг дээр өнөөдөр бид ард түмэнтэйгээ харж байгаа.

Тийм учраас энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг ямар зарчмаар явуулах юм, ямар асуудлыг шийдэх юм, ямар шийдлийг олох юм гэдэг асуудал дээр бид өнөөдөр шийдэл гаргах ёстой. Энд бид нар бол олон зүйлийг харсан, олон зүйл дээр би өнөөдөр харж байгаа. Тэгээд энд олон том том асуудал гарлаа гээд өнөөдөр бид хууль, хүчний байгууллага руу шилжүүлээ гэдэг ийм асуудал гарсан. Тэгэхлээр энэ Улсын Их Хурал дээр яригдсан энэ асуудал чинь нотлох баримт болох юм уу, шүүхийн нотлох баримт болох юм уу гэдэг асуудал.

Нөгөө талаас энэ шинжээч нар гэдэг хүмүүс байгаа. Энэ хүмүүсийн дүгнэлт нотлох баримт болох уу? Энэ хуурамч нотлох баримт гаргасан, хуурамч зүйл ярьсан юм бол энэ хариуцлагыг нь хэн хүлээх юм гэдэг асуудал байгаа. Үүнийг Эрүүгийн хуулиар шийдэх юм уу? Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар шийдэх юм уу? Өнөөдөр хуурамч нотлох баримт зөндөө гарсан энд. Том том ноцтой гэмт хэргүүдийг дарсан. Тэр оффтейк гэрээ, Хөгжлийн банк гээд. Үүний хариуцлагыг хэн хүлээх

юм? Шинжээч нар хүлээх юм уу? Энийг өнөөдөр энэ Түр хороог удирдсан тэр хүмүүс хүлээх юм уу? Улсын Их Хурал дээр үг хэлснийхээ төлөө Улсын Их Хурлын гишүүн хариуцлага хүлээлгэдэггүй гэдэг энэ бодлогын хүрээнд, энэ хуулийн хүрээнд өнөөдөр дураараа юм ярьсан шүү дээ. Дураараа юм ярьсан. Энэ нотлох баримт болох юм уу шүүхийн хэмжээнд? Худал хүнийг гүтгэсэн, худал мэдээлэл гаргасан бол тэр хүн хуулийн хариуцлага хүлээх юм уу гэдэг энэ асуудлыг хүртэл өнөөдөр Улсын Их Хурал дээр авч, энэ Хяналт шалгалтын хуулиар шийдэх ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн. Дараа нь санал хураалт.

Ж.Сүхбаатар: Ер нь энэ манай гишүүд хэлж л байна л даа. Мэдээж сонгууль ойртчихсон байж байна. Сөрөг хүчин, эрх баригч хүчин гээд энэ хуулийн төсөл байхгүй юу. Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, парламентын хянан шалгах үндсэн чиг үүргийг яаж бүтээмжтэй хэрэгжүүлэх вэ гэдэг ийм механизмыг энэ удаагийн Улсын Их Хурал 2021 оны сүүлээр баталсан байхгүй юу КОВИД-ын үеэр.

Энэ хэрэгжүүлэх, зохион байгуулах ажил нэг жил хагас л явж байна шүү дээ манай энэ гишүүд бас ойлгомоор байгаа юм. Сүүлийн 30 жил өмнөх парламентууд ийм сонголыг хийгээгүй байхгүй юу даа. Хийж байсан туршилага байхгүй, хууль байхгүй. Оролдлого байсан байх. Тэгэхдээ энэ удаагийн парламент энэ Занданшатар Их Хурлын даргын үед үүрэг, даалгавар өгөгдөөд бид хэд олон гишүүд оролцоод ингээд хэдүүлээ хийгээд энэ сонголуудыг хийлээ. Үр дүн хаана байна гэж? Үр дүнг хаана, хэнээс нэхэх вэ гэж.

Тэгэхээр энэ дээр эрх баригч, сөрөг хүчин гэж нэхэхээс илүүтэй хуулийг хэн биелүүлэх вэ, хэн хянах вэ, хэн

батлах вэ гэдэг ажил үүргийн хуваарь Монгол Улсын Үндсэн хуульд заачихсан байж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал үр дүн гарахгүй байна гэвэл үр дүнг хэнээс шаардах вэ? Гүйцэтгэх эрх мэдлээ шаардах ёстой. Их Хурлын гишүүн та өөрөө тэр албан тушаалтнуудаас шаардах ёстой, араас нь явах ёстой. Тэгэхэд энэ хууль чинь туслах гээд байгаа байхгүй юу. Түүнээс микрофоны ард энэ үр дүн хаана байна вэ гэж. Үгүй таныг тэр үр дүнг гаргуулахын тулд, энэ үр дүнгийн араас явахын тулд хууль санаачил, баталсан хуулийнхаа араас яв, шаард, шах, ажил гэж тэр сонгогчид, иргэд үүрэг даалгавар өгөөд суулгасан байхгүй юу. Яг Засгийн газраас асууж байгаа бол тэр механизмаар ажиллах ёстой.

Тэгэхээр яг одоогийн энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн энэ гол юм бол энэ механизмыг яаж зүгшрүүлэх вэ гэж. Хуулийн тодорхой заалтууд зөв, буруу байх асуудал нэг асуудал. Энийг засаж янзалж болно. Хамгийн монголын ер нь ингээд хамгийн том фэйлддэг /fail/ бүтэлгүйтдэг энэ бүтэлгүйтэл бол би сая сайдаар жил гаран ажиллаж үзэхэд, харахад ерөөсөө боловсон хүчний л хомсдол байна шүү дээ бүх шатад. Гүйцэтгэл байхгүй. Одоо нэг үеэ бодвол бид нар шийдвэр гаргах чадамж сайжирчихсан. Бодлогоо тодорхойлох чадамж сайжирч байна. Одоо араас нь гүйцэтгэл, гүйцэтгэлийн хяналт гэдэг асуудал гарч ирчхээд байгаа байхгүй юу. Урьд нь их ярьдаг байсан бид нар гүйцэтгэлийн сахилга гэж ярьдаг байсан байхгүй юу. Хуучин би захиргааны эрх зүйн хичээл дээр тэгж заадаг байсан.

Тэгэхээр одоо энэ Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль чинь Их Хурал хянан шалгах гээд давхиад байгаа биш, хуулийн гүйцэтгэлийг яаж бүрэн хангуулах вэ гэдэг тэр шахдаг, шаарддаг, хянадаг механизмаа сайжруулж байгаа юм. Энэ тохиолдолд мэдээж хэрэг тэр энэ Улсын Их Хурал чинь өөрөө ард

түмний индэр. Тийм учраас энэ дээр бол мэтгэлцээн гарна, тэр попроно гэж ярина уу тэр янз бүрийн байдлаар алдаа зөрчил гарна уу гарна.

Гэхдээ энэ чинь нээлттэй, ил тод, бусдад харагдаж байгаа байхгүй юу даа. Энд ажлаа олигтой хийхгүй байна ч гэдэг юм уу, эсвэл санал шүүмжлэл гэдэг энэ парламент чинь өөрөө индэр. Ярилцдаг, мэтгэлцдэг, хэлэлцдэг. Тэгэхээр парламентын Хянан шалгалтын тухай хууль бол парламентын хянан шалгах буюу цаад гол юм нь парламент дээрээ мэтгэлцдэг, энэ дээр хянан шалгадаг энэ юмыг төгөлдөржүүлэхэд чиглэж байгаа юм. Энэ дээр эхний үе шатын ажил дөнгөж хийгдээд бид 2 жилийн нүүр үзэж байна. 2 жилийн хугацаа. Хугацаа хэрэгтэй байна, гишүүд өөрсдөө сурч боловсрох хэрэгтэй байна. Олон нийт бас энэ дээр асуудлаа энэ механизмаар дамжуулж ажиллаж сурах хэрэгтэй байна.

Цаашидаа энэ Хөгжлийн банкнаас сургамж авсан шүү дээ хүмүүс. Авсан зээлээ хамаагүй олон дансаар гаргаад явуулчхаж болдоггүй юм байна, өөр зорилгод зарцуулж болдоггүй юм байна. Энэ хэрэггүй болоогүй шүү дээ. Сургамж болсон шүү дээ. Энэ үр дүн гарч байгаа шүү дээ. Хуулийн байгууллагуудаас шаардаж байна. Удаашираад байгаа гэж байна. Шийдээд явж байна. Тэн дотроос сугарч үлдээд байгаа гэж шүүмжлэл гарч байна. Үгүй энэ чинь энэ хуулийн чинь үр дүнгээр тэр энийг чинь үнэлэх бололцоотой болж байгаа байхгүй юу. Урьд нь энийг чинь тодорхой ярьдаг механизм ч байхгүй байсан байхгүй юу даа бас. Энэ утгаараа би энэ Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг хууль шүүмжилж байна гэж үгүйсгэх, хуулийг эрх зүйгүй нэг ойлголт лигист үзэл гэж байдаг. Үгүйсгэх. Хууль засагладаг больё гэж байвал хуулийг муу хэлээд бол явдаггүй. Хууль биелүүлж байгаа тэр амьд хүмүүс байгаа шүү дээ. Чимэд багшийн нэг үгийг би эцэст нь, төгсгөлд нь хэлье. Хууль хэрэгжүүлнэ гэж ярьдаг

чинь буруу шүү. Хуулийг биелүүлнэ гэж ярих ёстой. Хууль хэрэгжүүлнэ гэж үг Үндсэн хуульд байхгүй тэгж ярих юм бол. Хууль биелүүлнэ гэдэг чинь юу вэ гэхээр хэг хууль өөрөө өнхөрч хэрэгждэггүй. Энийг хэн нэгэн этгээд хэрэгжүүлдэг, биелүүлдэг, гүйцэтгэдэг тэрийг.

Тэгэхээр хууль хэрэгжсэнгүй гэж ярих биш, хуулийг биелүүлдэг болгохын тулд л Их Хурлын гишүүн сууж байгаа. Хуулийг тогтоогоод араас нь явдаг энэ механизмууд чинь бий болоод ирэхээр аяндаа энэ шүүмжлээд байгаа манай бусад гишүүд ч гэсэн өөрсдөө ажлын чинь орчныг сайжруулж байгаа учраас та өөрөө үүнийхээ араас явдаг, үр дүн хаана байна биш, үр дүн гарах ёстой гээд та тэд дунд нь явдаг байх энэ чиглэлд энэ хууль чинь л явж.../минут дуусав./

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Манай гишүүд Хяналт шалгалтын тухай хуулийн талаар дэмжсэн хоёр, дэмжээгүй нэг гишүүн үг хэлсэн. Адьшаа гишүүн дэмжээгүй үг хэлсэн.

Энэ хяналт шалгалтын нээлттэй сонсголын Улсын Их Хурлын хяналт шалгалтын шинэ механизм бол энэ парламентын бидний бас түүхэн ажил гэж хэлж болно. Энэ хяналт шалгалтын механизм ажиллаж эхэлснээрээ олон жил бугшсан, дарагдсан мэдэгдэхгүй байсан юмнууд ил тод болсон.

Тэгэхээр ерөөсөө парламентын гурван үндсэн үүрэг байдаг. Хууль тогтоох, ард түмнийг төлөөлөх, гуравдугаарт нь тэр хуулийнхаа биелэлтийг хянан шалгах. Сая манай Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүний хэлснээр Үндсэн хуульд хуулийн биелэлтийг Засгийн газар хариуцна. Олон улсын парламентын холбооноос гаргасан зөвлөмжөөр ерөөсөө хуулийн биелэлтийг хангах, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хамгийн сайн механизм бол ил тод байдлыг хангаж, гүйцэтгэх засаглалд

хяналт тавих тэр мэдээллийн ил тод байдлыг бий болгож байгаа юм. Түүнээс энэ шүүх хурлын асуудал биш бөгөөд ил тод болгосноороо энэ ард түмний ардчиллын хяналтыг бий болгож байгаа механизм гэж үздэг.

Ийм учраас энэ парламентын хяналт шалгалтын гурван механизм байна л даа. Төсвийн хяналт. Баталсан төсвөө яаж хэрэгжүүлж вэ, ард түмний татварын мөнгийг яаж үр ашигтай зарцуулж уу, идэж ашиглаж уу гэдэг дээр хяналт тавих. Төсвийн хяналт.

Хоёрдугаарт нь хуулийн биелэлтийн хяналт.

Гуравдугаарт нь ард түмний төлөөллийн хяналт. Ард түмний төлөөллийн хяналтын хэлбэр нь л зөвхөн энэ нээлттэй сонсгол байгаа юм. Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хуулийн биелэлтийг хангах зорилгоор Мөрдөн хянан шалгах түр хороог цөөнхийн төлөөллийг оролцуулж байгуулж ажиллуулах энэ механизмыг бий болгосон. Энэ бол түүхэн ажил болсон. Мааш олон асуудал эхэлсэн.

Гэхдээ бас зарим гишүүний шүүмжилж байгаа шиг энэ нөгөө чөтгөр нь детальд нуугдаж байдаг учраас энэ сонсголын процесс ил тод байх. Зөвхөн даргын өнгө үзэмжээр шийдэгддэг биш, энэ Ганболд гишүүний хэлээд байгаа үзэмжээр биш Хяналт шалгалтын түр хорооныхоо хурлаар асуудлыг шийддэг, гэрч хяналтаа дууддаг, ингээд нарийн процессуудыг хуульчилж их тодорхой болгохгүй бол бас энэ маань буруу ашиглагдаж, хэрэглэгдэж болзошгүй тийм кэйс, тохиолдол байна гэж зарим гишүүд шүүмжлэлтэй ярьж байна. Ирээдүйд бас энэ буруу практик тогтоож болохгүй. Тийм учраас парламентын хяналтын механизм бол зайлшгүй чухал.

Үүнийг яагаад тогтоосон гэхээр зөвлөлдөх ардчилал, зөвлөлдөх санал асуулгаар ард түмэн энэ юм болохгүй байна гэдгийг мэдрээд, ерөөсөө ардын хянан шалгах хороог сэргээн байгуулъя гэж ийм санал, хүсэлт зөвлөлдөх ардчиллаар хэлсэн юм. Энийг орчин үеийн ардчилсан парламентын улсуудын нийтлэг жишигт байгаа энэ парламентын мөрдөн шалгах парламентын овер сайт /oversight/ буюу хяналт шалгалтын энэ механизмыг бий болгосон.

Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Тэгэхээр энийг хууль дээр анхаарах юм бол бас Америкийн сенат бол Говермент акаунтабилити оффис /Government Accountability Office/ гээд бүүр Төрийн хяналтын хариуцлагын газар гэж маш том орон тоотой алба энэ тусалж байгаа юм. Манайх чинь хяналт шинжээчдээ л дуудаад байдаг. Тэгтэл тэнд бүтэн хариуцлагын алба байгаа юм. Аудитын алба, АТГ, хамтарсан ийм бүтэц ажиллаж байгаа юм. Ийм л систем бий болж байж энэ авлигагүй шударга нийгмийг бүтээнэ.

Тэгэхээр ажлын эхлэл бол, сайн эхлэл бол ажлын хагас гэдэг. Ямар ч байсан авлигагүй, шударга нийгэм бий болгох эхлэлийг энэ ард түмний хяналт шалгалт дээр тулгуурласан нээлттэй сонсгол, ард түмний нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хяналт шалгалтын хороо байгуулдаг, Түр хороо байгуулдаг энэ механизм хэрэгжиж эхэлсэн. Энэ бол манай олон гишүүдийн ажлын үр дүн мөн. Алдаа оноо байгааг засаж залруулаад улам сайжруулаад явах ёстой.

Санал хураалт явуулах хэрэгтэй байна. Өдөр дуудсан ахиж л дууд. Хөөш энэ юугаа.

Одоо бас сая манайд Дашидондогийн Ганбат гишүүний хэлснээр Эмийн чанар, үнийн асуудлаарх

хяналт шалгалтын түр хорооны сонсгол ирэх нэг дэх өдөр манай Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын гишүүдийн Түр хороо ажлын хэсэг хэрэгжүүлнэ.

Дараа нь ногоон автобус, ашигт малтмалын лицензийн олголтын асуудлаар өнөөдөр ажлын хэсэг байгуулах асуудлыг хянан шалгалтын түр хороо байгуулах асуудлыг хэлэлцэнэ. Гадаа байхгүй бол дараагийн асуудалд орох уу?

Яг үнэн Дэгийн хуулиар бусад улс чинь гадаад харилцааны сайд байлаа гэхэд гадаад уулзалт хийж байхад чинь хонх дуугараад л за санал хураалт боллоо уучлаарай гээд л босоод, гүйгээд гараад явчихна. Өөрөөр хэлбэл, санал хураалт дээр ордон дээр хонх дуугараад л хүмүүс заавал ирж байдаг. Бусад үед хэлэлцүүлэг, мэтгэлцээний үед бол бусад ажлуудаа төлөөллийн ажлуудаа хийж байдаг. Одоо ингээд, тэгвэл одоо санал хураалтыг түр хойшлуулаад дараагийн асуудалд оръё. Нэг мөсөн орчихъё. 6 цаг хүртэл. Тэр хооронд бусад нь ороод ирэг. Дараагийнх нь удахгүй юм чинь. Дараагийнх чинь тэгсэн чинь юу билээ? Дараагийн асуудалд орно.

17.12 цаг

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 30 гишүүнээс 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 25 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс зарим талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг орон нутгийн саналыг харгалзахгүй олгосон нь соёлын өвд бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутагтай давхцасан ашигт малтмалын тухай тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар 3 удаа сунгуулах эрх зөрчигдсөн, холбогдох зарим албан тушаалтны хариуцлагагүй чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул зэргээс шалтгаалан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого бүрэн ороогүй зэргийг харгалзан Улсын Их Хурлаас хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг үндэслэн тогтоолын төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх ашигт малтмал хайх, тусгай зориулалтаар газар түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар

ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хянан шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах, тайланг Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог байгуулах нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэж, дээрх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ бас их чухал асуудал юм байгаа юм. Энэ Монгол Улсад ялангуяа энэ газрын асуудал, тэр дотроо энэ нийслэлд бол замбараагүй болсон. Тусгай хамгаалалттай газруудад замбараагүй болсон, лицензийн газрууд замбараагүй, ашигт малтмалын газрууд замбараагүй болсон. Тийм учраас асуудлын хувьд бол маш их чухал асуудал байгаа юм. Олон гишүүн энэ хуулийг төслийг санаачилсан байна. Би хоёр зүйл тодруулъя гэж бодож байна. Хууль санаачлагчаас.

Нэгдүгээрт нь бидний бүрэн эрхийн хугацаа 2 сар хүрэхгүй, 2 сар л байна. Энэ хугацаанд бид нар сонсгол хийж болох чадах уу? Сонсгол маань 5 сарын 15-наас өмнө хийх шаардлагатай болов уу гэж би бодож байна. 5 сарын 15-наас нэр дэвшилт гээд дараагийн процесс эхэлчээж байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэгдүгээрт нь цаг хугацааны хувьд 5 сарын 15-ндаа багтааж сонсгол хийж чадах уу? Тийм мэдээлэл цуглуулж амжих уу гэдэг асуудал байгаа юм.

Хоёрдугаар асуудал бид нар сонсгол хийгээд түрүүн ч бас яриад байна лээ гишүүд сонсгол хийгээд орхичхоод байгаа юм. Тэр сонсголын үр дүнгээр заавал Их Хурал Засгийн газарт чиглэл өгч, тодорхой хуулиудад өөрчлөлт оруулж баймаар байгаа юм. Би тухайлбал, энэ Ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулах ёстой гэж бодож байдаг хүн байхгүй байнга. Ашигт малтмал, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоходоо тухайн багийн Иргэдийн Хурлаас зөвшөөрөл авдаг л болчихвол ерөөсөө Монголд янз бүрийн замбараагүй юм байхгүй болчих байхгүй юу. Энийг ингээд цэгцэлчих ёстой гээд л хуулийн төсөл яриад байдаг. Энэ нь орж ирдэггүй юм байгаа юм.

Тэгэхээр ер нь энэ сонсгол хийсний дараа энэ чиглэлийн саналуудыг боловсруулах уу гэдэг ийм хоёр асуултыг би хууль санаачлагчаас асууя.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн асуултад хариулна.

Ц.Цэрэнпунцаг: Эхнийхийг нь Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Та хоёр дахь асуултаа дараа нь дахиад тодруулж асуугаад асуучхаарай. Би энд бас сонссонгүй өнгөрчихлөө.

Эхний асуултад цаг хугацаа нь давчуу байна, энд амжих юм уу гэж байна. Энэ ажлын хэсэг 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар гарсан ажлын хэсэг гарч ажилласан. Байнгын хороодын дарга нар орсон 9 гишүүнтэй ажлын хэсэг ажиллаж, эхний удирдамж батлагдаад энэ удирдамжаар бид нар энэ хянан шалгах үйл ажиллагаа явуулах цар хүрээгээ тогтоосон. Энэ дээр нэлээн ажилласан. Саяын таны дурдсан энэ нийт газар олголт, ашиглалттай

холбоотой энэ бүх ажлыг хамарч шалгана гэвэл үнэхээр нэг чуулганы хугацаа бас хүрэлцэхээргүй ийм нөхцөл байдал үүссэн учраас ер нь асуудлыг хоёр хувааж, хоёр Хянан шалгах түр хороо гаргаж ажиллая гэдэг дээр тогтоод, эхний хэсэг нь бол энэ газар олголт, ашиглалттай холбоотой Улаанбаатар, хот суурин газруудын газар олголтыг шалгая. Энийг тусад нь Хянан шалгах түр хороо байгуулъя.

Хоёр дахь нь энэ уул уурхайн ашиглалтын лицензтэй холбоотой, олголттой холбоотой, төлбөр, татвар ногдуулалттай холбоотой асуудлыг шалгах ийм хоёр Хянан шалгах түр хороо байгуулъя гээд энэ ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт дээр бол дурдсан.

Гурав дахь хэсэг нь бол энэ хянан шалгах үйл ажиллагаа явуулах шаардлагагүй бас тодорхой ажлууд байна. Энэ цар хүрээ хамарч байгаа энэ хоёр ажлын Хянан шалгах түр хорооны хянан шалгах үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд хамаарахгүй энэ бусад зүйлийг нь өнөөдрийн энэ явж байгаа хууль, эрх зүйн хүрээнд бол Засгийн газрын үйл ажиллагаагаа сайжруулах, цаашилаад хуулийг нь сайжруулах ийм нөхцөл байдал шаардлагатай бол Их Хурал руу оруулж ирэх чиглэл өгсөн Засгийн газар руугаа ийм тодорхой асуудлуудыг дурдаад ингээд ийм тогтоол гаргаж ажиллая гээд ийм гурван үндсэн ч чиглэлээр ажиллая гэдэг ийм санал, дүгнэлт гаргасан юм байгаа юм. Тэгтэл өнөөдөр Улаанбаатар хот дээр энэ газар олголттой холбоотой асуудлууд бас нэлээн яригдаад Улаанбаатар хотоос ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа юм байна лээ. Энэ дээр нь бас давхардуулж бид нар энд Хянан шалгах түр хороо байгуулах нь зохимжтой бус байна гэж үзээд эхний ээлжид энэ ашигт малтмалын лиценз олголт, үүний татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой энэ асуудлаар хянан шалгах үйл ажиллагаа явуулъя гээд цар хүрээг нь нэлээн сайн

тодорхой болгосон. Цар хүрээг энэ 4 зүйлээр тодорхойлсон юм байгаа юм. Хяналт шалгалтынхаа цар хүрээг

Нэгд, ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөө олгох үйл ажиллагаа.

Хоёрт, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бүртгэх үйл ажиллагаа.

Гуравд, тусгай зөвшөөрлөөр олгосон газар түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх.

Дөрөв. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ноогдуулах, тайлагнах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа гэсэн ийм цар хүрээнд хяналт шалгалтынхаа үйл ажиллагааг явуулъя гээд тусга.../минут дуусав./

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя. Яг тодорхой, тас тас тас гээд л хариулчхаач.

Г.Ганболд: Би бас энэ хууль санаачлагчийн нэг. Тийм учраас би гишүүдийг дэмжиж өгөөрэй гэж бодож байна энэ хуулийн төслийг. Хэдийгээр богинохон хугацаа байгаа ч гэсэн бид нар зайлшгүй хийх ёстой гэж үзэж байгаа. Хөдөө орон нутагт явж байхад энэ лиценз олголттой холбоотой иргэдийн зүгээс маш их гомдол, саналууд байна.

Тийм учраас ер нь хэдэн сая га газрыг хэдэн хүн лицензээр авсан юм? Хэн хэн байгааг нь ер нь бол нэг ил тод гаргах цаг болсон юм билээ. Хамгийн олон лиценз эзэмшиж байгаа хүн нь хэн юм? Тэгж байж энэ асуудлыг цэгцлэхгүй бол энэ сонгон шалгаруулалтын талбай нэртэй орон нутаг нь эсэргүүцээд байхад шууд дуудлага худалдаагаар олгочихдог асуудал их төвөгтэй байгаа юм. Ер нь лицензийг хоёр янзаар олгоод байгаа шүү

дээ. Нэг нь бол орон нутгаас санал аваад тэгээд дэмжсэн байвал олгодог, дэмжээгүй бол олгодоггүй.

Сонгон шалгаруулалтын талбай гэж энэ дуудлага худалдаагаар өгч байгаа лиценз бол орон нутаг бүх шатдаа эсэргүүцээд байхад шууд зарлачихдаг. Үүнээсээ болоод ерөөсөө иргэд төр засаг руу их дайрах дайралт, орон нутгийнхныг олгосон гэх байдал асар их байгаа учраас энийг бол яаралтай нэг талд нь гаргаад, бүүр болохгүй бол шалгалтын хүрээгээ жаахан хумиад, зөвхөн энэ сонгон шалгаруулалтын талбайгаар нь юм уу хуваагаад явсан ч ер нь болохгүй юм байхгүй юм байгаа юм.

Тийм учраас үүнийг би гишүүдийг дэмжиж, яаралтай Түр хороогоо байгуулаад, Түр хорооныхон ажилдаа ороод, болж өгвөл энэ чуулганы төгсгөл рүү бүүр нотлох баримтын сонсгол хийж амжихгүй бол Түр хороо байгуулаад энэ чинь заавал нотлох баримтын сонсгол хийнэ гэсэн үг биш шүү дээ. Түр хороо шууд тайлангаа тавьчихаж ч болно, сонсгол хийчхэж ч болно, эсвэл ерөнхий хяналтын сонсгол хийсэн ч болно. Тэгэхээр зэрэг аль нэгэн хэлбэрээр цаг хугацаагаа тооцоолж байгаад тэгээд шууд тайлангаа тавьсан ч болох учраас үүнийг ажиллуулж өгөх нь зүйтэй байх.

Тийм учраас гишүүдийг энэ хуулийг дэмжиж өгөөсэй гэж ингэж хүсэж байгаа юм.

Г.Занданшатар: Үг хэллээ. Асуулт биш. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Энэ ашигт малтмалын лиценз олголттой холбоотой асуудал бол туйлын замбараагүй болсон гэдэг нь үнэн. Орон нутгийн удирдлагууд огт дэмжээгүй, ИНХ нь дэмжээгүй олон мянган га талбайнууд л ашигт малтмалын хайгуулын лиценз нэртэйгээр орж ирдэг. Сумын дарга байж байхад

нэг өглөө нэг нөхөр орж ирээд л хэдэн зуун га газрыг хайгуулын лиценз манайх авсан юм гээд л ороод ирдэг. Амьдрал дээр харж байхад тэр лиценз авсан хүмүүс тэндээ хайгуул хийх ямар ч тийм санхүүгийн бололцоо, чадавх байхгүй. Тэрийгээ бариад гадна, дотнын нөхдүүдийг гуйж очдог. Тэгээд энэ хуулиараа энэ чинь гаднынхантай нийлж хайгуул хийгээд, тэндээс нь алт эрдэнэс гарч ирвэл талыг нь гаднын нөхдүүд авах ийм л зохицуулалттай юм байна лээ.

Тэгэхээр ер нь бол энэ ашигт малтмалын лицензтэй холбоотой асуудал дээр бид ер нь энэ шинэ хууль эд нар юмаа хурдхан шиг оруулж ирж, энэ нутаг орондоо эзэн болох энэ асуудлаа ярихгүй бол энэ чинь бас болохгүй байна шүү гэдгийг би нэгдүгээрт хэлмээр байгаа юм.

Би ганц нэг уурхайг бүүр тухайлан судалж үзсэн. Хэдэн жил тэгээд л тэнд ухааж байгаа, байгаль орчин сүйтгээж байгаа. 8-хан хүний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байгаа шүү дээ улсад. 8-хан хүний бүхэл бүтэн уурхай.

Дээрээс нь 100 гаранхан сая төгрөгийн татвар, машин унаа, эсэн бусын татвар нь нийлж байж тийм юм тушаасан байгаа юм. Тэгэхээр ийм мэтийн ийм хаана үр ашгаа өгөөд байгаа нь мэдэгдэхгүй ийм уурхайнуудыг ер нь цэгцэлж, хаахыг нь хааж ингэмээр байна. Одоо хүртэл Цэнхэр сум, Цэнхэрмандал сумын Хужхан бригад дээр яг голыг унуулаад л лиценз болгочихсон л байж байх жишээтэй. Ийм замбараагүй болсон.

Миний хувьд ийм замбараагүй 97 оноос хойш ингэж явж ирсэн асуудлыг ийм яаруу сандруу ярьж амжих болов уу, үгүй болов уу гэдэг дээр би эргэлзээ байна. Хагас хугас юм болох вий гэсэн эргэлзээ бол байна.

Харин сүүлийн үед энэ Баялгийн сангийн хууль орж ирсэнтэй

холбогдуулаад Монгол Улсын стратегийн 15 ордын 7 нь өнөөдөр ард түмний мэдэлд байгаа. Бусад нь өөр газар яваа гэдэг ийм айхтар юм байгаа шүү. Миний ойлгож байгаагаар Баялгийн сангийн хуулиараа энэ Монголын ард түмэн стратегийн ордуудаасаа ашиг хүртэж эхлэх ийм том хууль орж ирж байгаа юм билээ.

Харин үлдсэн 7, 8, талаас илүү нь хаашаа явчхав гэдэг дээр харин хяналтын сонсгол хийж энийг ер нь ухааж, гаргаж ирж энэ ард түмний өмчийг хэн нь авчхаад байгаа юм? Эндээс ард түмэн ер нь ашиг хүртэж чадах юм уу, чадахгүй юм уу? Эргэж Монголын төр энийгээ олж авч чадах юм уу, чадахгүй юм уу гэдгээ харин бүүр хянаж шалгах нь илүү оновчтой болох байх. Цаг хугацааны хувьд ч боломж гарах болов уу гэж би бол бодож байгаа юм.

Тэгэхээр ашигт малтмалын энэ салбар дээр ер нь том, жижиг гэхгүй энэ юмнуудаа ер нь нэлээн ул суурьтайгаар үзэж, харж ингэхгүй бол дэлгэсэн тэрлэг шиг нутаг гэдэг маань эзэнгүй юм шиг л ийм л болчихоод байгаа шүү. Орон нутаг ямар ч мэдэл байхгүй, багийн ИНХ эд нарыг бүүр тоох ч үгүй, сумын Засаг даргыг тоох ч үгүй, аймгийн даргыг тоох ч үгүй, аймгийн Иргэдийн Хурлыг тоох ч үгүй ийм байдлаар явж ирсэн.

Тэгэхээр би цаг хугацааны хувьд бас их яаруу давчуу байна. 30 жилийн замбараагүй юмыг судалбал энэ чинь амжих юм уу? Тэрний оронд харин томоохон ордуудаа хаа яваа вэ гэдгийг судлаад явбал яасан юм бэ гэсэн ийм л санал хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Санал маягтай байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Идэрбат гишүүн хамгийн гол нь цаг хугацаандаа амжих юм уу гэж байгаа юм байна. Энэ түүвэрчлээд том ордууд дээрээ үзэж

харвал яасан юм бэ гэж байгаа юм байна. Хамгийн гол нь лицензийг одоо төвлөрсөн байдлаар Уул уурхайн яам энэ Кадастраас олгодог учраас нэгдсэн зөвшөөрөлтэй. Ийм учраас энэ тоо, өнөөдөр тоо хэчнээн хайгуулын лицензтэй, хэчнээн ашиглалтын лицензтэй ийм бүх л тоо тодорхой байгаа шүү дээ.

Хамгийн гол нь бид нар ард, иргэддээ, нийтдээ энэ мэдээллээр хангах энэ чиглэлд бид нар өнөөдөр асуудал байдаг юм. Нэг талаасаа энэ дээрээсээ энэ зөвшөөрлүүд хууль ёсны дагуу олгогдоод явчихсан гээд явдаг. Доод талдаа иргэдээ газар дээрээ очихоор зэрэг орон нутгийн иргэд, баг, ингээд сумын Иргэдийн Хурал эд нар зөвшөөрлийг нь албан ёсоор авчихсан, зарим нь өгсөн, өгөөгүй, би гарын үсэг зурсан, зураагүй гээд л ийм асуудлууд гардаг шүү дээ. Тэгэхээр үүнийг л тодорхой болгоё гэж бас зорьж байгаа юм. Ер нь иргэд мэдэх эрх нь байна.

Тэгтэл энэ асуудал яригдаад явахаар зэрэг энэ яг зөвшөөрөл өгөхөд бол энэ иргэдийн нийтийн хурал, багийн нийтийн хурал эд нар руу оруулах ёстой байдаг тэр процессыг гаргалгүй л иргэд дарга нар гарын үсэг зураад явуулчихаж гээд л энэ иргэд маань их гомдол гаргадаг шүү дээ. Энэ дээр бид нар бас анхаарч ажиллая гэж бодож байгаа юм. Таны саяын анхааруулж яриад байгаа зүйлийг.

Тэгэхлээр аль альдаа, хэн нь, хаана буруу, зөрүү байна, хуурамчаар гарын үсэг зураад өгчихсөн байдаг юм уу, үнэхээр гарын үсгээ зураад иргэддээ тэр мэдээллээ өгөөгүй байдаг юм уу гэдэг асуудал хүртэл энэ дээр гарч ирэх учраас бол бид нар нийт энэ ингээж цоолдож том бизнесээ хийгээд явуулж байгаа энэ том уул уурхай дээрээ очоод энэ бас асуудал үүсгээд ярихыг бол хүсэхгүй байгаа.

Ер нь нийтэд нь жигд энэ бүх лиценз олголттой холбоотой, энэ хууль

ёсны дагуу явагдсан юм уу, үгүй юү? Энэ лицензийн мэдээж энэ цаад эзэд бас ямар эзэд байгаа юм бэ гэдгийг бас ард иргэд мэдэх хүсэлтэй байдаг. Та бүхэн мэдэж байгаа. Энэ ялангуяа өнөөдөр бас бид нар энэ бас дэмжээд явуулсан 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын хуулиас хасагдаж байгаа газрын газартай холбоотой зүйл, заалт бол яагаад энэ газрынхаа хуультай зөрчилдөөд байгаа юм бэ энэ Хөрөнгө оруулалтын хууль нь гэхээр тэр зүйл, заалтаас болоод өнөөдөр энэ Монгол Улсад бүртгэгдсэн Монгол Улсын хуулийн этгээд, энэ аж ахуйн нэгжүүд, цаад талын эзэд нь мэдэгдэхгүй учраас өнөөдөр энэ бас ард иргэд эргэлзээ төрүүлсэн, энэ гадаадын хөрөнгө оруулалт цаана нь байна уу, үгүй юү гэдэг ийм хардалт төрдөг. Энэ нь тодорхой бус ийм байдал байдаг учраас энэ дээр энэ дээр бид нар бас тодорхой анхаарлаа тавьж ажиллая гэж байгаа.

Өнөөдрийн тэр бид нарын дэмжиж явуулсан Хөрөнгө оруулалтын хуульд оруулсан өөрчлөлттэй ч гэсэн энэ холбоотой. Баялгийн сангийн хууль бид нар Засгийн газраас өргөн барьсан. Ингээд ажлын хэсэг байгуулагдсан энэ Их Хурал дээр хэлэлцэгдэж явж байна.

Тэгэхлээр энэ баялгийн сангийн хууль хэлэлцэхтэй холбоотой бид нар энэ Монгол Улс ер нь бас ямар хэмжээний баялагтай юм, ямар хэмжээний нөөцтэй юм, аль нь хайгуулын түвшинд яваа юм, аль нь ашиглалтын түвшинд яваа юм, ашиглалтын түвшинд яваа бол ямар хэмжээ, нөөц, баялаг маань ямархуу хэмжээтэй юм бэ гэдэг нь энийг бас тодорхой болгох энэ бас ийм зорилго энэ цаана нь байгаа гэж танд хэлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Маргааши өглөө хуулийн төсөл эцэслэн батална. Хуулиа бас батална. Үг хэлээд дуусчихлаа. Үгүй ээ энэ чинь тогтоолын төсөл. Асуулт, санал нэг явчихсан.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөснийг мэдэгдье. Маргааш өглөө.

17.33 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*